ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2018 ОНЫ 4-Р САР

Лиахона

Бид Христийн амилсны баярын ням гарагт юу тэмдэглэдэг вэ? 12-р хуудас

Их Эзэний хаант улсыг байгуулахад техник технологийг ашиглах нь, 18-р хуудас

Иосефт зориулсан нэгэн ажил Бурханд байв, 26-р хуудас

Исламын шашны түүх, сургаалыг ойлгох нь, 32-р хуудас

АРИУН СҮМ ДЭХ СҮСЭГ БИШРЭЛ, ӨВӨГ ДЭЭДСИЙНХЭЭ ТӨЛӨӨ ХИЙДЭГ ҮЙЛЧЛЭЛ . . . ГЭРЭЭНИЙ ЗАМ ДЭЭРЭЭ ҮЛДЭХ ГЭСЭН ТА НАРЫН ХҮСЛИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛНЭ.

ЕРӨНХИЙЛӨГЧ РАССЭЛЛ М.НЭЛСОН

Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг, 4-р хуудас

Лиахона, 2018 оны 4-р сар

ЗАХИАС

4 **Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Биднийг хамтдаа урагшлахад**
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ

12 **Аврагчийн эцсийн бөгөөд ганцаараа хийсэн аялал**
Шакэлл Ворддлэй
Энэ жилийн Христийн амилсны баяраар Аврагчийн цагаатгагч золиослолын өөр өөр талууд хэрхэн таны амьдралын аялалд нөлөөлдөг талаар бодно уу.

18 **Аврагчийн тухай мэдлэгээ хуваалцацгаая**
Ахлагч Гари И.Стивэнсэн
Бид сүүлийн үеийн техник технологийн хөгжил, дэвшлийн ачаар, урьд өмнө хэзээ ч байгаагүй олон арга замаар Есүс Христийн тухай хуваалцах боломжтой болсон.

26 ***Гэгээнтнүүд:* Сүмийн түүх—3-р бүлэг: Алтан ялтас**
Тэнгэр элч Моронайг Иосеф Смит дээр айлчлан ирсний дараа Иосеф Смит алтан ялтаснуудыг анх удаа харсан.

32 **Исламын шашныг ойлгох нь**
Даниел Петерсон
Дэлхийн хоёр дахь том шашны товч түүх болон гол сургаалуудаас

БУСАД ӨГҮҮЛЭЛ

8 **Индэр дээр: Сагс ба шилэн сав**
Чиэко Н.Оказаки

10 **Сайн мэдээний сонгодог бүтээл: Тэр нэгэн цэлмэг ням гаргийн өглөө**
Ахлагч Жозеф Б.Вөртлин

40 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**

44 **Итгэлийн хөрөг: Ракотомалала Алфонс**

80 **Биднийг дахин уулзах хүртэл: Амилалтын бодит байдал**
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

ХАВТСАН ДЭЭР
Зураг чимэглэлийг Жон Макноотон

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



46 **Жинхэнэ аз жаргалд хүргэх зам**
Ахлагч Үлиссэс Соарэс
Есүс Христийн сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарснаар жинхэнэ, үүрдийн аз жаргалыг олж авах боломжтой.

50 **Гэрлэлт, мөнгө, итгэл**
Сандэй Чибуйкэ Обаси
Миний сүйт бүсгүй, бид хоёрт хуримандаа бэлтгэх хангалттай мөнгө байгаагүй тул итгэлээ сорьсон юм.

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Чи өвөө эмээгээсээ ямар сургамжтай зүйл мэдэж авсан бэ?

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

52 **Асуулт, хариулт**
Би итгэлээ дахин олж авахын тулд юу хийж болох вэ? Яагаад Бурхан дайныг хүлээн зөвшөөрдөг вэ?

54 **Залбирал: Гэрчлэл ба сэргээлтийн түлхүүр**
Ахлагч Робэрт Д.Хэйлс
Иосеф Смитийн амьдрал нь гэрчлэл хөгжүүлэх анхны алхам бол залбирал гэж заадаг.

58 **Юу, яагаад, хэрхэн: Сэргээлтийг задлан шинжлэхүй**
Фэйт Садерлин Блакхөрст
Эрин үе, урвалт, сэргээлт зэрэг нь хоорондоо хэрхэн холбогддог вэ?

62 **Аврагчийг таньж мэдэх нь**
Сара Хэнсон
Бид Есүс Христийн талаар сурч мэдэхэд судруудыг ашигласнаар илүү их амар амгалан болон зорилгыг мэдрэх болно.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

66 **Сэргээлт миний хувьд ямар учир утгатай вэ?**
Энэ ижилсүүлдэг тоглоомыг ашиглан өнөөдрийн өөрийн амьдралд нөлөөлдөг Сүмийн түүхийн үйл явдлуудын талаар суралцаарай.

68 **Төлөвлөгчид Христийн талаар гэрчилж байна**
Ахлагч Дэвид А.Бэднар

69 **Гайхалтай сургамж**
Ахлагч Валэри В.Кордон

70 **Абуэлогийн гутал засварын газар**
Рэй Голдрап
Муу сонголт хийснээ наманчлах хамгийн тохиромжтой цаг бол яг одоо юм.

72 **Гэрлээ гэрэлтүүл: Нинжин сэтгэлтэй бай**
Клаудиа хэрхэн бусдыг өмгөөлж хамгаалан, тэдэнд нинжин сэтгэлээр ханддагаа хуваалцсан.

74 **Төөрөөд, олдсон нь**
Кэл С.
Би ойд төөрсөн боловч залбирах юм бол Бурхан надад тусална гэдгийг мэдэж байсан.

75 **Бидний хуудас**

76 **Судрын түүх: Иосеф Египет рүү худалдагдсан нь**
Ким Вэбб Рэйд

79 **Будах хуудас: Есүс Христ “Ирээд, Намайг дага” гэж хэлсэн**

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Liahona.lds.org гэсэн хаягаар өгүүллүүдийг уншиж мөн өөрийнхөө түүхийг явуулна уу.

Сүнслэг өдөөлт бүхий захиасуудыг (англи, португаль, испани хэлээр) **facebook.com/liahona** хаягаар орж олон, бусадтай хуваалцана уу.

Санал хүсэлтээ **liahona@ldschurch.org** хаягаар илгээнэ үү.

Store.lds.org-оор орж захиална уу. Аль эсвэл хангамжийн төв дээр очин, тойргийн удирдагчаасаа асууж лавлан, 1-800-537-5971 (Америкийн Нэгдсэн Улс болон Канадад) дугаараар холбогдоно уу.

© GETTY IMAGES-ИЙН ШИЛТГЭЭ ЗУРАГ

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Аз жаргал, *46*
Амилуулалт, амилалт, *10, 12, 80*
Аравны нэг, *66, 69*
Ариун Сүнс, *8, 42, 52, 66, 72*
Ариун сүм, *40, 75*
Баптисм, *75*
Гэрлэлт, *50*
Гэрчлэл, *12, 62*
Гэрээнүүд, *4*
Дайн, *52*
Есүс Христ, *10, 12, 18, 62, 66, 68, 79, 80*
Залбирал, *26, 52, 54, 74*
Золиослол, *12, 44*
Иосеф Смит, *26, 54, 58, 66*
Итгэл, *46, 50, 52, 68*
Мормоны Ном, *26, 54, 66*
Наманчлал, *70*
Нинжин сэтгэл, *72*
Сошиал медиа, *18*
Судрууд, *41, 52, 62, 76*
Сэргээлт, *26, 54, 58, 66*
Сүмийн удирдагчид, *4*
Сүмийн түүх, *26, 54, 66*
Сүнслэг нөлөө, *40, 42*
Технологи, *18*
Тэнгэрлэг Эцэг, *12, 46, 52, 66, 74, 80*
Урвалт, *54, 58*
Үлгэр жишээ, *72, 76*
Үхэл, *10, 12, 26, 43, 80*
Христийн амилсны баяр, *10, 12, 80*
Цагаатгал, *10, 12, 80*
Шашин, *32*
Шударга зан, *70*

2018 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР, 19, №2
ЛИАХОНА 14750 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Хюго И.Мартинэз
Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрол Ф.Макконки
Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Бонни Х.Кордон, Бага Лигранд Р.Куртис, Эдуард Дюб, Шэрон Юбанк, Доналд Л.Холлструм, Даглас Д.Холмэс, Эрих В.Көпишкэ

Удирдах захирал: Ричард И.Хийтон
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Хэвлэлийн туслах: Фрэнсиска Олсон
Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мардок, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Сэлү, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, Брэд Тиэри, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрэк Ричардсон
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис
Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Бэркир

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс *Лиахона* сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа (мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал хувилан авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
April 2018 Vol. 19 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

Биднийг хамтдаа урагшлахад

Хянан найруулагчийн тайлбар: Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон 2018 оны 1-р сарын 14-нд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн 17 дахь ерөнхийлөгчөөр томилогдсон бөгөөд 2018 оны 1-р сарын 16-нд Солт Лэйкийн ариун сүмийн өргөтгөлийн байрнаас шууд дамжуулсан нэвтрүүлгээр энэ үгийг хэлсэн юм. Тэрээр өөрийн хэлсэн үгийг энэ дугаарт нийтлэхийг хүссэн.

Хайрт ах, эгч нар аа, би энэ өглөө та нартай хамт байгаадаа зүрх сэтгэл минь даруусаж байна. Дөрвөн өдрийн өмнө бид агуу хүн болох Бурханы бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсонг амар тайван амьдралд нь үдсэн. Түүний амьдрал ямар агуу бөгөөд гайхамшигтай байсныг үгээр илэрхийлэх боломжгүй юм. Би түүний надад заасан зүйлд талархаж, өөрсдийн нөхөрлөлийг мөнхөд нандигнах болно. Одоо бид Их Эзэн Есүс Христэд, Түүний энэхүү сүмд бүрэн итгэх итгэлээр ирээдүйгээ харах хэрэгтэй.

Хоёр өдрийн өмнө одоо байгаа бүх амьд төлөөлөгч Солт Лэйкийн ариун сүмийн дээд өрөөнд уулзсан. Тэнд бид эхлээд Тэргүүн Зөвлөлийг дахин зохион байгуулахаар болж, намайг Сүмийн ерөнхийлөгчөөр үйлчлүүлэх шийдвэрийг санал нэгтэй гаргасан. Энэ эрин үед бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн санваарын бүх түлхүүрийг атгадаг ах нар маань миний толгой дээр гараа тавьж, намайг Сүмийн ерөнхийлөгчөөр томилон, онцгойлон адисалж байхад надад ямар санагдаж байсныг үгээр бүрэн илэрхийлэх аргагүй билээ. Энэ нь миний хувьд ариун нандин бөгөөд намайг даруусгасан тийм туршлага байсан.

Үүний дараа миний зөвлөх болгохоор Их Эзэний бэлдсэн хүмүүсийг ялган таних үүрэг хариуцлага над дээр ирсэн юм. Би өөрийн гүнээ хайрладаг үлдсэн арван хоёр төлөөлөгчөөс хэрхэн хоёрхон хүнийг сонгох вэ? Их Эзэн миний чин сэтгэлийн залбирлыг хариулсанд би гүнээ талархаж байна. Сүмийн ерөнхийлөгч Даллин Харрис Өүкс болон ерөнхийлөгч Хэнри Бэннион Айринг хоёр миний нэг, хоёрдугаар зөвлөхөөр надтай хамт үйлчлэх хүсэлтийг хүлээн авсанд би маш их талархаж байна. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгадаа үргэлжлүүлэн үйлчлэх болно. Тэрээр гагцхүү түүний хийж чадах томоохон ажил үүргүүдийг аль хэдийн хүлээн авсан байгаа.

Би түүнд болон ерөнхийлөгч Айрингт ерөнхийлөгч Монсоны зөвлөхүүдийн хувиар хийж гүйцэтгэсэн гайхалтай үйлчлэлд нь талархаж байгаагаа илэрхийлье. Тэд бүхий л талаараа чадвартай, үнэнч, сүнслэгээр өдөөгдсөн байсан. Бид тэдэнд маш их талархаж байна.

Тэргүүн Зөвлөлийн сар бүрийн захиас бичиг үүгээр дуусгавар болов

Энэ бол сэтгүүл дээр сар бүр хэвлэн гаргах Тэргүүн Зөвлөлийн хамгийн сүүлчийн захиас бичиг байх болно. Хойшид Тэргүүн Зөвлөл чухал захиасыг LDS.org гэх мэт Сүмийн төрөл бүрийн сувгаар дамжуулан шаардлагатай үед хуваалцаж байх болно.



Төлөөлөгчийн үйлчлэлийн өдөр бүр нь суралцах, цаашид ирэх олон үүрэг хариуцлагыг хүлээн авахад бэлдэх өдөр байдаг.

Одоо тэд хоёулаа өөр өөрийн хамгийн хэрэгтэй байгаа тэр газраа үйлчилж байгаа.

Түүнчлэн насны хувьд ахмадаасаа хоёрт ордог ерөнхийлөгч Өүкс Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч болж байгаа юм. Гэхдээ түүнийг Тэргүүн Зөвлөлд дуудсантай холбогдуулан мөн Сүмийн дэг жаягийн дагуу ерөнхийлөгч М.Рассэлл Баллард насны хувьд түүний дараа ордог тул, уг чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчээр үйлчилнэ. Тэргүүн Зөвлөл Их Эзэний хүслийг олж харан, Түүний ариун үйл хэргийг урагшлуулахад Арван хоёртой хамт мөр зэрэгцэн ажиллах болно.

Бид та нарын залбиралд талархдаг. Дэлхийн өнцөг булан бүрд бидний төлөө залбирч байсан. Ерөнхийлөгч Монсонг нас барсны дараах өглөө Бэнсон нэртэй 4 настай бяцхан хүү ийм нэгэн залбирлыг хийсэн байлаа. Эшлэлийг миний эхнэр Вэндийд бичсэн ээжийнх нь захидлаас авав. Бэнсон залбирахдаа: “Тэнгэрлэг Эцэг минь, ерөнхийлөгч Томас С.Монсонд эхнэртэйгээ дахин уулзах боломж олгосонд тань баярлалаа. Шинэ бошиглогчийн төлөө Танд баярлалаа. Түүнд зоригтой байж, шинэ бошиглогч болсондоо айхгүй байхад туслаарай. Түүнд эрүүл саруул, хүч чадалтай болж өсөж том болоход нь туслаарай. Түүнд санваар байгаа тул хүч чадалтай болоход нь туслаарай. Бас үргэлж эелдэг байхад минь туслаарай” гэжээ.

Түүн шиг ийм хүүхдүүдэд, зөв шударга байх өөрсдийн үүрэг хариуцлагад бууръ суурьтай хандаг эцэг эхчүүдэд мөн хүнд ачаа үүрч байгаа ч чин сэтгэлээсээ үйлчилдэг эцэг эх, багш, гишүүн бүрийн төлөө би Бурханд талархдаг. Өөрөөр хэлбэл, би та нарын хүн нэг бүрд гүнээ талархдаг.

Их Эзэн залуур дээрээ байгаа

Бидний хамтдаа урагшлах энэ мөчид би та бүхнийг Их Эзэний

ЕРӨНХИЙЛӨГЧ НЭЛСОНЫ СОЛТ ЛЭЙК ТАБЕРНЭКЛД ҮГ ХЭЛЖ БАЙГАА ЗУРГИЙГ СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ.

Гэрээний зам дээрээ үлд. Та нар Аврагчийг дагах гэрээ байгуулж, уг гэрээгээ сахиснаар хүртэх боломжтой сүнслэг адислал, давуу эрхийн үүд хаалгыг нээх болно.

Өөрийн Сүмийг удирдан залдаг тэрхүү гайхалтай арга замын талаар тунгаан бодоосой хэмээн урьж байна. Сүмийн ерөнхийлөгч нас барахад түүний оронд хэн үйлчлэхээр дуудагдах талаар нууцалж далдлах зүйл огт байдаггүй. Үүнд сонгууль хийх, сонгуулийн зар сурталчилгаа явуулах шаардлагагүй. Зөвхөн Их Эзэний мутраар өгөгдсөн бөгөөд халаа залгамжлан авах тэнгэрлэг төлөвлөгөө чимээгүй ажилладаг.

Төлөөлөгчийн үйлчлэлийн өдөр бүр нь суралцах, цаашид ирэх олон үүрэг хариуцлагыг хүлээн авахад бэлдэх өдөр байдаг. Төлөөлөгчийн хувьд доод албан тушаалын суудлаас дээд албан тушаалд очихын тулд хэдэн арван жил үйлчилдэг. Тухайн хугацаанд тэрээр Сүмийн ажил хэрэг бүрийн талаар шууд эх сурвалжаас нь арвин туршлага хуримтлуулсан байдаг билээ. Тэр мөн дэлхий даяар үүрэг даалгавраа гүйцэтгэхээр байн байн явах хугацаандаа дэлхийн хүмүүстэй, тэдний түүх, соёл, хэлтэй сайтар танилцсан байдаг. Сүмийн удирдлагын халааг залгамжлан авах энэхүү үйл явц өвөрмөц юм. Би ийм үйл явцыг өөр хаанаас ч харж байгаагүй. Энэ бол Их Эзэний Сүм учраас бид үүнд гайхах хэрэггүй. Тэр хүмүүний арга замаар ажилладаггүй.

Би Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад өмнөх таван ерөнхийлөгчийн удирдлаган доор үйлчилж байсан. Би ерөнхийлөгч бүрийг илчлэлт хүлээн авч, уг илчлэлтэд хэрхэн хариулж байсныг харж байсан. Их Эзэн Өөрийн бошиглогчдод үргэлж зааварчилж, тэднийг сүнслэгээр өдөөж байсан төдийгүй цаашид ч мөн зааварчилж, сүнслэгээр өдөөсөөр байх болно. Их Эзэн залуур дээрээ байгаа. Бид Түүний ариун нэрийг дэлхий даяар гэрчлэх үүрэгтэй бөгөөд цаашид ч Түүний хүслийг үргэлжлүүлэн эрэлхийлж, дагах болно.

ЮТАГИЙН ЖОРДАН РИВЕР АРИУН СҮМИЙН ӨМНӨ ЗОГСОЖ БУЙ ЭМЭГТЭЙН ГЭРЭЛ ЗУРАГ БА КАЛИФОРНИЙН НЬЮПОРТ БИЙЧ АРИУН СҮМИЙН ӨМНӨ БУЙ СҮЙТ БҮСГҮЙ, ЗАЛУУ ХОЁРЫН ГЭРЭЛ ЗУРАГ

Гэрээний зам дээрээ үлд

Одоо би Сүмийн гишүүн бүрд гэрээний зам дээрээ үлд хэмээн хэлмээр байна. Та нар Аврагчийг дагах гэрээ байгуулж, уг гэрээгээ сахиснаар ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн болон хүүхэд бүр хүртэх боломжтой сүнслэг адислал, давуу эрхийн үүд хаалгыг нээх болно.

Шинэ ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд бид үүний тулд ажлаа эхлүүлэхийг хүсэж байна. Чухам энэ л шалтгааны учир бид ариун сүмээс та бүхэнтэй ярьж байна. Бидний хүн нэг бүрийн хүсэн хүлээж буй төгсгөл бол Их Эзэний өргөөнд хүч чадлын хишиг хүртэж, гэр бүлээрээ лацдан холбуулж, ариун сүмд хийсэн гэрээнүүддээ үнэнч байснаар Бурханы хамгийн агуу бэлэг болох мөнх амьдралыг хүлээн авах шаардлагыг хангах явдал юм. Ариун сүмийн ёслол, тэнд хийдэг таны гэрээнүүд амьдрал, гэрлэлт, гэр бүл болон дайсны дайралтыг сөрөн зогсох чадварыг тань хүчирхэгжүүлдэг түлхүүрүүд юм.

Ариун сүм дэх шүтлэг бишрэл, өвөг дээдсийнхээ төлөө хийдэг үйлчлэл тань та нарын хувийн илчлэлт, амар амгаланг өсгөн адисалж, гэрээний зам дээрээ үлдэх гэсэн та нарын хүслийг хүчирхэгжүүлнэ.

Хэрэв та нар замаасаа гарсан байгаа бол би та бүхнийг чин сэтгэлээсээ эргэн ирэхийг урьж байна. Та нарын асуудал, саад бэрхшээл ямар ч бай, та нарт зориулсан газар зөвхөн энд Их Эзэний Сүмд бий. Гэрээний зам дээр эргэн орохоор яг одоо та нарын хийх үйлдэл таныг төдийгүй хараахан төрөөгүй байгаа үр удмыг тань ч адислах болно. Бидний Тэнгэрлэг Эцэг үр хүүхдүүдээ нандигнан хайрладаг бөгөөд бидний хүн нэг бүрийг гэртээ, Өөр дээр нь эргэн ирээсэй хэмээн хүсдэг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн агуу зорилго бол бидний хүн нэг бүрийг гэртээ эргэн очиход туслах явдал юм.

Би та бүхнийг гүнээ хайрладаг гэдгээ илэрхийлье. Энэхүү хайр минь та нартайгаа хэдэн арван жил уулзалдаж, хамтдаа шүтэн бишрич, та нарт үйлчилснээр өсөн нэмэгдсэн билээ. Бидний тэнгэрлэг эрх мэдэл бол үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс болгонд очиж, Их Эзэний Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлдэхэд туслах явдал юм. Бид үүнийг Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр мөн Түүнийг удирдлагад байгаа гэдгийг мартахгүй байснаар хийнэ. Энэ бол Түүний ажил мөн Түүний Сүм. Бид Түүний үйлчлэгчид.

Би Мөнхийн Эцэг Бурхан, Түүний Хүү Есүс Христэд үнэнч гэдгээ тунхаглаж байна. Би Тэднийг мэддэг, хайрладаг бөгөөд Тэдэнд болон та нарт өөрийн эцсийн амьсгал хүртлээ үйлчилнэ гэдгээ амлаж байна. Есүс Христийн ариун нэрээр, амен. ■

САГС БА ШИЛЭН САВ

Чиэко Н.Оказаки

Энэхүү шинэ цувралд сүсэг бишрэлтэй эмэгтэйчүүдийн амьдрал болон захиасаас онцлон нийтлэх бөгөөд *At the Pulpit: 185 Years of Discourses by Latter-day Saint Women* (2017) номоос хэсэгчлэн авав.

Бурхан бидэнд олон бэлэг, өвөрмөц онцлог шинж, ялгарах зүйлийг өгсөн ч нэн чухал зүйл бол бид бие биенээ буюу бүгд Түүний хүүхдүүд гэдгийг мэддэг байх явдал юм.

Сүмийн гишүүдийн хувьд бидэнд тулгардаг сорилт бол бүгд бие биенээсээ суралцаж, хайрлаж, хамтдаа өсөж хөгжих явдал билээ.

Сайн мэдээний сургаалууд зайлшгүй шаардлагатай. Тэдгээр нь нэн чухал боловч сав баглаа нь өөр өөр байдаг. Сүмийн сургаал болон соёлын сав баглаа өөр хоорондоо ялгаатайг харуулах нэгэн энгийн жишээг би хуваалцмаар байна. Энд Ютагийн нэгэн гэрийн эзэгтэйн гэр бүлээ цасны улиралд хооллохын тулд бэлтгэсэн, шилэн савтай Ютагийн тоор жимс байна. Хавай дахь гэрийн эзэгтэй нар жимсийг шилэн саванд хадгалдаггүй. Тэд хэдэн өдөрт хүрэлцэх хангалттай жимс түүгээд, гэр бүлдээ зориулан яг ийм сагсанд хийн хадгалдаг. Энэ сагсанд жилийн турш жимс жимсгэнэ боловсорч байдаг уур амьсгалтай газарт гэр бүлээ хооллохын тулд Полинезийн гэрийн эзэгтэйн түүсэн . . . манго, гадил, хан боргоцой, папайя жимснүүд байгаа.

Сагс, шилэн сав хоёр нь өөр өөр хадгалах сав боловч дотор нь ижил зүйл буюу гэр бүлдээ зориулсан жимснүүд байдаг юм. Тэгвэл шилэн сав нь зөв, сагс нь буруу юм болов уу? Үгүй ээ, тэдгээр нь хоёулаа зөв. Тэдгээр нь тухайн соёл болон хүмүүсийн хэрэгцээнд тохирсон сав мөн бөгөөд дотор нь байх зүйл буюу жимсэндээ тохирсон сав юм.

Ингэхэд жимс нь юу вэ? Паул бидэнд: “Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал болон дөлгөөн зан [болон] өөрийгөө захирах байдал нь юм” [Галат 5:22–23] хэмээн хэлсэн. Халамжийн нийгэмлэгийн эгч дүүсийн харилцаа болон Санваарын чуулгын ахан дүүсийн харилцаанд, ариун ёслолоос хүртэхээр бишрэл хүндэтгэлтэйгээр цуглахад, Сүнсний үр жимс Халамжийн нийгэмлэг нь Тайпэйд эсвэл Тонгад, харин санваарын чуулга нь Монтанад эсвэл Мексикт, ариун ёслолын цуглаан нь Фижид эсвэл Филиппинд байхаас үл хамааран хайр, баяр хөөр, амар амгаланд биднийг нэгтгэдэг.

. . . Намайг Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлд дуудагдахад, ерөнхийлөгч [Гордон Б.] Хинкли надад “Та энэ ерөнхийлөгчийн зөвлөлд онцгой өвөрмөц зүйлийг авчирна. Таныг Нэгдсэн Улс, Канадын хилийн цаана

ЧИЭКО Н.ОКАЗАКИ ЭГЧИЙН ТУХАЙ

Чиэко Нишимура Оказаки (1926–2011) АНУ-ын Хавайд япон гаралтай Буддын шашинтан гэр бүлд өсжээ. Тэрээр 15 настай байхдаа Сүмд нэгдсэн байна.

Тухайн үед Оказаки эгч өөрийн үндэс угсаа, соёл зан заншлын байдал ямар нарийн түвэгтэй болохыг хүлээн зөвшөөрөхөд хүрчээ. Японы зэвсэгт хүчин Хавайн Сувдан эргийг бөмбөгдсөний дараа бусад хүн тэднийг хэрхэн үзэх бол гэдэгт санаа зовсон Оказаки эгч ээжтэйгээ хамт өөрсдөдөө байгаа японыг сануулсан бүх зүйлийг цуглуулж, шатаажээ. Гэвч тэр толинд хараад, “Би Японд хэзээ ч очиж байгаагүй. Би зүрх сэтгэлдээ япон хүн биш. Гэхдээ би өөрийнхөө хэн болохыг үгүйсгэж чадахгүй. Миний нүд, арьс, үс бол япон”[1] гэж бодов.

Оказаки эгч амьдралынхаа туршид арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй нүүр тулж байсан юм. Тэрээр Дэлхийн II дайны дараахан Нэгдсэн Улсад Японы эсрэг хандлага хүчтэй хэвээр байсан үед багшилж эхэлжээ. Хүүхдүүдээ түүний ангид суулгахаас гурван эх татгалзсан байна. Гэвч Оказаки эгч удалгүй тэднийг ятгаж, зөвшөөрүүлсэн юм.[2]

Оказаки эгч эмэгтэйчүүдийн туслах бүлгийн гурван зөвлөлд бүгдэд нь, эхлээд Залуу эмэгтэйчүүдэд, дараа нь Хүүхдийн хэсэгт, тэгээд Халамжийн нийгэмлэгт үйлчилж байсан анхны эмэгтэй байлаа.[3]

Энэхүү захиасыг 1996 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээрх түүний нэгдмэл бөгөөд өвөрмөц шинэ байдлын тухай хэлсэн үгээс хэсэгчлэн авав (цэг тэмдэг ба том үсгээр бичих дүрмээр стандартын дагуу болгосон).

байгаа хүмүүсийг төлөөлдөг нэгэн гэдгээр тань олон түмэн мэдэх болно. . . . Таныг тэд Сүм дэх нэгдмэл байдлыг төлөөлж байна л хэмээн харна" гэж зөвлөсөн билээ. Тэрээр надад хүмүүст хандан ярих үед хэл маань чөлөөтэй байх адислалыг өгсөн.[4]

. . . [Би өөр улс оронд очиж үг хэлэхдээ,] миний үгсийг Сүнс тэдний зүрх сэтгэлд хүргэж, "Сүнсний үр жимс" тэдний хайр, баяр баясгалан, итгэлийг надад авчирч байгааг мэдэрдэг. Би Сүнс биднийг нэг болгож байгааг мэдэрсэн.

Ах эгч нар аа, та нарын үр жимс тоор эсвэл папайя байна уу эсвэл та тэдгээрийг сагстай эсвэл шилэн савтай авчирсан уу гэдгээс үл хамааран тэдгээрийг хайраар өгч байгаад тань бид талархаж байна. Тэнгэр дэх Эцэг минь, бид нэгдмэл төдийгүй таных байгаасай[5] хэмээн би Аврагч, Есүс Христийн ариун нэрээр залбирч байна, амен. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Chieko N. Okazaki, *Lighten Up!* (1993), 7.
2. Okazaki, *Lighten Up!,* 48–50; Gregory A. Prince, "'There Is Always a Struggle': An Interview with Chieko N. Okazaki," *Dialogue: A Journal of Mormon Thought* 45, no. 1 (Spring 2012): 114–115-ийг үзнэ үү.
3. "Obituary: Okazaki, Chieko," *Deseret News,* Aug. 7, 2011.
4. Prince, "There Is Always a Struggle," 121-ийг үзнэ үү. 1990 онд Оказаки эгчийг дуудагдах үед Гордон Б.Хинкли Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх байжээ.
5. Сургаал ба Гэрээ 38:27-г үзнэ үү.

ОКАЗАКИ ЭГЧИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЭЛЖ, БУСАД ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

ТЭР НЭГЭН ЦЭЛМЭГ НЯМ ГАРГИЙН ӨГЛӨӨ

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Жозеф Б.Вөртлин (1917–2008)

Тэр өдөр Их Эзэн үхлийн хүлээсийг тайлан, амилсан юм. Тэрээр булшнаас бүх хүн төрөлхтний Аврагч болж алдар суутай босож ирсэн билээ.

Амилалт гэж сүнс болон бие махбод төгс байдалд эргэн нэгдэхийг хэлдэг болохыг бид мэднэ. . . .

Та үүнийг төсөөлж байна уу? Амьдралынхаа ид сайхан үед байсантай адилаар үүрд амьдрах ямар байхыг та төсөөлж байна уу? Хэзээ ч өвдөхгүй, хэзээ ч өвчин мэдрэхгүй, мөнх бус оршихуйд биднийг үргэлж хавчдаг зовлонд хэзээ ч дарамтлуулахгүй гээд төсөөлөөд үз дээ?

Амилалт нь Христийн шашинтны итгэл үнэмшлийн төвд байдаг. . . .

. . . Аврагч булшнаас босохдоо . . . өөр хэний ч хийж чадахгүй нэгэн зүйлийг хийсэн. Тэр зөвхөн Өөрийнхөө төлөө төдийгүй амьдарч байсан бүх зөвт болон хилэнцэт хүний төлөө үхлийн хүлээсийг тасдсан. . . .

. . . Тэрээр уг бэлгийг бүх хүнд хүртээлтэй болгосон билээ. Энэ гайхалтай сайн үйлээр Тэрээр хайртай нэгнээ алдсан хүмүүсийн бодгалийг үгүйрүүлэн хоосруулж, дотроос нь идэж сүйрүүлдэг уй гашууг зөөлрүүлсэн юм.

Би Христийг загалмай дээр цовдолсон тэр баасан гараг ямар аймшигтай байсан бол гэж боддог.

. . . Газар доргиж, харанхуй бүх газрыг нөмөрч, . . .

Түүний амийг авахаар эрэлхийлж байсан нүгэлт хүмүүс баясаж, . . .

тэр өдөр сүмийн хөшиг хоёр хэсэг болон цуу урагдсан.

Магдалын Мариа, Есүсийн эх Мариа хоёр хоёул уй гашуу, цөхрөлд автсан юм. . . . Тэдний хайрлан, хүндэтгэж явсан гайхалтай нэгэн эр загалмай дээр амьгүй болж, дүүжлэгдэн байв. . . .

Төлөөлөгчид ч их цочирдсон байлаа. Есүс буюу усны мандал дээгүүр алхалж, үхэгсдийг амилуулж байсан тэдний Аврагч ёсон бус хүмүүсийн гарт орсон байв. . . .

Энэ бол үгүйрүүлэн хоосруулж, дотроос нь идэж сүйрүүлдэг уй гашуугаар дүүрсэн баасан гараг байлаа. . . .

Энэ дэлхийн түүхийн эхэн үеэс хойших бүх өдрөөс хамгийн хар бараан өдөр нь тэр баасан гараг байсан хэмээн би боддог.

[Гэвч] найдлага тасраагүй. Ням гарагт Их Эзэн үхлийн хүлээсийг тайлан, амилсан юм. Тэрээр булшнаас босож, бүх хүн төрөлхтний Аврагч болж, алдар суутай ирсэн билээ.

Мэлмэрэх нулимсаар дүүрсэн байсан нүд агшин зуур хуурай болсон юм. Зовлон, уй гашуугийн залбирлыг шивнэн хэлэх амнаас магтаалын үгс гарч байв. Учир нь Есүс Христ, амьд Бурханы Хүү эдүгээ үхэл гэдэг бол зөвхөн нэгэн шинэ, гайхамшигтай туршлагын эхлэл гэдгийг нотлон . . . тэдний өмнө босож ирсэн байлаа.

Бидний хүн нэг бүрд өөрийн гэсэн баасан гараг буюу орчлон ертөнц тэр чигээрээ сүйрч, бидний

МАЙКЛ МАЛМ, *РАББУНИ*

амьдрал утга учиргүй мэт санагдах тийм өдрүүд байх болно. . . .

Гэвч би үхлийг ялан дийлсэн Есүс Христийн нэрээр та бүхэнд ням гараг ирэх болно гэдгийг гэрчилж байна. Биднийг уйтгар гунигт автан, харанхуйд байх үед ням гараг ирнэ.

. . . Биднийг уй гашууд автах эсэхээс үл хамааран ням гараг ирэх л болно. Энэ амьдралд эсвэл дараагийн амьдралд ням гараг ирнэ.

Би та бүхэнд Амилалт үлгэр домог биш гэдгийг гэрчилж байна. Түүнийг харсан хүмүүсийн хувийн гэрчлэл бидэнд бий. Иерусалимд болон Америк тивд амьдарч байсан мянга мянган хүн амилсан Аврагчийг гэрчилсэн байдаг. Тэд Түүний гар, хөл, хавирган дахь сорвинд гар хүрсэн. . . .

Амилалтын дараа шавь нар сэргэж, дэлхий даяар аялан, . . . Есүс бол Христ бөгөөд амьд Бурханы амилсан Хүү гэдгийг зоригтойгоор гэрчилж байлаа.

Тэдний дундаас олон хүн . . . амь насаа алдаж, амьсгал хураахдаа амилсан Христийг гэрчилж байсан.

Амилалт нь үүнийг гэрчилсэн хүмүүсийн амьдралыг орвонгоор нь эргүүлсэн юм. Энэ нь бидний амьдралыг өөрчлөхгүй гэж үү?

Бид бүгд булшнаас босох болно. . . .

Бид дэлхийн Аврагчийн амьдрал, мөнхийн золиослолын ачаар дотны хайртай хүмүүстэйгээ дахин учран золгоно.

. . . Тэр өдөр Мессиа бүхнийг ялан дийлсэн тул бид үүрд мөнх амьдарч чадна гэдэгтээ баясах болно.

Ариун сүмд хүлээн авдаг ариун нандин ёслолуудын ачаар энэ мөнх бус байдалд өнгөрүүлсэн асар богино амьдралыг орхин одох мөч бидний мөнхийн холбоосоор уяж холбосон харилцааг удаан салгаж чадахгүй.

Үхэл бол бидний оршихуйн төгсгөл биш гэдгийг би гэрчилж байна. . . .

Бид Тэнгэрлэг Эцэгийн хайрт хөвгүүд, охидын хувьд өөрсдөдөө ирсэн энэ үнэлж баршгүй бэлгүүдийг болон бүгд булшнаас алдар суud босож ирэх тэр цэлмэг нэгэн өдрийн амлалтыг ойлгон, талархаж амьдрах болтугай.

. . . Бидний баасан гараг хэр харанхуй бүрхэг байхаас үл хамааран ням гараг ирнэ. ■

2006 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

Аврагчийн эцсийн бөгөөд ганцаараа хийсэн аялал

Шакэлл Вордлэй
Сүмийн сэтгүүлүүд

Аврагч мөнх бус амьдралынхаа туршид, тухайлбал нялх байхдаа Бетлехемээс Египет улс руу хийсэн аялал, цөл дэх 40 өдрийн аялал, тохинуулах үеэрээ заах, эдгээх, адислахаар хот, тосгон, орон гэрүүдэд хийсэн аялал гэх мэт олон аялал хийсэн. Гэвч нэг л аяллыг Аврагч ганцаараа хийх ёстой байсан ба зөвхөн Тэр л тэсэж гарч чадах байв.

СИМОН ДЮВЕЙ, *АЙ ЭЦЭГ МИНЬ*

ЛУИ РОЙЕР, РЕЙКСМЮСЕУМ, ЭССЭ ХОМО

“Бид Христийн амилсны баярын ням гарагт дэлхийн түүхэн дэх хамгийн удаан хүсэн хүлээсэн агуу үйл явдлыг тэмдэглэдэг.

Энэ бол бүхнийг өөрчилсөн өдөр.

Энэ өдөр миний амьдралыг өөрчилсөн.

Та нарын амьдрал ч мөн адил өөрчлөгдсөн.

Мөн Бурханы бүх хүүхдийн хувь тавилан өөрчлөгдсөн билээ.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Ач ивээлийн бэлэг,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 95.

Зүйрлэхийн аргагүй зовлон шаналал

“Христийн Гетсеманийн цэцэрлэгт хийсэн зүйлийн бүрэн дүүрэн утга учрыг мөнх бус хүмүүний оюун ухаан ойлгож чадахгүй.

Түүний сүв бүрээс үлэмж их цус шүүрэн, Эцэгийнхээ оноосон гашуун аяганы шаарыг шавхан уусан билээ.

Тэр бие, сүнс аль алинаар, ямар ч хүн үхэлгүй тэсэн гарах боломжгүй тийм байдлаар зовж шаналсныг бид мэднэ.

Түүний зовлон шударга ёсны шаардлагыг хангаж, бидний ойлгохын аргагүй арга замаар наманчлагч хүмүүсийг өвдөлт болон нүглийн шийтгэлээс аварч, Түүний ариун нэрэнд итгэдэг хүмүүст нигүүлслийг боломжтой болгосныг бид мэднэ.

Өвдөлт, сэтгэл санааны тарчлалын хэмжээлшгүй ачаа дарамт нь Түүнийг дагжин чичрэхэд хүргэж, тэрхүү гашуун аяганаас уухгүй байж болохгүй гэж үү гэж бодохдоо Түүнийг элгээрээ газарт унасныг бид мэднэ.”

Elder Bruce R. McConkie (1915–85) of the Quorum of the Twelve Apostles, “The Purifying Power of Gethsemane,” *Ensign,* May 1985, 9.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Аврагч Цагаатгалыг хийх үеэрээ бүх төрлийн өвчин зовлонг амссан гэдгийг бид сайн ойлгодоггүй байж магадгүй юм. Тэрээр хугарсан яснаас авхуулаад хамгийн хүнд архаг өвчин гээд бие махбодын бүхий л өвчин зовлонг ойлгодог. Тэрээр сэтгэл гутрал, түгшүүр, донтолт, ганцаардал, уй гашуу гэх мэт сэтгэлийн өвчин зовлон ямар хар бараан байдгийг, хэчнээн их цөхрөлд хүргэдгийг мэдэрсэн. Түүнчлэн Тэр хүн төрөлхтний бүх гэм нүглийг Өөр дээрээ авсан учраас бүхий л сүнслэг шархыг мэдэрсэн билээ.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Бид сул дорой байдлаасаа болж, ‘Ийм хүнд ачааг хэн ч мэдэхгүй, хэн ч ойлгохгүй шүү дээ’ хэмээн дуу алдан хашгирч мэднэ. Харин Бурханы Хүү төгс мэддэг ба төгс ойлгодог, учир нь Тэрээр бидний хүн нэг бүрийн ачааг мэдэрч, үүрсэн юм” гэж заасан (“Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд,” *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 108).

Үүнийг хийж чадах Цорын Ганц Хүн нь Тэр байв

"Түүний хийсэн зүйлийг зөвхөн Бурхан л хийж чадна. Эцэгийн бие махбодыг авсан Төрсөн Ганц Хүүгийн хувьд Есүс Христ тэнгэрлэг шинж чанаруудыг өвлөн авсан. Тэр энэхүү юу юунаас илүү чухал, тэнгэрлэг үйл хэргийг гүйцэтгэж чадах мөнх бус байдалд төрсөн цорын ганц хүн байсан билээ. Энэ дэлхий дээр амьдарсан цорын ганц нүгэлгүй Хүний хувьд Тэрээр сүнслэг үхэлд хамааралгүй байв. Тэр Өөрийн бурханлаг байдлын улмаас бие махбодын үхлийг ялан дийлэх хүчтэй байсан. Иймээс Тэр бидний өөрсдөө хийж чадахгүй зүйлийг бидний төлөө хийсэн. Тэрээр үхлийн цэвдэг хүлээсийг тасчсан. Тэр мөн бидэнд Ариун Сүнсний бэлгийн эрхэм дээд, амарлингүй тайтгарлыг хүртэх боломжийг олгосон билээ.

President James E. Faust (1920–2007), Second Counselor in the First Presidency, "The Atonement: Our Greatest Hope," ***Лиахона,*** **2002 оны 1-р сар, 20.**

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Хүн бүрд мөнх амьдралыг өгөхийн тулд Аврагч Цагаатгалаараа дамжуулан үхлийн хүлээсийг тайлж, бид бүгдийг гэм нүглээс маань гэтэлгэсэн. Тэрээр ийм сүрдмээр, биелэгдэшгүй даалгаврыг биелүүлж чадах цорын ганц хүн байв. Аврагч үнэхээр боломжгүйг боломжтой болгож чаддаг гэдгийг мэдэх нь хүнд сорилт бэрхшээл тулгарах үед биднийг тайтгаруулдаг.

Тэр эргэж буцаагүй

“Калварийн толгой дээр өмнөөс нь юу ч хийж чадахгүй байгаа дагалдагчдынх нь нүдэн дээр, нэл шарх болсон Түүнийг загалмайд хадав. Түүнийг бүдүүлэг хэрцгийгээр доогլон тохуурхаж, хараан зүхэж байлаа. . . .

Тэр амьсгал хураах хүртлээ олон цаг зовсон юм. Түүний омголтсон уруулаас ‘Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая гэсэн үгс гараад тэр амьсгалаа хураасан юм.’ . . .

Сүүлчийн агшинд Эзэн эргэн буцаж болох байв. Гэвч Тэр тэгээгүй. Тэрээр бүх зүйлийг аврахын тулд бүх зүйлээс доогуур орсон юм. Түүний амьгүй болсон цогцсыг хүнээс гуйж авсан булшинд яаруу боловч эвтэйхэн аваачиж тавьжээ.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018), “Тэр амилсан!” *2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 98.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Аврагч тэсэхийн аргагүй өвдөлт, ганцаардал, цөхрөлөөс болж зовж шаналж байсан ч тэсвэрлэж, мөнх бус аяллаа сүр жавхлантайгаар, бүр Эцэгээсээ Өөрийг нь цовдолсон хүмүүсийг уучлахыг гуйсаар дуусгасан билээ. Түүний төгс үлгэр жишээний ачаар бид зовлон бэрхшээлтэй тулгарахдаа сүр жавхлантай байж, Түүний тусламжтайгаар бас эцсээ хүртэл тэвчиж чадна.

БЕРНАРДО КАВАЛЛИНО, *КАЛВАРИ РУУ ЯВСАН ЦУВАА*, ДҮРСЛЭХ УРЛАГИЙН КРАЙСЛЕР МУЗЕЙ

КАРЛ ХЭЙНРИХ БЛОХ, *ОРШУУЛГА*

Түүний амилалтыг гэрчлэх олон гэрч

"Би Шинэ Гэрээнд гардаг Аврагчийн амилсныг гэрчлэх гэрчүүд болох Петр, бусад төлөөлөгч, цэвэр ариун Магдалын Мариа болон бусад гэрчид итгэдэг. Би Мормоны Номонд гардаг Өгөөмөр нутаг дахь төлөөлөгч Нифайд болон цугласан олны гэрчлэлд итгэдэг. Мөн би Иосеф Смит, Сидней Ригдон хоёрын Түүний талаар өгсөн олон гэрчлэлийн дараа 'Тэр амьд бөлгөө! Учир нь бид түүнийг харсан' хэмээх энэхүү эцсийн эрин үеийн агуу гэрчлэлд итгэдэг. Бүхнийг харагч Түүний мэлмий дор би Назарын Есүс бол амилсан Гэтэлгэгч гэдгийг мөн Түүний амилалтын *үнэн бодит байдлын* бүх зүйлийг гэрчилж байна. Та нар мөн үүнтэй адил итгэл, тайтгарлыг олж авах болтугай."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон, "Есүс Христийн Амилалт," *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 135.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Хэдийгээр бид Гэтэлгэгчийн амилсан, төгс бие махбодыг харсан хүмүүсийн дунд байгаагүй ч өнөөдөр Түүний гэрч болон зогсож чадна. Биднийг хэзээ ч мөн хаана ч байсан бай, Тэрээр амьдралын маань төвд үргэлж байсаар байх болно. Бид бусдыг өрөвдөж хайрлан, үйлчилж, бүгдэд номхон даруу зан ааш, нинжин сэтгэл, хүндлэл үзүүлж, сайн мэдээний гэрчлэлээ хуваалцах болгондоо Есүс Христийн жинхэнэ гэрч болон зогсдог билээ.

Бид орь ганцаар алхах шаардлагагүй

"Христийн амилсны баярын үеэр мэдэрч болох гайхалтай тайтгарлуудын нэг нь Есүс цор ганцаараа тийм урт замыг туулсан учраас *бид* туулах шаардлагагүй болсон явдал юм. Түүний ганцаар хийсэн аялал нь бидэнд өөрсдийн богинохон замд Тэнгэр дэх Эцэгийн энэрэнгүй анхаарал халамж, биднийг хэзээ ч орхихгүй хайрт Хүүгийнх нь нөхөрлөл, Ариун Сүнсний төгс бэлэг, тэнгэр дэх тэнгэр элчүүд, хөшигний хоёр талд байх гэр бүлийн гишүүд, бошиглогч төлөөлөгч, багш, удирдагчид болон найз нөхдийг бидэнд авчирсан билээ. Есүс Христийн Цагаатгал болон Түүний сайн мэдээний Сэргээлтийн ачаар мөнх бус амьдралын аялалд дээр дурдсанаас гадна өөр олон хамтрагчийг бидэнд өгсөн. Хэдийгээр заримдаа бидэнд ганцаар мэт санагдах үе байдаг ч Калварийн толгод дээрээс биднийг хэзээ ч ганцаар, тусламжгүй үлдээхгүй гэсэн үнэнийг бүрээн дуугаар мэдэгдсэн болно. . . .

. . . Бид 'ямар ч цагт мөн бүх зүйлд мөн [өөрсдийн] байж болох хаана ч үхэлд хүртлээ' Есүс Христийн дэргэд зогсох болтугай. Учир нь Тэр үхэн үхтлээ цор ганцаар зогсож *байсан* ч ийнхүү итгэлтэйгээр бидний хажууд зогсож байсан юм."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, "Түүнтэй хамт хэн ч байсангүй," *2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 97–98.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Энэ жилийн Христийн амилсны баяраар Аврагчийн эцсийн бөгөөд ганцаараа хийсэн аяллыг дурсан сана. Тэр Өөртөө байсан бүхнийг золиосолсон болохоор та болон энэ дэлхий дээрх бүх хүн цэвэр ариун болж, мөнх амьдралтай байж чадах болсон. Түүний төгс жишээнээс суралц. Түүнийг бодол санаандаа болон зүрх сэтгэлдээ хадгал. Та хэзээ ч ганцаараа биш гэдгийг үргэлж сана. Тэр Өөрийн эцсийн аяллыг орь ганцаар хийсэн болохоор таныг орхихгүй. Таныг гэсэн Түүний хайр хэмжээлшгүй бөгөөд хувиршгүй. Мөн таныг аяллаа үргэлжлүүлэхэд Тэр танд амар амгалан, тайтгарал, найдварыг өгөхөд бэлэн байдаг. Түүний Цагаатгалын бэлэг үүрдийнх бөгөөд энэ нь танд өгөгдсөн. ■

Дээгүүр өнгөрөх баяр Христийн амилсны баярыг ойлгоход бидэнд хэрхэн тусалдаг болохыг **lds.org/go/41817**-оос үзнэ үү.

МАРК Р.ПЬЮ, *ЭМЭГТЭЙ, ЧИ ЮУНД УЙЛНА ВЭ?*
ГРЭГ ОЛСЭНЫ "*НАДТАЙ ХАМТ АЛХ*" ЗУРГААС АВАВ, ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Гари И.Стивэнсон

АВРАГЧИЙН ТУХАЙ МЭДЛЭГЭЭ хуваалцацгаая

Бидний захиас бол амар амгалангийн захиас бөгөөд та бүхэн түүнийг номлох элчүүд билээ. Та шинэ, сонирхолтой технологийн хэрэгслүүдээр дамжуулан номлож болно.

Бид бол хожмын үед байгуулагдсан Есүс Христийн Сүмийнхэн мөн. Их Эзэн Өөрийн эртний шавь нарт зааварчилсны адил бид хожмын өдрүүдэд "Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд [тунхаглах]" (Марк 16:15) үүрэг хүлээсэн.

Энэ номлол, захиас болон үүний ард буй эцсийн зорилгыг эртний бошиглогч Нифай: "Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглолуудынхаа дагуу бичдэг болой" (2 Нифай 25:26) хэмээн товч дүгнэсэн байдаг.

Мозая номноос бид Мормоны Номын эртний бошиглогч Бенжамин хаан хэрхэн бүх нутаг даяарх өөрийн хүмүүсийг ариун сүмийн талбайд цуглуулж, цамхаг босгуулж, тэдэнд заасан тухай уншдаг. Тэрээр заадаг байхдаа өнөө цаг үеийн талаар: "Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, нэгэн Аврагчийн талаарх мэдлэг бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ; *ХРИСТИЙН ДҮР ТӨРХ*, ХЕЙНРИХ ХОФМАНН



хүмүүс бүрийн дунд тархах тэр цаг ирэх болно" (Мозая 3:20) хэмээн бошиглосон байдаг.

"Аврагчийн тухай мэдлэг"

Гэр бүл дотроо нандигнаж мөн бусдад өгч болох хамгийн эрхэм бэлгүүдийн нэг бол "Аврагчийн тухай мэдлэг" буюу Есүс Христийн талаар мэддэг зүйл юм.

Цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн нээлттэй зэрэгцэн бүх хүн төрөлхтний гэгээрэл, технологийн дэвшлийн хурдацтай хөгжил ирсэн. Энэ нь үйлдвэрлэлийн эрин үе болон харилцаа холбооны хэрэгслүүдийг авчирч, Бенжамин хааны бошиглол биелэгдэх боломжтой болгосон.

Би Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүний хувьд "бүх дэлхийд Христийн нэрний" (С ба Г 107:23) тусгай гэрчээр дуудагдан, Олон нийттэй харилцах алба болон Харилцаа холбооны үйлчилгээний хороонд тодорхой үүрэг даалгавар гүйцэтгэж, бидэнд байгаа хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан "Аврагчийн тухай мэдлэг"-ийг дэлхий даяар түгээх гэсэн энэхүү бошиглолын биелэлтэд анхаардаг юм.

"Бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүрийн дунд"

Түүхээс харахад, сонин хэвлэлийн хөгжил дэвшил, радио телевизийн нээлт зэрэг нь Сэргээлтийн захиасыг дэлхий даяар тараах боломжтой болгосон. Бид үүний олон жишээг мэддэг ба заримыг нь тод санадаг.

Анхны үзэгдлээс хойш арван жилийн дотор, Сүм зохион байгуулагдахаас нэг сарын өмнө Мормоны Ном 5000 хувиар хэвлэгджээ. Тэр цагаас хойш 175 гаруй сая хувь хэвлэгдсэн байна.

Аль ч ням гаргийн өглөө та 5000 дахь удаагийн нэвтрүүлгээ хийх гэж байгаа *Хөгжимт өгүүлэмж* нэвтрүүлгийг сонсох юм уу үзэж болно. Анхны нэвтрүүлэг нь 1929 онд радиогоор шууд явагдсан юм. 1949 онд Ерөнхий чуулганыг телевизээр анх удаа шууд дамжуулжээ.

Сонирхолтой нь, 1966 онд ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) ирээдүйд болох зүйлсийн талаар: "Тийм их хүч нөлөөтэй илрээгүй нээлтүүд нь нэг бол хүмүүнийг адисална, эс бөгөөс сүйрүүлнэ. Тэдгээрийг удирдах нь хүмүүний гарт өгөгдсөн хамгийн агуу үүрэг хариуцлага байх болно. . . . Энэ цаг үе хэмжээлшгүй аюул, хэлж барамгүй боломжуудаар дүүрэн юм"[1] гэж ярьж эхэлсэн юм.

1974 онд ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) ирж буй өдрийн талаар үзсэн үзэгдлээ дүрслэхдээ: "Их Эзэн энэ дэлхийг олон . . . хиймэл дагуулаар адисалсан. Тэдгээр нь өндөрт, тэнгэрт байрлаж, дэлхийн гадаргуугийн өнцөг булан бүрд нэвтрүүлгийн дохиоллыг дамжуулж байна. . . . Эдгээр хиймэл дагуул бол дэлхий даяарх нэвтрүүлгийн ирээдүйд болох зүйлсийн зөвхөн эхлэл нь билээ. . . . Их Эзэн энгийн бидэнд төсөөлшгүй их ололт амжилт өгөхөөр тэсэн ядан байгаа гэдэгт би итгэдэг"[2] гэжээ.

Бид Бенжамин хаан, ерөнхийлөгч Маккэй болон ерөнхийлөгч Кимбаллын бошиглолууд нь интернэтийн хөгжлийн улмаас хөгжсөн өнөөгийн харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн технологийн хурдацтай дэвшилтэй зэрэгцэн яг таг биелж буйг амьдралынхаа хугацаанд гэрчилсээр байгаа мэт санагддаг.

Мөн Их Эзэний хаант улсыг дэлхий дээр байгуулахад эдгээр технологийг ашиглах

1830

*Мормоны Ном **5000** хувь хэвлэгджээ*

1850

1870

1890

Хөгжимт өгүүлэмж ***1929** онд эхэлсэн бөгөөд өдгөө **5000** дахь удаагийн нэвтрүүлэг нь гарах гэж байна.*

1950

1974

"Хиймэл дагуул нь дэлхий даяарх нэвтрүүлгийн ирээдүйд болох зүйлсийн зөвхөн эхлэл нь билээ. . . . Их Эзэн энгийн бидэнд төсөөлшгүй ололт амжилтыг өгөхөөр тэсэн ядан байгаа гэдэгт би итгэдэг."
—Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл

2010

*Өнөөдрийн байдлаар Мормоны Ном **175 САЯ** хувиар хэвлэгдэн гарчээ*

2030

тодорхой загвар байдаг. Би иим жишээнээс та бухэнтэй хуваалцмаар байна.

LDS.org болон Mormon.org

1996 онд Сүм албан ёсоор энэ вэбсайтыг зурвас илгээх болон харилцаа холбооны хэрэглүүр болгон хэрэглэж эхэлжээ. Түүнээс хойш Сүмийн захиалгаар 260 орчим вэбсайт хийгдсэн. Үүнд мөн Сүмийн гишүүд амьдардаг бараг бүх улс оронд, тухайн орон нутгийн хэл дээр ашиглаж болох вэбсайтууд багтдаг.

Эдгээр вэбсайтын талаар хоёр танил жишээг би хуваалцъя. Нэг дэх нь 1996 онд байгуулагдсан LDS.org вэбсайт бөгөөд өнөөдөр жилд 24 сая гаруй шинэ хүн, долоо хоног бүр дунджаар 1 сая гаруй хүн уг сайтад зочилдог. Олон гишүүн энэ сайтаас заах хөтөлбөр болон өнгөрсөн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг олж авдаг. Хоёр дахь нь Сүмийн гишүүн биш хөршүүд болон найз нөхдөдөө сайн мэдээг танилцуулах зорилготой Mormon.org вэбсайт юм. Уг сайт нь жилд 16 сая гаруй давхардаагүй хандалттай байдаг.

Зөөврийн хэрэгслийн аппликэйшн

Технологийн асар хурдацтай өөрчлөлтийг даган хөгжихөд тодорхой хэмжээний хичээл зүтгэл, нөөц баялаг хэрэгтэй болдог нь мэдээж. Ухаалаг утас зохион бүтээгдсэнтэй холбоотойгоор зөөврийн хэрэгсэл дэх асар их хэмжээний өгөгдлийг хянах, ашиглах боломж гарсан. Энэ өгөгдлүүдийн ихэнх нь зөөврийн хэрэгслийн аппликэйшн буюу “апп“ хэлбэрээр зохион байгуулагддаг. Сүмийн санхүүжүүлсэн хамгийн анхны апп 2007 онд гарсан.

“Аврагчийн тухай мэдлэгээ” түгээхэд зөөврийн хэрэгслийн аппликэйшнуудыг үр ашигтай хэрэглэсэн олон жишээ бидэнд бий. Та нар өөрсдөө амархан олоод мэдчихэж болох энэ олон аппликэйшны агуулгыг би дүрслэн ярихгүй. Гэхдээ та нарын мэдэж байж магадгүй хэдэн аппликэйшныг би энд дурдъя.

- Сайн мэдээний номын сан
- Мормон суваг
- ХҮГ хэрэгсэл
- ХҮГ хөгжим
- Гэр бүлийн мод

Эдгээрийг сая сая хэрэглэгч долоо хонog бүр хэдэн сая удаа ашигладаг.

Ухаалаг утас зохион бүтээгдсэнтэй холбоотойгоор зөөврийн хэрэгсэл дэх асар их хэмжээний өгөгдлийг хянах болон ашиглах боломж гарсан.

Сошиал медиа

Сошиал медиаг хувь хүн болон байгууллагуудад виртуал хамтлаг ба сүлжээнүүдээр дамжуулан мэдээлэл, санаа, бусад хэлбэрийн илэрхийлэмжийг үзэх, бүтээх, хуваалцах боломж олгодог компьютер удирдлагын технологи гэж тодорхойлдог.

Сүм “Аврагчийн тухай мэдлэг”-ийг түгээхийн тулд 2010 оны үеэс сошиал медиа хэрэглээний ач холбогдолтой ашиглалтыг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь хурдтай бөгөөд давшингүй тоон харилцаа холбооны хэлбэр бөгөөд өөрчлөлтийн хурдаараа бараг юутай ч зүйрлэшгүй юм.

Сошиал медианы харагдахуйц нэг шинж чанар бол аливаа хүн нэг платформыг мэддэг болоход юм уу ямар нэгэн хүндрэлгүй болж эхэлмэгц шинэлэг, томоохон, илт сонирхолтой эсвэл илүү сайн платформ гарч ирдэг явдал юм.

Сүмийн харилцаа холбооны хэрэгсэл болгон ашигладаг сошиал медиагийн таван платформын тухай би товч тайлбарлая.

1. Фэйсбүүк дэлхий даяар 2 тэрбум гаруй хэрэглэгчтэй. Энд хэрэглэгчид өөрсдийн онлайн найзуудын нийгмийн сүлжээг байгуулдаг.

2. Инстаграм бол зураг, видео бичлэгүүд дээр төвлөрсөн сошиал сайт юм.

3. Пинтерест нь яг л виртуал мэдээллийн самбартай адил. Энд самбарт “зүү” гэгдэх үзүүлэн зургуудыг хаддаг. Эдгээр зураг нь урам зориг өгөх үг хэллэгүүд эсвэл хүсэл эрмэлзэл бүхий зургууд байдаг.

4. Жиргээ нь “жиргэлт” гэж нэрлэдэг 280 тэмдэгт бүхий богино зурвасыг илгээх, унших

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

2016 оны 8 сард ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф өөрийн ач хүү Эрикт сайн мэдээний зарчмуудыг зааж буй видео бичлэгийг Инстаграм дээр тавьсан. Та нар хаана зааж байсныг нь тааварлаж чадах уу? Онгоцны кабинд зааж байсан!

боломжийг хэрэглэгчдэд олгодог нийгмийн сүлжээ юм.

5. Снаапчатад тэр даруй эсвэл 24 цагийн дотор алга болдог гэрэл зураг, богино хэмжээний видео бичлэгүүд тавигддаг.

Бид байгууллагын хувьд эдгээр сошиал медиа сайтуудыг хүчирхэг арга замаар ашигладаг юм.

ФЭЙСБҮҮК

Хэдэн жилийн өмнө Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд сэтгэл санааны хямралын талаар сүнслэгээр нөлөөлсөн захиас хуваалцсаныг та санаж байгаа байх.[3] Түүний энэ хэлсэн үгээр богино хэмжээний видео бичлэг хийсэн нь зөвхөн фэйсбүүк дээр гэхэд хүмүүс хоёр сая гаруй удаа үзэж, олон мянган лайк, шэйр буюу хуваалцсан, дэмжсэн саналуудыг хүлээн авсан байна.[4]

ИНСТАГРАМ

2016 оны 8-р сард ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф өөрийн ач хүү Эрикт сайн мэдээний зарчмуудыг зааж буй видео бичлэгээ Инстаграм дээр тавьсан. Та нар хаана зааж байсныг нь тааварлаж чадах уу? Онгоцны кабинд заасан.[5] Ерөнхийлөгч Угдорфын Инстаграм дахь постыг мянга мянган хүн үзэж сонирхон, олон зэрэг санал үлдээсэн.

Мөн 2017 оны 11-р сард Сүм өөрийн Инстаграм хаяг дээр, номлолд үйлчилж буй эгч нарын тухай асуусан залуу насанд хүрсэн эмэгтэйчүүдийн асуултад ахлагч Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард нарын хариулж буй видео бичлэгийг тавьсан юм. Яг энэ постыг хүмүүс 112000 гаруй удаа үзжээ.

ПИНТЕРЕСТ

Пинтерест дээр LDS.org-оос авч тавьсан болон гишүүдийн хувь хүнийхээ хувьд бусдыг сүнслэгээр урамшуулсан олон зуун мэдээллийг олж харж болно.

Тухайлбал, олон хүн өнгөрсөн эдүгээгийн бошиглогчдын үгсийг хуваалцдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсоны сургаалуудаас “Амьдралд өдий төдий зүйл бидний зан төлөвөөс шалтгаалдаг”[6] гэсэн нэгэн мэдээллийг оруулсан байдаг.

ЖИРГЭЭ

Өнгөрсөн жилийн Христийн амилсны баярын өглөө хийсэн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын жиргээг хүмүүс 210000 удаа үзжээ. “Тэр энд байхгүй. Учир нь тэр амилсан” (Матай 28:6) гэсэн богино бөгөөд энгийн захиас нь гүн гүнзгий, өнө удаан үргэлжлэх үр нөлөөтэй болохыг ахлагч Бэднар харуулсан юм.

СНААПЧАТ

Эцэст нь хэлэхэд, ерөнхийлөгч Монсоны Тэргүүн Зөвлөлийн нэг захиас бичгийн зураг болон үгс саяхан снаапчатад тавигдсан байна.

Эдгээрээс урган гарах эрсдэл

Эдгээр шинэ технологийн бүхий л давуу талыг магтаж, тэдгээрийн зохих хэрэглээг тайлбарласан болохоор одоо тэдгээртэй холбогдох зарим эрсдэлийн тухай ярих нь тустай гэж би бодож байна.

Сошиал медиад эсвэл зөөврийн хэрэгслийн аппликэйшнуудад зарцуулдаг цаг хугацааны талаар бид бүгд анхаарах ёстой. Сошиал медиаг ашиглах нь нүүр тулсан бодит харилцаа багасгах эрсдэлтэй бөгөөд энэ нь манай залуусын нийгмийн ур чадварын хөгжлийг бууруулах магадлалтай юм.

Зохисгүй агуулгатай холбоотой аюулыг ч онцлох нь зүйтэй. Нийгэмд порнографт донтох аюул нүүрлэж байгаа нь Сүмийн гишүүд, гэр бүлүүдэд сөргөөр нөлөөлж, зовоож байна.

Эцэст нь би шинээр гарч ирж буй өөр хоёр эрсдэлийг ярья. Эдгээр нь үндсэндээ хүн бүрд, ялангуяа залуу эмэгтэйчүүдэд болон мянганы ээж, эхнэрүүдэд нөлөөлж байна. Би энэ хоёр эрсдэлийг "үнэн бодит байдлыг хэтрүүлэх," "харьцуулснаас болж уруу дорой харагдуулах явдал" хэмээн нэрлэдэг. Эдгээр эрсдэлийг дүрслэх хамгийн сайн арга бол жишээ хэлэх явдал гэж би боддог.

Ерөнхийд нь хэлэхэд, сошиал медиад тавигддаг зургууд амьдралыг хамгийн сайхнаар, бүр ихэнхдээ бодит бус байдлаар харуулдаг. Тэдгээр нь гэрийн гайхалтай засал чимэглэл, аялал зугаалгын сайхан газар, уран нарийн чимэглэсэн хоол хүнсний зургаар дүүрэн байдаг. Аюул нь мэдээж хэрэг олон хүн энэ виртуал үнэн бодит байдлын хэтрүүлэгтэй адилгүй байгаадаа сэтгэлээр унадагт байгаа юм.

Зээ дүү минь Пинтерест дээрх төрсөн өдрийн "шарвингаар" хийсэн бялууны мэдээллээс санаа аван, яг адил зүйлийг хийснээ саяхан тавив. Тэрээр үүгээрээ зохисгүй дарамт хавчлага үүсгэхийн оронд өөрийн "Пинтерест бүтэлгүйтэл"-ийг (шарвингийн зургийг үзнэ үү) нийтэлж, бусдад сүнслэгээр нөлөөлөхөөр шийджээ.

Бид бодит байдлыг хэтрүүлсэн зураг хараад, үүнд илүү бодитой хандаж, хошигносон байдлаар хүлээн авч, урам хугарах мэдрэмжийг арай цөөн удаа мэдэрч сурах байх гэж найдаж байна. Мөн энэ нь ихэнхдээ харьцуулснаас болж өөрийгөө уруу дорой харагдуулахад хүргэдэг.

"Харин тэд өөрсдийгөө . . . хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг. Тэд ухаангүй ажээ" (2 Коринт 10:12) гэсэн Паулын үгээс харахад ийм харьцуулалт зөвхөн бидний энэ цаг үеийн тэмдэг биш бөгөөд өнгөрсөн цаг үед ч бас байсан аж.

Далын ахлагч Ж.Дэвн Корнишын хэлснээр "Бид өрсөлдөж, харьцуулснаар өөрсдийгөө дэмий шаналган зовоодог. Бид өөрсдийн үнэ цэнийг өөртөө байгаа эсвэл байхгүй *зүйлсээр* мөн *бусдын үзэл бодлоор* хуурамч байдлаар шүүдэг. Хэрэв бидэнд харьцуулалт хийх шаардлага гарвал урьдын байдлаа өнөөдрийнхтэй эсвэл бүр ирээдүйд ямар байхыг хүсэж байгаатайгаа л харьцуулж байя."[7]

Сошиал медиа дэлгэрэхээс нэлээн хэдэн жилийн өмнө авахуулсан энэхүү манай гэр бүлийн зурагт (дараагийн хуудсанд) байгаа нэгэн нууцаа би хуваалцъя. Хэрвээ энэ зургийг өнөөдөр авахуулсан бол энэ нь нийтлэгдэж, нэг гэр бүлийн, хувцасныхаа өнгийг хослуулсан, хүмүүжилтэй, хөөрхөн дөрвөн хөвгүүн гэр бүлийн эв найртай зураг авахуулах боломжинд дуртай байгаа мэт харагдах байсан байх. Та яг бодит түүхийг нь мэдэхийг хүсэж байна уу?

Би эхнэрээсээ хүлээн авсан утасны дуудлагыг одоо ч гэсэн санадаг. "Гари, чи хаана байна? Бид зурагчны гадаа байдаг студид байна. Зургаа авахуулахад бүгд бэлэн. Хөвгүүдийг хувцаслаж, өнгийг нь хослуулж, бэлэн болгоход тийм ч амар байсангүй. Чи бараг ирчихсэн үү?' гэв.

Олон хүн энэ виртуал бодит үнэний хэтрүүлсэн байдалтай адилгүй байгаадаа сэтгэлээр унадаг.

Хийхээр төсөөлсөн зураг

Хийсэн бодит байдал



Би бүр мартчихсан, ажлаасаа ч гараагүй байлаа! Хагас цаг хоцроод очиход, намайг байхгүйд сайн зүйл болоогүй бололтой, замбараагүй байдалтай байв.

Юу болоо вэ? Том хүү минь цэцэрлэгийн талбайгаар гүйж, алимны мод олон, хэдэн алим түүгээд, бусад хөвгүүн рүү шидэж эхэлжээ. Тэр гурав дахь хүүгийн маань араас алим шидэж, унагаасан тул гурав дахь хүү маань уйлж гарав.

Ийм зүйл болж байхтай зэрэгцэн, хоёр дахь хүүг маань суух үед өмд нь бага зэрэг дээш болжээ. Бусад хүүхэд түүнийг ээжийнх нь гаргаж тавьсан сүмд явахдаа өмсдөг оймсыг биш, харин спорт цагаан оймс өмссөнийг харчихаж. Ээж нь түүнээс “Чи яагаад сүмийн оймсоо өмсөөгүй билээ?” гэж асуухад

Тэр “Надад таалагддаггүй юм, загатнуулаад байдаг” гэж хариулав

Тэднийг ярьж байхад хоёр настай хүү минь талбайгаар гүйж байгаад ямар нэгэн зүйлд бүдрэн унаж, хамраас нь цус гарснаас хоолойтой цагаан цамц руу нь цус дусаж, толботуулав. Яг энэ үед би ирсэн байлаа. Зургаа авахын тулд хоолойтой цамцыг нь эргүүлэн, энгэрийг нь ард тал руу нь харуулж өмсгөн, цусны толбыг зургийн аппаратаас нуув.

Том хүү минь ийш тийш гүйж, алим шидэж байхдаа унаад, өвдгөндөө өвсний томоос том ногоон толботой болжээ. Иймээс энэ зурагт түүний гарыг бодлоготойгоор байрлуулж, өвсний толбыг нь халхалсан байгаа юм.

Гурав дахь хүүгийнхээ тухайд хэлэхэд, уйлснаас болж улайсан нүдийг нь зүгээр болтол бид 20 минут хүлээсэн. Бас бага хүүгийн минь цусан толбо цамцных нь ард талд байгаа гэдэг нь ойлгомжтой.

Хоёр дахь хүүгийн маань гарыг бодлоготойгоор спорт оймсыг нь халхалж байхаар байршуулсан тул бүх юм адилхан байлаа.

Гари миний бие хоцорч ирснээс энэ бүх зүйл болсон хэмээн би бас асуудалд оров.

Тиймээс та бүхэн манай гэр бүлийн энэ сайхан зургийг хараад, “Бид яагаад аж амьдралаа зохицуулаад, яг эднийхэнтэй адил зураг мэт төгс гэр бүл байж болохгүй гэж?” хэмээн харамсаж магад. Та нар ийм биш гэдгийг мэдэж байгаа!

Сошиал медиа болон номлолын ажил

Бид үнэн бодит байдлыг хэтрүүлэх болон харьцуулснаас болж уруу дорой харагдуулах зэрэг аюул, эрсдэлийг мэддэг байх хэрэгтэй болохыг та нар ойлгосон байх. Энэ дэлхий ихэнхдээ сошиал медиад харагддаг шигээ тийм ч аз жаргалтай байдаггүй. Гэсэн хэдий ч эдгээр харилцаа холбооны платформоор дамжуулан олон сайн зүйлс ирсэн, ирсээр ч байх болно.

Сошиал медиаг номлогчийн ажилд ашиглах арга замуудын тухай зарим шинэ удирдамжийг Номлогчийн албанаас 2017 онд гаргасан. Бидэнд байгаа олон дижитал эх сурвалжийг хүчирхэг, хялбар, энгийн бөгөөд дээд зэргийн үр дүнтэй аргуудаар ашиглаж болно.

Технологийн хэрэглээг зүй зохистой бөгөөд сүнслэгээр нөлөөлөгдсөн арга замуудаар ашиглах олон боломж бий. Бид өсөж буй үеийнхэнд технологийг зөв зохистой ашиглахыг зааж, үүнийг буруу ашиглахаас мөн холбогдох аюулд орохоос сэрэмжлүүлэхийн тулд чадах бүхнээ хийх ёстой. Энэ нь технологийн үр ашиг нь холбогдох эрсдэлүүдээсээ илүү гэдгийг бидэнд нотолж өгдөг.

“Элчүүд ямар сайхан юм бэ”

Би энэхүү захиасын талаар гүн гүнзгий тунгааж, залбирч байх үедээ нэгэн өглөө сэртэл “Амар амгалангийн сайн мэдээг бидэнд номлодог элчүүд ямар сайхан юм бэ”[8] гэсэн дууны энгийн шүлэг санаанд минь орж ирсэн.

Бидний захиас бол амар амгалангийн захиас бөгөөд та бүхэн үүнийг номлох сайхан элчүүд билээ. Та үүнийг эдгээр шинэ, сонирхолтой технологийн хэрэгслүүдээр дамжуулан хийж чадна. Бид амар амгалангийн сайн мэдээг тун амар аргаар номлох чадвар бүхий цаг хугацааны бүрэн дүүрэн байдалд, онцгой дэлхий дээр амьдардаг.

Бидэнд өнөө цаг үеийг төгс тодорхойлж, бидний өдрүүдэд чиглэл өгдөг эртний бошиглогчдын “Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, нэгэн Аврагчийн талаарх мэдлэг бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүрийн дунд тархах тэр цаг ирэх болно” (Мозая 3:20) хэмээх бошиглолын үгс бий.

Бидэнд мөн орчин цагийн илчлэлтээр ирсэн, бидний цаг үе, нөхцөл байдалд тохирсон бөгөөд удирдамж өгдөг үгс бий. “Бид Христийн шавь нарын хувьд Бурхан бол Мөнхийн Эцэг гэдгийг болон Түүний хүүхдүүддээ зориулсан аз жаргалын төлөвлөгөөг мөн Түүний Хүү Есүс Христийг дэлхийн Аврагч гэдгийг гэрчилж; хожмын өдрүүд дэх сайн мэдээний Сэргээлтийн бодит байдлыг тунхаглан; Их Эзэний ажлыг гүйцэтгэхэд эдгээр сүнслэгээр өдөөгдсөн хэрэгслийг зөв зохистой, илүү үр дүнтэй ашиглах цаг болсон гэдэгт итгэдэг”[9] гэсэн ахлагч Бэднарын үгийг би эш татмаар байна.

Би та нарын хүн нэг бүрийг сайхан элчүүдийн хувиар амар амгалангийн захиасыг номлохын тулд өөрийн үүргийг анхааралдаа бүрэн аваасай гэж уримаар байна. Бүгдээрээ “Аврагчийн талаарх мэдлэгээ” бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст хуваалцахын тулд үүргээ биелүүлцгээе. Үүнийг хийх хамгийн сайн арга зам нь танд болон таны гэр бүлд тохирдог онцгой арга замаар хийх явдал юм. Бидний хайрт Тэнгэрлэг Эцэгийн хүслийг алдаршуулж, бишрэн хүндэтгэж, гэр бүл, хайртай нэгэн, найз нөхөд, сошиал медиа дээрх найзууддаа Аврагчийн тухай мэдлэгийг авчрахын тулд та нарын хүн нэг бүр блог бичих, пин хийх, лайк дарах, шэйр хийх, найзлах, снааплах, гүйлгэн унших зоригтой байна гэдэгт би найдаж байна. ■

2017 оны 5-р сарын 5-нд Бригам Янгийн Их Сургуулийн эмэгтэйчүүдийн чуулган дээр хэлсэн “Аврагчийн тухай мэдлэг” үгээс авав.

Бүгдээрээ “Аврагчийн талаарх мэдлэгээ” бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст хуваалцахын тулд үүргээ биелүүлцгээе.

ЭШЛЭЛҮҮД

1. David O. McKay, in Conference Report, Oct. 1966, 4.
2. Spencer W. Kimball, “When the World Will Be Converted,” *Ensign,* Oct. 1974, 11, 10.
3. Жэффри Р.Холланд, “Хагарсан сав шиг,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 46–49-ийг үзнэ үү.
4. See Jeffrey R. Holland, “Mormon Message: Like a Broken Vessel,” June 20, 2016, mormonnewsroom.org.
5. See “President Uchtdorf Relates Flying to Gospel in Post and Video with Grandson,” Sept. 30, 2016, LDS.org.
6. Ерөнхийлөгч Томас С.Монсон, ”Элбэг хангалуун амьдрах нь,” *Лиахона,* 2012 оны 1-р сар, 4.
7. Ж.Дэвн Корниш, “Би хангалттай сайн байна уу? Би хаант улсад орж чадах уу? *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 19.
8. “How Lovely Are the Messengers,” hymnary.org.
9. David A. Bednar, “Flood the Earth through Social Media,” *Liahona,* Aug. 2015, 50; see also David A. Bednar, “Sweep the Earth as with a Flood” (video), LDS.org.

Бид амар амгалангийн сайн мэдээг тун амар аргаар номлох чадвар бүхий цаг хугацааны бүрэн дүүрэн байдалд, онцгой дэлхий дээр амьдардаг.

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

3-Р БҮЛЭГ

Алтан ялтас

Энэ бол "Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх" *нэртэй Сүмийн шинэ дөрвөн боть түүхэн өгүүллийн номын 3-р бүлэг юм. Уг ном 14 хэл дээр хэвлэгдэн гарах бөгөөд Gospel Library аппликэйшны Сүмийн түүх хэсэгт болон гэгээнтнүүд.lds.org вэбсайт дээр тавигдана. Энэ оны сүүлээр уг номын 1-р боть хэвлэгдэн гарах хүртэл дараагийн хэдэн бүлгийг ирэх дугаарууддаа нийтлэх болно. Тэдгээр бүлэг нь Gospel Library аппликэйшн болон гэгээнтнүүд.lds.org вэбсайт дээр 47 хэлээр тавигдах юм. 2-р бүлэгт 1820 оны хавар Эцэг, Хүү хоёрыг харсан Иосефын Анхны үзэгдлийг дүрсэлнэ.*

Гурван жил, гурван ургац хураалт өнгөрөв. Иосеф гэр бүлийнхээ эдлэн газрын жилийн төлбөрийг төлөх мөнгө олохын тулд ихэнх өдрүүдэд газар хагалан, хөрсөө бэлтгэж, хөлсний ажил хийдэг байв. Тэр энэ ажлаасаа болоод сургуульдаа байнга явах боломжгүй байсан бөгөөд ихэнх чөлөөт цагаа гэр бүлтэйгээ эсвэл бусад ажилчидтай хамт өнгөрөөдөг байв.

Иосеф болон түүний найзууд нас залуу, санаа зовох зүйлгүй байсан ба тэд заримдаа тэнэг алдаанууд гаргадаг байлаа. Иосеф нэг удаа уучлагдана гэдэг нь дахиад наманчлах шаардлагагүй гэсэн үг биш гэдгийг ойлгожээ. Түүнд тохиолдсон гайхамшигт үзэгдэл ч бүх асуултад нь хариулж, төөрөгдлөөс нь бүрэн гаргаагүй юм.[1] Тиймээс тэр Бурхантай ойр байхаар хичээж байв. Тэр Библиэ уншиж, өөрийг нь аврах Есүс Христийн хүч чадалд итгэн, өөр ямар ч сүмд нэгдэхгүй бай гэсэн Их Эзэний зарлигийг дагаж байлаа.

Бурхан Мосе, Аарон нарт болон Библи дээрх бусад хүнд илчилсэн шигээ саваа, чулуу гэх мэт биет зүйлсээр дамжуулан мэдлэгийг илчилнэ гэдэгт Иосеф тухайн бүс нутгийн олон хүнтэй адил, түүний дотор аавынхаа нэгэн адил итгэж байлаа.[2] Нэгэн өдөр Иосеф хөршдөө худаг ухахад нь тусалж байхдаа газрын гүнд булсан нэгэн жижиг чулууг олжээ. Иосеф хүмүүс заримдаа алдагдсан эд зүйлс юмуу нуусан эрдэнэсийг олохдоо онцгой чулуунууд ашигладаг гэдгийг мэдэж байсан бөгөөд өөрийгөө тийм чулуу олчихсон байх гэж бодсон байна. Тэрээр уг чулууг ажиглаад, энгийн нүдээр олж харахааргүй зүйлсийг харжээ.[3]

Уг чулууг ашиглах бэлэг Иосефт өгөгдсөнд гэр бүлийнхэн нь гайхан бишрч, үүнийг тэнгэрлэг тусламжийн тэмдэг гэж үзэж байв.[4] Хэдийгээр Иосефт үзмэрч байх бэлэг байсан ч Бурханы таалалд нийцэж байгаа эсэхтээ тэр эргэлзэж байлаа. Тэр Эцэг, Хүү хоёрыг үзэгдэлд харсныхаа дараа мэдэрсэн өршөөл, амар амгалангийн мэдрэмжийг мэдрэхээ больжээ. Харин оронд нь сул дорой, төгс бус байдлаасаа болж буруутай мэт мэдрэмжийг үргэлж мэдрэх болсон байна.[5]

1823 оны 9-р сарын 21-нд Иосеф арван долоон настайдаа ах нартайгаа хамт байдаг дээврийн өрөөндөө сэрүүн хэвтэж байв. Тэрээр орой болтол гэрийнхнийгээ өөр сүмүүд, тэдний заадаг сургаалын тухай ярилцаж байхыг сонссон аж. Одоо бүгд унтацгааж, байшин нам гүм боллоо.[6]

Иосеф Бурханаас нүглийг нь өршөөхийг чин сэтгэлээсээ гуйн өрөөндөө, харанхуйд залбирч эхлэв. Их Эзэний өмнө ямар байдалтай байгааг нь мэдүүлэх, ойн төгөлд амласан сайн мэдээний мэдлэгийг нь өгөх тэнгэрлэг элчтэй харилцахыг тэрээр хүсэж байв. Бурхан урьд урьдын залбиралд нь хариулсан бөгөөд энэ удаад ч хариулна гэдэгт Иосеф бүрэн итгэлтэй байлаа.

Иосефыг залбирах үед орных нь хажууд нэгэн гэрэл тусаж, улмаар дээврийн өрөөг бүхэлд нь гэрэлтүүлэхүйц тод болжээ. Иосефыг дээш хартал, агаарт нэгэн тэнгэр элч зогсож байлаа. Уг тэнгэр элч бугуй болон

МАЙКЛ МАЛМ, *ТЭР НАМАЙГ НЭРЭЭР МИНЬ ДУУДСАН*

шагай хүрсэн урттай, оёдолгүй цагаан өмсгөлтэй байв. Түүнээс гэрэл цацарч байсан бөгөөд царай нь цахилгаан мэт туяаран байлаа.

Иосеф анх хармагцаа айсан ч хоромхон зуур амар амгалангаар дүүрэв. Тэнгэр элч түүнийг нэрээр нь дуудаад, өөрийгөө Моронай гэж танилцуулсан юм. Тэрээр Иосефт Бурхан нүглийг нь өршөөсөн бөгөөд одоо түүгээр хийлгэх ажил байгааг мөн Иосефын нэр бүх хүмүүний дунд сайн болон муу аль алинаар нь яригдах болно гэж тунхаглажээ.[7]

Моронай ойролцоох гүвээнд булагдсан алтан ялтаснуудын тухай ярилаа. Уг алтан ялтаснууд дээр Америк тивд амьдарч байсан эртний хүмүүсийн цэдэг сийлэгдсэн байв. Тэр цэдэгт тэдний гарал үүслийн талаар өгүүлж, Есүс Христийн тэдэн дээр зочилж, Өөрийнхөө сайн мэдээний бүрэн байдлыг заасан тухай цэдэглэсэн байдаг.[8] ялтаснуудтай хамт хоёр үзмэрчийн чулуу хадгалагдан буйг Моронай хэлэв. Эдгээр чулууг хожим нь Урим ба Туммим буюу хөрвүүлэгч гэж Иосеф нэрлэжээ. Их Эзэн Иосефт уг цэдгийг орчуулахад нь туслахын тулд эдгээр чулууг бэлтгэсэн байна. Эдгээр тунгалаг чулууг хамтад нь боон, алтан ялтаснуудтай бэхэлсэн аж.[9]

Моронай айлчлалынхаа үлдсэн хугацаанд Исаиа, Иоел, Малахи, Үйлсийн библийн номнууд дахь бошиглолоос эш татав. Их Эзэн удахгүй ирэх гэж буйг мөн хүн төрөлхтний гэр бүл Бурханы эртний гэрээг шинэчлэхээс наашгүй бүтээгдсэн зорилгодоо хүрч чадахгүй гэдгийг тэр тайлбарлав.[10] Бурхан Иосефыг тус гэрээг шинэчлүүлэхээр дуудсаныг болон хэрэв тэр итгэлтэй байж, Бурханы зарлигуудыг сахивал ялтаснууд дээрх цэдгийг илчлэх нэгэн байх болно гэж Моронай хэлжээ.[11]

Бурхан гэрээгээ шинэчлэхийн тулд Иосефыг сонгосон болохыг мөн хэрэв тэрээр Бурханыг зарлигуудад итгэлтэй байвал ялтаснууд дээрх цэдгийг илчлэх нэгэн байх болно гэдгийг Моронай түүнд хэлсэн.

Тэнгэр элч явахаасаа өмнө Иосефт ялтаснуудад анхаарал тавьж, заавар хүлээн авахаас бусдаар хэнд ч тэдгээрийг үзүүлж болохгүй, уг зөвлөгөөг эс дагаваас тэр устгагдах болно гэж анхааруулсан байна. Тэгээд гэрэл Моронайн биеийн эргэн тойронд хуралдан, тэрээр тэнгэр рүү дээшлэн одсон юм.[12]

Иосефыг уг үзэгдлийн талаар тунгаан бодож хэвтэх үед гэрэл өрөөг дахин дүүргэж, Моронай ирээд, урьдын захиасаа дахин хэлчихээд, яваад өглөө. Гурав дахь удаагаа дахин нэг ирээд, нөгөө захиасаа хэлэв.

"Иосеф, анхааралтай байх ёстой шүү. Чамайг ялтсуудыг авахаар явах үед оюун санаа чинь харанхуйлагдах болно. Бүхий л төрлийн хилэнц оюун санаанд чинь орж ирэн, Бурханы зарлигуудыг дагахад чинь саад болно" гэж тэр хэллээ. Иосефыг өөрийг нь дэмжих хэн нэгэн рүү чиглүүлэх үүднээс Моронай үзэгдлүүдийн талаар аавдаа хэлэхийг ятгажээ.

"Тэр чиний үг бүрд итгэх болно" гэж тэнгэр элч амласан байна.[13]

Маргааш өглөө нь Иосеф аавыгаа үзэгдэл, тэнгэр элчүүдэд итгэдгийг мэдэж байсан ч Моронайн талаар юу ч хэлсэнгүй. Харин тэд өглөөг Алвинтай хамт ойролцоох талбай дээр ургац хурааж өнгөрүүлжээ.

Ажиллахад хэцүү байлаа. Иосеф өвсний хадуураа урагш, хойш савлан, өндөр ургасан тариа будааг хадаж буй ах нартайгаа мөр зэрэгцэн ажиллахыг хичээж байв. Гэвч тэрээр Моронайн айлчлалаас болоод шөнийн турш унтаагүй байсан бөгөөд эртний цэдгүүд болон тэдгээрийг булсан гүвээний л тухай бодож байв.

Төд удалгүй тэр өвс хадахаа больсныг Алвин ажиглалаа. "Бид ажиллах ёстой. Эс бөгөөс ажлаа дуусгаж чадахгүй нь байна" гэж тэр Иосеф руу хашгирав.[14]

Иосеф хэчнээн шаргуу, хурдан ажилласан ч Алвиныг гүйцэж чадахгүй байлаа. Ахмад Иосеф хэсэг хугацааны дараа Иосефыг цонхигор царайлан, өвс хадахгүй байгааг анзаарав. Хүүгээ өвдсөн байна гэж бодсон тэр "Гэртээ харь" гэж хэллээ.

Иосеф аавынхаа үгэнд орж, бүдчин барин гэр рүүгээ явав. Гэвч тэр хашаа давах гэж оролдохдоо эцэж туйлдан газарт уналаа.

Тэрээр газарт хэвтэж байхдаа Моронайг дахин өөрийнх нь дээр, гэрлээр хүрээлэгдэн зогсож байгааг хүчээ шавхан харав. "Миний хэлсэн зүйлийг яагаад аавдаа хэлсэнгүй вэ?" гэж тэр асуулаа.

Иосеф аавыгаа итгэхгүй байх вий гэж эмээснээ хэлжээ.

"Тэр итгэнэ ээ" гэж Моронай батлаад, өнгөрсөн шөнийн захиасаа давтан хэллээ.[15]

Хүүгээ тэнгэр элч болон түүний захиасын талаар хэлэх үед Ахмад Иосеф мэгшин уйлжээ. "Бурханаас ирсэн үзэгдэл байна" гэж тэр хэллээ. "Үүнийг дага."[16]

Иосеф гүвээ рүү яаран явав. Урьд шөнө нь Моронай ялтаснуудыг хаана байгаа талаар үзэгдэлд харуулсан учраас тэр хаашаа явахаа мэдэж байлаа. Ойр хавьцаа байдаг хамгийн өндөр гүвээ гэрээс нь бараг 5 километрийн зайд байв. Тус гүвээний оройгоос холгүй, баруун

КРЭЙГ ДИМОНДЫН АГААРААС АВСАН КУМОРА ГҮВЭЭ БОЛОН ТҮҮНИЙ ЭРГЭН ТОЙРНЫ ГАЗРЫН ГЭРЭЛ ЗУРАГ.

Кумора гүвээ нь Нью-Йоркийн Палмирагийн ойролцоо, Смитийн гэр бүлийн аж ахуйгаас 4.8 километрийн зайд оршдог. Моронай түүнд гүвээг үзэгдлээр харуулсан тул Иосеф тэнд булсан Мормоны Номын ялтаснуудыг олж авахын тулд хаашаа явахаа мэдэж байлаа.

талд нь байх томоохон чулуун доор ялтаснуудыг булсан байлаа.

Тэрээр алхан явахдаа ялтаснуудын талаар бодсоор байв. Хэдийгээр тэдгээр нь ариун нандин гэдгийг мэдэж байсан ч хэр үнэд хүрэх бол гэсэн сонирхлоо дарахад хэцүү байлаа. Тэр урьд нь хамгаалагч сүнснүүдээр хамгаалагдсан эрдэнэсийн талаар хууч яриа сонсож байсан ч Моронай болон түүний ярьсан ялтаснууд эдгээр түүхээс өөр байв. Моронай бол Бурханы сонгосон үзмэрчид уг цэдгийг аюулгүй хүргэхийн тулд Бурханаар томилогдсон тэнгэр элч байсан юм. Ялтаснуудыг алтаар хийсэн учраас биш, харин Есүс Христийн талаар гэрчилж байсан учраас үнэ цэнтэй байсан билээ.

Гэвч Иосеф гэр бүлээ ядуурлаас гаргах хангалттай баялгийг олж авах газрыг яв цав мэдэж байгаа тухайгаа бодохгүй байж чадсангүй.[17]

Иосеф гүвээн дээр ирээд, үзэгдэлд харсан газраа олж, чулууны захаар буй шороог зайлуулж, оройг нь цухуйтал ухав. Дараа нь тэр модны том мөчир олоод, түүгээрээ чулуун доогуур ивж, дээш өргөв.[18]

Чулуун доор ёроол, ханыг нь чулуугаар хийсэн хайрцаг байв. Иосеф хайрцаг дотор алтан ялтаснууд болон үзмэрчийн чулуунууд, цээжний хуяг байгааг харлаа.[19] Ялтаснууд эртний бичээсүүдийг агуулж байсан бөгөөд нэг талдаа гурван цагиргаар холбогдсон байв. Ялтас бүр 15 сантиметрийн өргөн, 20 сантиметрийн урттай байлаа. Ялтасны зарим хэсэг нь хоорондоо лацдагдсан байснаас хэн ч унших боломжгүй байв.[20]

Гайхаж бахадсан Иосеф ялтаснууд хэр үнэд хүрэх бол гэж дахин бодлоо. Тэрээр тэдгээрт хүрэхээр завдах үед цахилгаанд цохиулах мэт болжээ. Гараа угз татан авсныхаа дараа тэрээр дахиад хоёр ч удаа ялтаснуудад хүрэхээр завдахдаа цахилгаанд цохиулах мэт болсон байна.

"Би яагаад энэ номыг авч чадахгүй байгаа юм бол?" гэж тэр дуу алдлаа.

"Учир нь чи Бурханы зарлигуудыг дагасангүй" гэж ойр хавьд нэгэн дуу сонсдов.[21]

Иосеф эргэж хараад, Моронайг харлаа. Тэр өнгөрсөн шөнийн захиасыг санаад, уг цэдгийн үнэн зорилгыг умартсанаа ойлгожээ. Түүнийг залбирч эхлэхэд, оюун санаа, бодгаль нь Ариун Сүнсийг мэдрэв.

"Хараач" гэж Моронай зарлиглалаа. Иосефт өөр нэгэн үзэгдэл өгөгдсөн бөгөөд тоо томшгүй олон элчээр хүрээлэгдсэн Сатаныг тэр олж харав. "Сайн болон муу, цэвэр ариун болон бузар бусармаг, Бурханы алдар суу болон харанхуйн хүч, энэ бүгдийг үзүүлсэн шалтгаан нь чамайг уг хоёр хүчний ялгааг танин мэдэж, ёс бус нэгнээр хэзээ ч нөлөөлүүлж, удирдуулахгүй байгаасай гэсэндээ юм" гэж тэнгэр элч тунхаглажээ.

Тэрээр цэдгийг хүлээн авахын тулд зүрх сэтгэлээ ариусгаж, оюун санаагаа хүчирхэгжүүлэхийг Иосефт заавар лав. "Их Эзэнийг дуулгавартай дагах итгэл, залбирлаар л эдгээр ариун нандин зүйлийг олж авах ёстой" гэж Моронай тайлбарлав. "Үүнийг энэ дэлхийн алдар суугийн төлөө эд баялаг, хөрөнгө хураахын тулд энд хадгалаагүй юм. Тэдгээрийг итгэлийн залбирлаар лацадсан."[22]

Иосеф хэзээ ялтаснуудыг авч болохоо лавлажээ.

"Хэрэв өөртэйгөө зөв хүнийг хамт авчирвал есдүгээр сарын хорин хоёр дахь өдөр" хэмээн Моронай хэллээ.

"Зөв хүн нь хэн юм бэ?" гэж Иосеф асуув.

"Чиний ууган ах."[23]

Иосеф хүүхэд байхаасаа л ууган ахдаа найдаж болно гэдгээ мэддэг байжээ. Энэ үед Алвин хорин таван настай байсан бөгөөд хүсвэл өөрийн гэсэн фермтэй болох цаг нь иржээ. Гэхдээ тэр гэр бүлийнхээ ферм дээр үлдэж, эцэг эхдээ нас нь өтлөх үед амьдралаа төвхнүүлж, газраа хамгаалахад нь туслахаар шийдсэн байна. Тэр буурь суурьтай, ажилч хичээнгүй байсан бөгөөд Иосеф түүнийг маш их хайрлаж, хүндэлдэг байв.[24]

Иосеф Их Эзэний ялтаснуудыг итгэл тээн авах хүн болохын тулд мэргэн ухаан, хүч чадлыг ахаасаа суралцах хэрэгтэй байсан гэж Моронай мэдэрсэн байх.

Тэр орой Иосеф гэртээ ирэхдээ ихэд ядарсан байв. Гэтэл түүнийг хаалгаар орж ирэнгүүт гэрийнхэн нь тойрч зогсоод, гүвээнээс юу олсон талаар нь мэдэхийг хүсэв. Иосеф тэдэнд ялтаснуудын талаар ярьж эхлэхэд Алвин түүнийг ямар их ядарсан байгааг хараад зогсоожээ.

"Унтахаар явцгаая. Бид өглөө эрт босоод, ажиллахаар явах ёстой" гэж тэр хэллээ. Тэдэнд маргааш нь Иосефын түүхийг сонсох хангалттай цаг олдох байв. "Хэрэв ээж оройн хоолоо эрт хийчихвэл бидэнд бүхэл оройжингоо суугаад, чамайг сонсох хангалттай цаг гарах болно"[25] гэж тэр хэлэв.

Маргааш орой нь Иосеф гүвээн дээр болсон зүйлийн тухай хэлэхэд Алвин түүнд итгэв. Алвин гэрийнхээ хамгийн том хүүгийн хувьд өтөлж буй эцэг эхийнхээ материаллаг байдалд анхаарал тавих үүрэг хариуцлагаа үргэлж мэдэрдэг байв. Тэр дүү нартайгаа хамт илүү тав тухтай байхын тулд гэр бүлдээ зориулан илүү том байшин барьж эхэлсэн байна.

Харин одоо Иосеф тэдний сүнслэг сайн сайханд санаа тавьж байгаа санагдав. Түүний орой бүр ярих алтан ялтаснууд, тэдгээрийг бичсэн хүмүүсийн талаарх яриа гэр бүлийнхний нь сонирхлыг татдаг байжээ. Гэр бүл нь илүү эвсэг дотно болж, гэр орон нь амар амгалан, аз жаргалтай байв. Ямар нэгэн гайхамшигтай зүйл болох гэж байгааг гэрийнхэн нь бүгд мэдэрч байлаа.[26]

Моронайн айлчлалаас хойш хоёр сарын дараа нэгэн намрын өглөө Алвин ходоод нь хүчтэй базалсан тул гэртээ орж ирэв. Тэр эвхрэлдэн, амь тэмцэн байхдаа тусламж дуудахыг аавасаа хүсжээ. Эмч ирээд, Алвинд нэгэн шохойн эм их хэмжээгээр өгсөн нь байдлыг улам дордуулав.

Алвин өвчиндөө тарчлан орондоо олон хоног хэвтжээ. Тэр өөрийгөө үхэх гэж байна гэж бодон, Иосефыг дуудлаа. "Цэдгүүдийг авахын тулд чадах бүхнээ хийгээрэй. Өгөгдсөн бүхий л зааврыг хүлээн авч, зарлигийг сахихдаа итгэлтэй байгаарай"[27] гэж Алвин хэлжээ.

Төд удалгүй тэр нас барж, гэр бүл нь уй гашууд автав. Оршуулах ёслол дээр номлогч Алвиныг там руу явсан гэсэн утгатай юм хэлсэн бөгөөд түүний үхлийг Бурхан биднийг аврахаар хөндлөнгөөс оролцохоос наашт тохиолдож болох зүйлсийн талаар бусдад өгөх сэрэмжлүүлэг болгожээ. Ахмад Иосеф цухалдангүй байв. Хүү нь сайн залуу байсан бөгөөд Бурхан хүүг нь яллана гэж тэр бодохгүй байлаа.[28]

Алвиныг явсны дараа ялтаснуудын талаарх яриа ч төгсгөл болов. Тэрээр Иосефын тэнгэрлэг дуудлагыг үнэн сэтгэлээсээ дэмждэг байсан бөгөөд ялтаснуудын талаарх аливаа яриа нь түүний үхлийг сануулж байв. Гэр бүлд нь тэвчихэд хэцүү байлаа.

Иосеф Алвиныг маш их санаж байсан бөгөөд түүний үхэл ялангуяа өөрт нь их хүнд тусжээ. Цэдгүүдийг авахад нь тусална гэдэгт том ахдаа найдаж байсан түүнд одоо хөсөр хаягдсан мэт санагдаж байлаа.[29]

Гүвээ рүү явах өдөр ирэхэд Иосеф ганцаараа явав. Алвин байхгүй учраас Их Эзэн өөрт нь ялтаснуудыг итгэл хүлээлгэн өгнө гэдэгт тэр эргэлзэж байлаа. Гэхдээ

1823 оны 9-р сарын 22-ны үдэш Иосеф Смит Мормоны Номын ялтаснуудыг анх харсан мөн яг 4 жилийн дараа гаргаж авсан газрын дурсгалд зориулан Моронайн хөшөөг Кумора гүвээний оройд сүндэрлүүлжээ.

тэр ахынхаа зөвлөснөөр Их Эзэний өгөх зарлиг бүрийг сахина гэж бодож явав. ялтаснуудыг авах талаарх Моронайн зааварчилгаа тодорхой байжээ. "Чи тэдгээрийг гартаа бариад, шууд гэр рүүгээ явах ёстой. Тэдгээрийг нуу"[30] гэж тэнгэр элч хэлэв.

Иосеф гүвээн дээр ирээд, чулууг хөшин дээшлүүлж, чулуун хайрцган дотроос ялтаснуудыг гаргаж ирлээ. Хайрцган дахь бусад зүйл ч бас үнэ цэнтэй учраас тэдгээрийг гэр рүүгээ явахаасаа өмнө далдлах хэрэгтэй юм байна гэсэн бодол түүнд төрөв. Тэр ялтаснуудыг гаргаж тавиад, хайрцгийг таглах гээд эргэж харав. Эргээд ялтаснуудаа авах гэтэл алга болчихсон байлаа. Айж түгшсэн тэрээр өвдөг сөхрөн, тэдгээрийг хаана байгааг мэдэхийн төлөө залбирчээ.

Моронай гарч ирэн, дахиад л заавруудыг дагаагүйг Иосефт хэлсэн байна. Тэр ялтаснуудыг аюулгүй газар аваачихаасаа өмнө газар тавьсан төдийгүй хараанаасаа салгажээ. Залуу үзмэрч Их Эзэний ажлыг гүйцэлдүүлэх хүсэлтэй байсан ч эртний цэдгүүдийг хамгаалах чадвартай болоогүй байв.

Иосеф сэтгэлээр унахад Моронай түүнд дараа жил ялтаснуудыг авахаар эргэн ирэхийг заавралжээ. Мөн тэрээр Бурханы хаант улсад зориулсан Их Эзэний төлөвлөгөө, урагш өнхөрч эхэлж буй агуу ажлын талаар түүнд илүү олон зүйлийг заалаа.

Гэсэн хэдий ч Тэнгэр элчийг явсны дараа Иосеф гар хоосон гэртээ ороход гэрийнхэн нь юу гэж бодох бол гэдэгт санаа зовнин, гүвээ уруудан гунигтай гэгч нь алхав.[31] Түүнийг гэртээ ороход тэд хүлээж байлаа. Аав нь түүнээс ялтаснуудыг авсан эсэхийг асуув.

"Үгүй. Би авч чадсангүй" гэж тэр хэллээ.

"Чи тэдгээрийг харсан уу?"

"Би харсан. Гэхдээ авч чадсангүй."

"Хэрэв би чиний оронд байсан бол авах байсан юм" гэж Ахмад Иосеф хэлэв.

"Та юу хэлж байгаагаа мэдэхгүй байна. Их Эзэний тэнгэр элч зөвшөөрөөгүй учраас би авч чадсангүй"[32] гэж Иосеф хэллээ. ■

Эш татсан бүтээлүүдийн бүрэн жагсаалт saints.lds.org вэбсайтад англи хэл дээр бий.

Тэмдэглэл дэх *Сэдэв* гэсэн үг нь дэлгэрэнгүй мэдээлэл онлайнаар, гэгээнтнүүд.lds.org вэбсайт дээр байгааг илэрхийлнэ.

ЭШЛЭЛҮҮД

1. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 4–5, in *JSP,* H1:220 (draft 2); Joseph Smith History, circa Summer 1832, 1, in *JSP,* H1:11.
2. "Joseph Smith as Revelator and Translator," in *JSP,* MRB:xxi; Turley, Jensen, and Ashurst-McGee, "Joseph the Seer," 49–50; мөн Мозая 8:17; Алма 37:6–7, 41; Сургаал ба Гэрээ 10:1, 4-ийг үзнэ үү (Revelation, Spring 1829, at josephsmithpapers.org).
3. Бушмэн, *Rough Stone Rolling,* 48–49; Bushman, "Joseph Smith as Translator," 242. **Сэдэв:** Seer Stones (Үзмэрчийн чулуу)
4. Lucy Mack Smith, History, 1845, 95; мөн Алма 37:23-ыг үзнэ үү.
5. Joseph Smith History, circa Summer 1832, 4, in *JSP,* H1:13–14; Иосеф Смит—Түүх 1:28–29; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 5, in *JSP,* H1:218–20 (draft 2).
6. Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [10].
7. Joseph Smith History, circa Summer 1832, 4, in *JSP,* H1:13–14; Иосеф Смит—Түүх 1:29–33; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 5, in *JSP,* H1:218–22 (draft 2); Pratt, *Interesting Account,* 6, in *JSP,* H1:524; Hyde, *Ein Ruf aus der Wüste,* 17–20-ийг үзнэ үү. **Сэдэв:** Angel Moroni (Тэнгэр элч Моронай)
8. Joseph Smith, Journal, Nov. 9–11, 1835, in *JSP,* J1:88.
9. Иосеф Смит—Түүх 1:35; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 5, in *JSP,* H1:222 (draft 2); Joseph Smith History, circa Summer 1832, 4, in *JSP,* H1:14; Oliver Cowdery, "Letter IV," *LDS Messenger and Advocate,* Feb. 1835, 1:65–67; Turley, Jensen, and Ashurst-McGee, "Joseph the Seer," 49–54; "Mormonism—No. II," *Tiffany's Monthly,* 1859 оны 7-р сар, 164. **Сэдэв:** Seer Stones (Үзмэрчийн чулуу)
10. Иосеф Смит—Түүх 1:36–41; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 5–6, in *JSP,* H1:222–26 (draft 2); Joseph Smith, Journal, Nov. 9–11, 1835, in *JSP,* J1:88–89.
11. Оливер Каудери, "Letter IV," *LDS Messenger and Advocate,* Feb. 1835, 1:78–79; Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [11].
12. Иосеф Смит—Түүх 1:42–43; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 6, in *JSP,* H1:226 (draft 2).
13. Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [10]–[11]; Оливер Каудери, "Letter IV," *LDS Messenger and Advocate,* Feb. 1835, 1:79–80; Оливер Каудери, "Letter VII," *LDS Messenger and Advocate,* 1835 оны 7-р сар, 1:156–57; Иосеф Смит—Түүх 1:44–46; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 6–7, in *JSP,* H1:230–32 (draft 2); Joseph Smith, Journal, 1835 оны 11-р сарын 9–11, in *JSP,* J1:88–89.
14. Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [11]; мөн Smith, *William Smith on Mormonism,* 9-ийг үзнэ үү.
15. Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [11]; Smith, *Biographical Sketches,* 82; Joseph Smith—History 1:48–49; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 7, in *JSP,* H1:230–32 (draft 2); Joseph Smith, Journal, Nov. 9–11, 1835, in *JSP,* J1:89.
16. Joseph Smith, Journal, Nov. 9–11, 1835, in *JSP,* J1:89.
17. Оливер Каудери, "Letter VIII," *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:195–97. **Сэдэв:** Treasure Seeking "Эрдэнэсийн эрэлд"
18. Оливер Каудери, "Letter VIII," *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:195–97; Иосеф Смит—Түүх 1:51–52; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 6–7, in *JSP,* H1:230–32 (draft 2); мөн Пакэр, "A Study of the Hill Cumorah," 7–10-ыг үзнэ үү.
19. Иосеф Смит—Түүх 1:52; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 7, in *JSP,* H1:232 (draft 2). **Сэдэв:** Gold Plates (Алтан ялтас)
20. Иосеф Смит, "Church History," *Times and Seasons,* 1842 оны 3-р сарын 1, 3:707, in *JSP,* H1:495.
21. Оливер Каудери, "Letter VIII," *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:197–98; see also Pratt, *Interesting Account,* 10, in *JSP,* H1:527–29.
22. Оливер Каудери, "Letter VIII," *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:198–99.
23. Knight, Reminiscences, 1; Joseph Smith, Journal, Nov. 9–11, 1835, in *JSP,* J1:89; Иосеф Смит—Түүх 1:53–54; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 7, in *JSP,* H1:232–34 (draft 2); мөн Жэссий, "Joseph Knight's Recollection of Early Mormon History," 31-ийг үзнэ үү.
24. Joseph Smith, Journal, Aug. 23, 1842, in *JSP,* J1:116–17.
25. Lucy Mack Smith, History, 1844–45, book 3, [12]; book 4, [3]; Smith, *Biographical Sketches,* 83.
26. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [1]–[3]; Smith, *Biographical Sketches,* 86–87; мөн Lucy Mack Smith, History, 1845, 89; and Bushman, *Refinement of America,* 425–27-г үзнэ үү. **Сэдэв:** Joseph Sr. and Lucy Mack Smith Family (Ахмад Иосеф, Люси Мак Смитийн гэр бүл)
27. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [3]–[5].
28. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [6]–[8]; "Wm. B. Smith's Last Statement," *Zion's Ensign,* 1894 оны 1-р сарын 13, 6.
29. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [7]; Joseph Smith, Journal, Aug. 23, 1842, in *JSP,* J2:116–17.
30. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [2]–[3].
31. Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [2]–[3]; Smith, *Biographical Sketches,* 85–86; Knight, Reminiscences, 1; Иосеф Смит—Түүх 1:54; Lucy Mack Smith, History, 1845, 88 мөн Жэссий, "Joseph Knight's Recollection of Early Mormon History," 31-ийг үзнэ үү.
32. Смит, *Biographical Sketches*, 86.

Исламын шашныг
ОЙЛГОХ НЬ

Даниел Петерсон
Бригам Янгийн Их Сургуулийн исламын шашин судлал ба араб хэл судлалын доктор профессор

Тайлбар: Өөр шашин шүтлэгтэй хүмүүсийг ойлгох нь чухал учраас дэлхийн хоёрдогч том шашин болох исламын шашны түүх, сургаалын талаар ерөнхий ойлголт өгөх нь тустай хэмээн Сүмийн удирдагчид үзсэн болно.

Сайн, муу янз бүрийн шалтгаанаар исламын шашин болон мусульманчууд сүүлийн үеийн мэдээнд гарахгүй өнгөрдөг өдөр гэж бараг байхаа больжээ. Тиймээс хожмын үеийн гэгээнтнүүд зэрэг исламын шашинтан бус олон хүн тэдний талаар сонирхож, тэр ч бүү хэл санаа зовдог болох нь ойлгомжтой. Бид мусульман хөршүүдтэйгээ ямар нэгэн зүйлээрээ адил уу? Бид хамтдаа амьдарч, ажиллаж чадах болов уу?

Юуны өмнө зарим түүхэн суурь мэдлэг өгөх нь тустай байж болох юм.

МЭӨ 610 онд дунд эргэм насны Мухаммед гэдэг араб худалдаачин эргэн тойронд нь үүссэн шашны төөрөгдлийн талаар эргэцүүлэн бодож, залбирахаар төрөлх хот Меккагийн ойролцоох гүвээ рүү гарчээ. Хожим нь тэрээр өөрийг нь өөрийн хүмүүст бошиглогч бол хэмээн дуудсан нэгэн үзэгдлийг хүлээн авснаа хэлсэн байдаг. Энэ үйл явдал (Бурханд) “захирагдах” гэсэн утгатай ислам (исс-ЛААМ) гэдэг үгээр нэрлэгддэг шашны эхлэлийг тавьсан байна. Исламын шашинд итгэгчийг мусульман (МУСС-лим) буюу “захирагдагч” хэмээн нэрлэдэг.

Мухаммедын төрсөн хот буюу исламын шашны хамгийн ариун хот болох Мекка дахь Каабаг дүрсэлсэн 19-р зууны шигтгэмэл зураг.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ



Дэлхий дээрх мусульманчуудыг улсаар нь, саяын нарийвчлалтай харуулав (Pew Research Center, 2009).

Түүнээс хойш Мухаммедыг 25 жилийн туршид нас барах хүртлээ олон илчлэлт хүлээн авсан гэж ярьдаг. Тэр эхлээд төрөлх хотынхоо оршин суугчидтай тэнгэрлэг шүүлт ирэх талаар анхааруулга өгч, сонсогчдоо наманчлахыг мөн бэлэвсэн, өнчин, ядуу хүмүүстэй зөв харьцахыг уриалж, нас барагсад бүгд амилах тухай болон Бурханы эцсийн шүүлтийн тухай номлож байсан байна.

Гэхдээ түүнийг болон дагагчдыг нь дооглон тохуурхах, мөрдөн хавчих явдал улам бүр ширүүссэн тул тэд хойд зүг рүү тэмээгээр 4 өдөр явах зайд орших Медина хот руу зугтахаас өөр аргагүй болсон аж.

Тэнд Мухаммедын гүйцэтгэдэг байсан үүрэг эрс өөрчлөгджээ.[1] Тэрээр ердийн номлогч, сэрэмжлүүлэгч байснаа хууль тогтоогч, шүүгч, Арабын чухал хотын, улмаар Арабын хойгийн улс төрийн удирдагч болсон юм.

Эртний итгэгчдийн байгуулсан энэ суурин газар исламын шашинд хууль, шударга ёсонд үндэслэгдсэн шашны дүр төрхийг өгчээ. Энэ нь уг шашны хамгийн өвөрмөц бөгөөд чухал онцлог шинж юм.

МЭӨ 632 онд Мухаммедыг нас барсны дараа түүний оронд исламын шашинтнуудын удирдагчаар хэн сонгогдох ёстой вэ гэдэг асуултаас үүдэн тэд хуваагдаж, хоёр үндсэн урсгал гарч ирэв.[2] Энэ хоёр урсгалын хамгийн томыг нь Суннит гэдэг (энэ нь *сунна* буюу Мухаммедын уламжлалт зан үйлийг дагадаг гэдэг бөгөөд үе залгамжлах асуудал дээр харьцангуй уян хатан байдаг). Нөгөөх нь Мухаммедын хүргэн ‘Алигийн эргэн тойрны хүрээнд үүссэн бөгөөд *Шийт ‘Али* (‘Алигийн урсгал) гэж нэрлэгддэг ба одоо Шийт гэсэн нэрээр олонд танигджээ. Суннитуудаас ялгаатай нь шиатууд (шийтүүд буюу ший мусульманчууд гэгддэг) Мухаммедыг залгамжлан удирдах эрхийг бошиглогч Мухаммедын хамгийн ойрын эрэгтэй хамаатан болох ‘Али ба түүний удам угсааныхан залгамжлах ёстой гэж үздэг байна.

Хэдийгээр хоорондоо ийм санал зөрөлдөөнтэй байсан ч исламын шашныхан шашин шүтлэгийн хувьд Христийн шашинтнуудаас илүү нэгдмэл байсаар иржээ. Цаашилбал, МЭӨ 800-аад оноос хойш хэдэн зууны туршид исламын соёл иргэншил шинжлэх ухаан, анагаах ухаан, математик, гүн ухаан судлалын хувьд дэлхийд хөгжлөөрөө тэргүүлж байсан гэж хэлж болно.



Мусульманчууд Коран судрыг Мухаммедад шууд өгсөн Аллахын үг хэмээн үздэг.

Мусульман сургаал ба зан үйлийн эх сурвалж

Мухаммедыг нас барснаас хойш арав хориод жилийн дараа түүний илчлэлтүүдийг цуглуулан коран (“унших” буюу “өгүүлэх” гэсэн утгатай *qara’a* гэдэг араб үгээс гаралтай) гэх ном болгожээ. 114 бүлэгтэй Коран нь Мухаммедын тухай түүх биш юм. Сургаал ба Гэрээний нэгэн адил энэ нь зохиолын ном биш бөгөөд мусульманчууд үүнийг Мухаммедад өгсөн Бурханы үг (ба үгс) гэж үздэг.[3]

Үүнийг уншсан Христийн шашинтнууд эндээс танил сэдвүүдийг олж уншиж болно. Тухайлбал, энэ номонд Бурхан ертөнцийг долоо хоногт бүтээсэн, Тэр Адам, Ева хоёрыг Едений цэцэрлэгт байрлуулсан, тэднийг чөтгөр уруу татсан, тэдний уналт, дараагийн дуудагдсан бошиглогчдын (ихэнх нь бас Библид гардаг) нэрс зэрэг нь гардаг. Коранд эдгээр бошиглогчийг өөрсдийн хүслийг Бурханд захируулсан *мусульманчууд* хэмээн дүрсэлсэн.

Уг бичвэрт Абрахамыг Бурханы найз хэмээн тодорхойлж, олон удаа түүний тухай дурдсан байдаг.[4] (Үүнээс гадна түүнийг хүлээн авсан илчлэлтүүдээ бичиж авсан хэдий ч тэдгээр нь алдагдсан гэж үздэг.[5]) Мөн Мосе, Фараон болон Израилийн хүүхдүүдийн Египетээс гарсан талаар гардаг байна.

Гайхалтай нь, Есүсийн эх Мариаг Шинэ Гэрээнд 19 удаа дурдсан байдаг бол Коранд 34 удаа дурдсан байдаг. (Үнэндээ тэр бол Коран судар т нэр нь дурдагдсан цорын ганц эмэгтэй юм.)

Коранд хамгийн их бичигдсэн сургаал бол *tawhid* (тау ХИЙД) сургаал бөгөөд үүнийг “монотейзм” буюу “ганц бурхан” гэж орчуулж болно. Энэ нь исламын шашны гол зарчмуудын нэг болох цор ганц онцгой тэнгэрлэг бие байдаг гэдгийг төлөөлдөг. “Тэр хүүхэдгүй, тэр өөрөө хэн нэгний хүүхэд ч биш” хэмээн Коран тунхаглаад, “мөн түүн шиг нэгэн нь үгүй”[6] гэсэн байдаг. Үүнээс улбаалан гарах дараах зүйл нь исламын болон Христийн шашны хоорондын хамгийн чухал ялгаа мөн. Тухайлбал: Мусульманчууд Есүс Христийн эсвэл Ариун Сүнсний бурханлаг байдалд итгэдэггүй. Бас бүх хүнийг Бурханы эн тэнцүү бүтээсэн бүтээл гэсэн ч исламын сургаалын дагуу бид Түүний хүүхэд биш гэж дурдсан байдаг.

Гэхдээ мусульманчууд Есүсийг Бурханы нүгэлгүй, онгон эхээс

Жил бүр хоёр сая орчим мусульман хүн Мекка руу мөргөл үйлдэхээр явдаг.

Мусульманчууд өдөрт таван удаа өвдөг сөгдөн мөргөл үйлддэг.

төрж, хожмын өдрүүдийн үйл явдлуудад чухал үүрэг гүйцэтгэх хувь тавилантай бошиглогч байсан гэдэгт итгэдэг. Есүсийг Коранд олон удаа, хүндлэн биширч дурдсан байдаг.

Мусульманы гол сургаал ба зан үйл

"Исламын таван тулгуур багана" хэмээн нэрлэдэг исламын шашны гол сургаалыг Коранд биш, харин Мухаммедад зориулан бичсэн мэдэгдэлд хамгийн оновчтой хураангуйлан дүрсэлсэн. Үүнд:

1. Гэрчлэл

Хэрэв исламын шашинтнуудад нийтлэг итгэлийн бэлгэ тэмдэг гэж байдаг бол тэр нь *шахада*, "итгэлийн тунхаглал" буюу "гэрчлэл" юм. Энэ хэллэг нь "[Аллахаас] өөр ямар ч Бурхан байхгүй мөн Мухаммед Аллахын элч мөн болохыг би гэрчилж байна" гэж орчуулагддаг араб уншлагыг илэрхийлдэг. Шахада бол исламын шашинд орох үүд хаалга юм Үүнийг чин сэтгэлээсээ итгэж, давтан уншсанаар мусульман болдог.

Аллах гэдэг үг нь араб хэлний *Бурхан* гэсэн үг юм. Уг үгийг задлан авч үзвэл, *al- ilah* ("бурхан") гэсэн хоёр үг нь оноосон нэр биш, харин цол хэргэм юм. Энэ нь еврей хэлний *Элохим* гэдэг үгтэй холбоотой.

Исламын шашинд санваар гэж байхгүй тул санваарын ёслолууд гэж байдаггүй. Мөн "сүм" гэж бас байдаггүй. Иймд шахадаг тунхаглах нь исламын шашны хувьд баптисмтай адил үйл юм. Исламын шашинд өнөө үед албан ёсны, нэгдсэн, дэлхийг хамарсан удирдлагын бүтэц гэж байдаггүй нь өөр утга санааг илэрхийлдэг. Тухайлбал, дэлхийн мусульманчуудыг ерөнхийд нь удирддаг удирдагч, тэднийг төлөөлөн ярьдаг хүн гэж байдаггүй. (Мухаммедыг хамгийн сүүлийн бошиглогч гэдгийг бараг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрдөг.) Энэ нь мөн террористууд эсвэл "буруу номтнуудыг" гишүүнчлэлээс хасах сүм байхгүй гэсэн үг.

2. Мөргөл

Мусульман биш олон хүн мусульманчуудын мөргөл үйлдэх ёс болох *салаатыг* (са-ЛААТ) мэддэг. Энэ нь өдөрт таван удаа, биеэрээ үйлддэг мөргөл юм. Коранд заагдсан шүлгийг давтан хэлж, духаа газарт хүргэх нь Бурханд даруухнаар захирагдаж байгааг илэрхийлдэг. Аль ч үед хийж болдог залбирлыг *ду'а* гэдэг ба үүнийг хүссэн үедээ хэлж, биеэрээ мөргөх шаардлагагүй байдаг байна.

Баасан гаргийн үд дундын мөргөлийг мусульман эрчүүд заавал, харин эмэгтэйчүүд боломжоороо исламын сүм хийдэд (арабаар *масчид* буюу "мөргөлийн газар") хийх ёстой байдаг. Тэнд хүйсээрээ тус тусдаа бүлгүүдэд хуваагдан, эгнэн зогсоод, масчидын имамын (арабаар ии-МААМ буюу *амама*, "урд талд" гэсэн утгатай) удирдлаган доор залбирч, богино номлол



Дэлхийн мусульманчуудын 85-аас дээш хувь нь суннит юм (see Pew Research Center). Цөөнх болох шийтүүд Азербайжан, Бахрайн, Иран, Иракаас өөр газруудад байдаг.

сонсдог. Гэхдээ баасан гараг нь Хүндэтгэлийн өдөртэй яг ч адилхан биш юм. Хэдийгээр ихэнх мусульман оронд "амралтын өдрүүд" нь *яум ал-жим'а* ("цугларалтын өдөр") буюу баасан гарагт төвлөрдөг ч тухайн өдөр ажиллах нь гэм нүгэлд тооцогддоггүй.

3. Өргөл

Закат (за-КААТ буюу "ариусгагч нэгэн" гэсэн утгатай) нь ядууст туслах, масчид болон исламын шашны бусад үйл ажиллагааг дэмжихэд зориулан буяны өргөл өргөхийг хэлдэг. Ерөнхийдөө үүнд мусульман хүн тогтоосон хамгийн доод хэмжээнээс дээгүүр гарсан бүх хөрөнгийнхөө 2.5 хувийг өгөх ёстой байдаг. Зарим мусульман шашинтай оронд энэ өргөлийг төрийн байгууллагууд цуглуулдаг бол зарим оронд энэ нь сайн дурынх байдаг ажээ.

4. Мацаг барих

Жил бүр билгийн тооллын Рамадан сарын турш нар мандахаас нар жаргах хүртэл сүсэг бишрэлтэй мусульманчууд хоол, унд, бэлгийн харьцаанаас татгалздаг. Тэд мөн уг сарын турш ядууст чиглэгдсэн онцгой буяны үйлсэд өөрсдийгөө зориулж, Коран уншдаг.[7]

5. Мөргөл үйлдэхээр явах

Эрүүл саруул, хөрөнгө мөнгөний боломжтой мусульманчууд амьдралдаа дор хаяж нэг удаа Мекка руу мөргөл үйлдэхээр явах ёстой. (Исламын шашны хоёр дахь ариун хот болох Мединад очиж болох ч тийшээ заавал очихыг шаарддаггүй.) Итгэлтэй мусульманчуудын хувьд ийнхүү үйлдэх нь асар их сүнслэг бөгөөд сэтгэл хөдөлгөм үйл явдал болдог ба энэ нь өөрийн биеэр Ерөнхий чуулганд оролцох эсвэл ариун сүмд анх удаа орж байгаатай адилхан юм.

Өнөөгийн зарим асуудал

Исламын шашны тухайд мусульман биш хүмүүсийн санааг зовоодог гурван зүйл нь шашны хүчирхийлэл; исламын буюу *шариатын* хууль; эмэгтэйчүүдэд хандах хандлага юм.

Зарим хэт даврагч бүлгийнхэн *жихад* гэдэг үгийг "ариун дайн" гэсэн утгаар хэрэглэдэг ч яг үнэндээ энэ үг нь "зөвхөн" залбирал хийж, судар судлахын оронд "бодит ажил хийх" гэсэн утгатай.

Мусульман хуульч, гүн ухаантнууд жихадын талаар олон янзын ойлголттой байдаг. Хуулийн жишиг эх сурвалжуудад дурдахдаа, тухайлбал, цэргийн жихад үйл ажиллагаа нь хамгаалах чанартай байх бөгөөд эсрэг талд анхааруулга өгч, өдөөн хатгасан үйлдлээ зогсоох боломж олгох ёстой гэсэн байдаг. Өнөөгийн зарим хуульч болон мусульман гүн ухаантан жихад гэж исламын шашинтнуудад ашигтай эсвэл дэлхийг ерөнхийд нь сайжруулах зорилготой ямар ч бодит үйлийг хэлж болно хэмээн маргалддаг. Мухаммед жихадыг "их жихад," "бага жихад" гэж хоёр төрөл болгон ангилсан гэж үздэг ба сүүлийнхийг нь дайн байлдаан хэмээсэн байдаг. Харин их жихад гэдэг нь шударга бусын эсрэг мөн зөв шударга амьдрахын тулд өөрөө өөртэйгөө тэмцэх гэсэн утгатай.

Өнөөгийн исламын террористууд шашны үндэслэлтэй гэх

Нар жаргах үед өдрийн Рамадан мацгаа тайлахдаа иддэг мусульманчуудын оройн зоог болох ифтарыг хамтдаа зооглох гэж буй мусульман эмэгтэйчүүд.

Зарим мусульман эмэгтэй зохистой байдлаа буюу Аллахад итгэдэг гэдгийн тэмдэг болгон эсвэл мусульман гэдгээ харуулахын тулд хижаб толгойн өмсгөлийг өмсдөг байна.

болович энэ нь бодит байдалд шашинтай бараг ямар ч холбоогүй нийгэм, улс төр, эдийн засгийн хүндрэлийг авчирдаг.[8] Түүгээр ч барахгүй, дэлхийн мусульманчуудын дийлэнх нь террорист хүчирхийлэлд нэгддэггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.[9]

Шариат нь мусульман биш хүмүүсийн санааг зовоодог өөр нэгэн асуудал юм. Коран болон Мухаммед, түүний дотны туслахуудын хэлсэн үгс, хийсэн үйлийг агуулсан товч тэмдэглэл болох *хадит*-аас үүссэн шариатын хууль нь мусульманчуудын биеэ хэрхэн авч явах загварыг гаргаж өгөхийн зэрэгцээ Кораны шүлгүүдийг тайлбарладаг мусульман сахилгын дүрэм юм.[10] Шариатын хуулинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувцаслалтын (*хижаб* буюу гивлүүр гэх мэт) талаарх дүрэм орсон байдаг ба зарим мусульман оронд үүнийг албан ёсоор мөрддөг байхад зарим оронд энэ нь хувь хүний сонголт байдаг байна. Шариат нь мөн хувийн ариун цэвэр, залбирлын цаг, агуулга, гэрлэлт, салалт, өв залгамжлалын талаарх дүрмүүдийг хамардаг. Тиймээс мусульманчууд шариатын хуульд захирагдахыг хүсэж байгаагаа судалгаагаар илэрхийлснээрээ улс төрийн мэдэгдэл хийж эсвэл хийгээгүй ч байж болох юм. Тэд зүгээр л мусульман амьдралаар чин сэтгэлээсээ амьдрахыг хүсэж байгаагаа илэрхийлж байж болно.

Мусульман биш олон хүн исламынхны эмэгтэйчүүдэд хандах хандлагын талаар бодохдоо шууд олон эхнэртэй байх ёс болон гивлүүрийн талаар боддог. Гэхдээ соёл заншлын бодит байдал нь илүү ээдрээтэй юм. Коран дахь олон шүлэгт эмэгтэйчүүдийг эрчүүдтэй эн тэнцүү гэж тунхагласан байхад заримд нь хараат болгон тэмдэглэсэн байдаг. Исламын шашинтай олон оронд, ялангуяа исламын шашин нэвтрэхээс өмнө овог аймгийн ёс заншилтай эсвэл өмнө нь өөр уламжлалтай байсан орнуудад эмэгтэйчүүдийг хараат, сул дорой гэж үздэг. Гэхдээ мусульманчуудын эмэгтэйчүүдийн үүргийг авч үзэх өнцөг нь улс орон бүрд төдийгүй улс орон дотроо ч өөр өөр байдаг.

Исламын шашны талаарх хожмын үеийн гэгээнтнүүдийн үзэл бодол

Өөр өөр итгэл үнэмшилтэй хэдий ч хожмын үеийн гэгээнтнүүд бид мусульманчуудтай харилцаа холбоогоо хэрхэн тогтоож чадах вэ?

Юун түрүүнд бид мусульманчуудын "хэрхэн, хаана, эсвээс юуг шүтэн биширэх" (Итгэлийн тунхаг 1:11) эрхтэйг хүлээн зөвшөөрөх ёстой. 1841 онд Науву хотын зөвлөлд байсан хожмын үеийн гэгээнтнүүд "Каталок, пресбитериен, методист, баптист, хожмын үеийн гэгээнтэн, квакер, епископал, универсалист, юнитариан, сухаммедчууд [мусульманчууд] болон бусад шашны бүх бүлгэмд" "чөлөөтэй, эн тэнцүү эрхийг"[11] олгон, шашны эрх чөлөөг баталгаажуулсан хуулийг батлалцсан.

Мөн бид манай Сүмийн удирдагчид исламын шашныг үүсгэн байгуулагчид талархлаа илэрхийлэхдээ ихэнхдээ онцгой эерэг ханддаг гэдгийг санах хэрэгтэй. Тухайлбал, 1855 онд Христийн шашинтай олон хүн Мухаммедыг антихрист хэмээн буруушаахад Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жорж А.Смит (1817–75), Парлей П.Пратт (1807–57) нар исламын шашны түүхийн талаар өргөн мэдлэг, дориун ойлголттой гэдгээ харуулаад зогсохгүй, Мухаммедыг сайшааж, дэлгэрэнгүй сургаал айлдсан байдаг. Ахлагч Смит Мухаммедыг хиймэл шүтээн шүтэхийн эсрэг номлох "зорилгоор Бурхан өсгөн хүмүүжүүлсэн нь гарцаагүй" хэмээн онцлоод, хожмын үеийн гэгээнтнүүдийн адил өөрсдийнхөө тухай "үнэн шударга түүх" бичүүлж чадахгүй зовж байгаа мусульманчуудыг өрөвдөн хайрлаж байгаагаа илэрхийлж байжээ. Түүний яг дараахан ахлагч Пратт Мухаммедын сургаал болон мусульман нийгмийн ёс суртахуун, дэг жаягийг биширч байгаагаа илэрхийлсэн байдаг.[12]

1978 онд Тэргүүн Зөвлөл энэ шашны талаар хамгийн сүүлд албан ёсны мэдэгдэл гаргасан. Үүнд Мухаммедыг "дэлхийн шашны агуу удирдагчдын" нэг болохыг дурдаад, тэр тэдний нэгэн адил "Бурханы гэрлээс тодорхой хэсгийг хүлээн авсан. Бүхэл бүтэн улс үндэстэнг гэгээрүүлж, илүү өндөр түвшний ойлголтыг хувь хүмүүст өгөхийн тулд ёс суртахууны үнэнийг [энэ удирдагчдад] Бурхан өгсөн" хэмээн ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл, Н.Элдон Таннэр, Марион Г. Ромни нар бичжээ.[13]

Адил төстэй суурин дээр босгох нь

Хожмын үеийн гэгээнтнүүд болон мусульманчууд Есүс Христийн тэнгэрлэг байдал, Аврагчийн хувьд Түүний гүйцэтгэсэн үүрэг, орчин цагийн бошиглогчдын дуудлага зэрэг чухал асуудлаар ялгаатай авч үздэг ч бидэнд адил төстэй олон зүйл бий. Тухайлбал, Бурханы өмнө ёс суртахууны хариуцлага хүлээдэг; хувийн зөв шударга байдал, сайн сайхан, шударга нийгмийг байгуулахын төлөө зүтгэх ёстой мөн амилж, Бурханы өмнө шүүгдэхээр зогсоно гэдэгт бид адилхан итгэдэг.

Мусульманчууд болон хожмын үеийн гэгээнтнүүдийн аль аль нь бат бөх гэр бүлд болон ядуус, гачигдагсдад туслах тэнгэрлэг зарлигт нэн чухал ач холбогдол өгдөг ба итгэлээ шавь байснаар төдийгүй үйлдлээрээ харуулдаг гэдэгт итгэдэг. Хожмын үеийн гэгээнтнүүд болон мусульманчууд мөр зэрэгцэн алхаж, боломж гарвал шашнаас улам бүр холдсоор байгаа дэлхийд улам бүр ойртон, хөршүүд болж байгаа энэ цаг үед нийгэмд хамтарч ажиллахад болохгүй зүйл үгүй. Шашинд итгэх нь зарим шүүмжлэгчийн үзсэнчлэн зөвхөн хэрүүл тэмцэл, хүчирхийллийн эх үүсвэр биш, харин биднийг сайн үйл хийх хүчирхэг хүчин болгодгийг хамтдаа харуулж чадна.

Коран судрат бидний өөр өөр үзэл бодолтой ч хамтдаа амар тайван амьдрах арга замыг дараах байдлаар бичсэн байдаг. "Хэрэв Бурхан хүссэн байх аваас тэр та нарыг нэгэн нийгэмд оруулах байсан. Гэвч Тэр та нарт өгсөн зүйлээрээ та нарыг сорихыг хүссэн. Тиймээс сайн үйлээрээ нэг нэгэнтэйгээ өрсөлд. Та нар бүгд Бурханд эргэн ирэх бөгөөд тэр та нарын санал нийлдэггүй байсан зүйлсийн талаар ярих болно"[14] хэмээжээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Үнэн хэрэгтээ Медина руу Мухаммедын *Хижра* буюу Медина руу дүрвэсэн МЭӨ 622 оноос мусульманчуудын хуанли (*Хижри*) эхэлдэг бөгөөд Коранд цуглуулан оруулсан илчлэлтүүдийг Меккагийнх эсвэл Мединагийнх гэж хоёр ангилдаг.
2. Олон зууны турш энэ хоёр урсгал өөр бусад хоёрдогч асуудлаас болж улам бүр холдсон аж.
3. Онцлон дурдахад, хэдийгээр Кораныг өөр хэлээр орчуулахыг зөвшөөрдөг ч гэлээ, зөвхөн анхны араб хэлээр бичигдсэнийг нь Коран, жинхэнэ судар хэмээн тооцдог.
4. Qur'an 4:125-ыг үзнэ үү.
5. Qur'an 53:36-62; 87:9-19; мөн Daniel C.Peterson, "News from Antiquity," *Ensign,* 1994 оны 1-р сар, 16–21-ийг үзнэ үү.
6. Qur'an 112:3-4. Даниел Петерсоны Коран судраас хийсэн орчуулга.
7. Кораны жишиг хэвлэл нь түүнийг эн тэнцүү байлгах зорилгоор 30 тэнцүү хэсэгт хуваасан байдаг.
8. Жишээлбэл, Robert A. Pape, *Dying to Win: The Strategic Logic of Suicide Terrorism* (2005); Graham E. Fuller, *A World without Islam* (2010); Robert A. Pape and James K. Feldman, *Cutting the Fuse: The Explosion of Global Suicide Terrorism and How to Stop It* (2010)-ийг үзнэ үү.
9. Charles Kurzman, *The Missing Martyrs: Why There Are So Few Muslim Terrorists* (2011); see also John L. Esposito and Dalia Mogahed, *Who Speaks for Islam?*-ыг үзнэ үү *What a Billion Muslims Really Think* (2008); James Zogby, *Arab Voices: What They Are Saying to Us, and Why It Matters* (2010).
10. Үнэндээ энэ нь Иудейн шашны раббигийн хуультай төстэй.
11. Ordinance in Relation to Religious Societies, City of Nauvoo, [Illinois] headquarters of The Church of Jesus Christ of Latter-day Saints, March 1, 1841.
12. *Journal of Discourses,* 3:28–42-ыг үзнэ үү.
13. First Presidency statement, Feb. 15, 1978. Ричард Бэллийн *Introduction to the Qur'an* (1970) номын засаж сайжруулсан хэвлэлд исламын нэртэй эрдэмтэн, Англикан сүмийн прист Монтгомери Ватт итгэлтэй Христийн шашинтан Кораныг сүнслэг байдлаар үзэж болох нэг арга замыг өгсөн байдаг.
14. Qur'an 5:48-ыг 2:48-тай харьцуул.

ТЭР ГАЗАР ЧИНЬ ЭНЭ БАЙНА

Миний аав сүсэг бишрэлтэй Христийн шашинтан байсан бөгөөд Есүс Христэд итгэлтэй байхыг надад заасан. Тэрхүү итгэл 1960-аад оны сүүлээр намайг армид алба хааж байхад болсон гурван жилийн иргэний дайнаас амьд гарахад тусалсан юм. Гэвч дараа нь би төөрөлдөж, Сүмд явахаа болив.

Би 1981 онд Нэгдсэн Улсад сургуульд сурахаар ирэхдээ миний амьдралд Бурхан хэрэгтэй гэдгийг мэдэрсэн. Хоёр жилийн турш би Массачусеттсийн Бостонд өөр өөр сүмд явсан бөгөөд нэг нь ч надад таалагдсангүй. Би Сүнсийг мэдрэхгүй байсан тул хайхаа ч больсон юм.

1984 онд миний эхнэр Мабел Нигериэс над дээр ирснээс хойш удалгүй надад Бурхантай дахин илүү ойртож, сүмд харьяалагдах оргилуун хүсэл төрөх болов. Нигериэс зочилж ирсэн найз маань намайг сүмийг хайж байгааг мэдээгүй ч Мормоны Ном гэдэг номтой нэгэн сүмийн тухай дуулснаа надад ярилаа.

Үүний дараа би сүмийг үргэлжлүүлэн хайв. Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэж нэрлэдэг нэгэн сүмийг оллоо. *Гэгээнтэн* гэх үг миний анхаарлыг татаж билээ. Би гэгээнтэн хэмээн нэрлэгдсэн гишүүдтэй сүм байдаг гэдгийг мэддэггүй байсан ба тэр ням гарагт уг сүмд очиж үзэхээр шийдлээ.

Миний оролцсон ариун ёслолын цуглаанд хүмүүс дууллуудыг хүндэтгэл бишрэлтэйгээр дуулж; пристүүд нь талх, усыг адисалж; цуглааныг дэг журамтай, даруу төлөв явуулав. Төгсгөлд нь би үүдний танхим руу гараад, уг цуглааны талаар бодож байтал нэрээр минь дуудахыг сонслоо.

Сүнсний дуу хоолой "Симеон" гэж дуудаад, "тэр газар чинь энэ байна" гэв.

Яг тэр мөчид хоёр номлогч над руу ирж, өөрсдийгөө болон Мормоны Номыг танилцуулав. Би тэдэн рүү хараад, "Би Мормоны Номын талаар юу ч мэдэхгүй, харин Библийг бол мэднэ. Би бэлэн байна" гэж хэлсэн юм.

Тэд надад авралын төлөвлөгөөг зааж эхлэв. Сар хүрэхгүй хугацааны дараа би баптисм хүртсэн юм. Удалгүй эхнэр минь Сүмд нэгдсэн. Түүнээс хойш хэдэн жилийн дараа бид хоёр Вашингтон Ди Си ариун сүмд лацдан холбогдож мөн таван хүүхэд маань бидэнтэй холбогдсон билээ.

Ариун сүмд олон зүйл надад илчлэгдсэн ч намайг анх сүмд очиход сонссон "Тэр газар чинь энэ байна" гэх үгсийг ариун сүмд мөн ч олон удаа надад илчлэлтээр баталж байв. Ариун Сүнснээс ирсэн тэрхүү үгсийн нөлөө миний болон эхнэр, үр хүүхдүүдийн минь амьдралыг үүрд мөнхөд өөрчилсөн билээ. ■

Симеон Нах, Нигери, Аба

Намайг анх сүмд очиход сонссон үгсийг ариун сүмд мөн ч олон удаа надад илчлэлтээр баталж байсан.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

Шалтаг гаргах бүрд судраас унших хугацаа маань багассаар, эцэст нь би бараг уншихаа болив.

БИ СУДАР СУДЛАХ ҮЙЛ ЯВЦАА ХЭРХЭН СЭРГЭЭЖ БОЛОХ ВЭ?

Номлолоосоо гэртээ эргэж ирээд ердөө гурван сар болж байхад надад судраас уншихад хэцүү болж эхэлсэн юм.

Би номлолдоо өдөр бүр судар уншдаг байсан ба гэртээ очихдоо үргэлжлүүлэн уншина гэж амласан байв. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам олон зүйл иймхүү уншихад саад болж байгаа мэт санагдах болсон. Би гэрийн даалгавар ихтэй байх юм уу, ажил хийгээд завгүй эсвэл зүгээр л их ядарсан байдаг байв. Шалтаг гаргах бүрд судраас унших хугацаа маань багассаар, эцэст нь би бараг уншихаа болив.

Би нэгэн орой Мормоны Номоо нээж, нэг шүлэг уншихаар төлөвлөлөө. Миний уншсан тэр шүлэг надад судруудад "Бурханы таалалт үгийг, тийм ээ, шархадсан зүрх сэтгэлийг эдгээгч тэрхүү үг" (Иаков 2:8) байдаг гэдгийг сануулсан юм.

Би энэ шүлгийг тунгаан бодоод, судраас судлахаа больсноор надад ямар сөрөг нөлөө үзүүлж байгааг ойлгов. Би сургууль дээрээ илүү их бухимдан, сүмдээ ч бас хайхрамжгүй хандах болж, Бурханаас улам бүр холдсон мэт мэдрэх болсон юм. Миний бодгальд судартбайдаг Бурханы эдгээгч үгс хэрэгтэй байв. Би нэн чухал зүйлсээ эргэн харах хэрэгтэй гэдгээ мэдэж байлаа.

Би судар судлах үйл явцаа сэргээх талаар найз нөхөд, гэр бүл, Сүмийн удирдагчдаасаа зөвлөгөө авав. Би гурван зүйл тус нэмэр болж болохыг олж мэдсэн юм.

Нэгдүгээрт, оройн цагаар судраас судлах нь миний хувьд үр дүн багатай болохыг би ойлгосон. Өглөөгүүр судлах нь өглөө уншсан сургаал, зарчмуудын талаар өдрийн турш тунгаан бодох боломжийг надад өгдөг байв.

Хоёрдугаарт, бидэнд гэр бүлийнхэнтэйгээ хамт судраас уншихыг заасан байдаг ч би их сургуульд, гэр бүлээсээ хол байсан тул нэг өрөөнд амьдардаг хүмүүс болон найзуудтайгаа хамт судар уншиж эхлэв. Энэ нь намайг үүргээ мартахгүй байхад тусалсан бөгөөд сайн мэдээний талаар гайхалтай ярилцлага өрнүүлэхэд хүргэдэг байлаа.

Гуравдугаарт, би судраас судалж байхдаа хүлээн авсан сүнслэг өдөөлт, бодол санаагаа бичиж тэмдэглэж эхлэв. Энэ нь намайг уншиж байгаа зүйл дээрээ анхаарлаа төвлөрүүлж, Сүнсний дуу хоолойг илүү сайн олж танихад тусалсан.

Судраас судлах үйл явц амьдралын маань чухал хэсэг дахин болсноор би хийх ёстой бүх зүйлээ хийж дуусгах хангалттай цаг зав, эрч хүчтэй болсноо олж мэдсэн юм. Хамгийн гол нь би судраас уншиж, тунгаан бодсоноор Бурхантай эргэж ойртсоноо мэдэрсэн билээ. Одоо би судраас унших цаг зав гаргахдаа амар амгаланг мэдэрч, бодгалиа эдгээж чаддаг болсон. ■

Сара Кийнэн, АНУ, Юта

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРЭДЛИ КЛАРК

Авга эгч маань таван сартай хүүхэдтэйгээ хамт мангоны хоёр зулзган модны хооронд бэхэлсэн дүүжин орон дээр хэвтэж байхыг би харав.

“ГОЛ РУУ ҮСЭР!”

Нэгэн өдөр эмээ маань авга эгчид хоол бэлдээд, надаас хүргэж өгөхийг гуйв. Тэр бямба гаргийн үдээс хойш халуун байсан бөгөөд би эмээгийнхээ зараалаар явахын оронд өөр олон зүйл хийхийг хүсэж байлаа. Би эмээгээсээ миний оронд үеэлүүдийн маань нэгийг явуулахыг гуйсан ч тэр заавал намайг явах ёстой гэж зүтгэв.

Цагийн дараа би эмээгийнхээ гуйлтыг биелүүлэх ёстойгоо мэдэрч эхэлсэн. Би хоолыг аваад, авга эгчийнхээ байшин руу алхлаа. Тэднийх нэлээн зайтай байдаг болохоор би очоод удна гэж төлөвлөөгүй байв.

Авга эгч маань таван сартай хүүхэдтэйгээ хамт мангоны хоёр зулзган модны хооронд бэхэлсэн дүүжин орон дээр хэвтэж байхыг би харав. Эдгээр мод байшингийн араар урсах голын дэргэд байдаг байлаа. Би хоолоо өгөхөөр тэдний зүг алхав. Гэнэт дүүжин орны олс тасарч, авга эгч маань хүүхдийнхээ хамт гол руу өнхрөн унах нь тэр. Би айснаасаа болоод хөшиж орхив. Би хэрхэн сэлэхийг ч мэддэггүй байсан ба туслах өөр хүн эргэн тойронд байсангүй. Би юу хийхээ мэдэхгүй байлаа.

Тэр даруй би “Үсэрч ор!” гэх Сүнсний дуу хоолойг сонсов.

Би эргэлзэлгүй шууд ус руу үсрэн орж, азаар хэдхэн мөчийн дотор хүүхдийг олсон ба авга эгч маань ч уснаас гарч чадав. Би уснаас хүүхдийг аван гарч ирэхдээ болсон зүйлд итгэж ч чадахгүй байлаа. Би сэлж чадахгүй мөртлөө гол руу үсрэн орсон хэдий ч Сүнсийг сонссон учраас нялх үеэлийнхээ хамт живэхээс аврагдсан байв.

Ариун Сүнсээр дамжуулан Бурханы өгдөг удирдамж, өдөөлтийг танин мэдэж, сонсох нь ямар чухал болохыг би ойлгосон. Би эцсийн эцэст эмээгийнхээ гуйлтыг биелүүлж, авга эгчийнхээ гэрт хоол хүргэж өгсөндөө талархдаг. Бид сүнслэг өдөөлтийг мэдрэх чадвартай байхыг хичээх ёстой бөгөөд тэгснээр бид Бурханы хүүхдүүдэд туслах мутар нь байж чадна гэдгийг би мэднэ. ■

Элвин Жером Ласеда, Филиппиний Пампанга

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

ГЭРТЭЭ БАЙГАА МЭТ МЭДРЭМЖИЙГ ДАХИН ОЛЖ АВСАН

Би ахаасаа хүлээн авсан утасны дуудлагад бэлэн биш байлаа. “Ээж нас барчихлаа. Тэр унаад, толгойгоо цохисон байна” гэж ах хэлэв.

Би цочролд оров. Ээж маань нас барчихаж, харин би түүнтэй өнгөрсөн орой гэхэд л ярьж байсан шүү дээ. Би яагаад ийм явдал болсныг өөрөөсөө асуусаар л байв. Яагаад тэр намайг орхин одсоныг би ойлгохгүй байлаа. Би уурлаж бухимдсаар, хэдэн долоо хоногийн турш уурласаар байсан!

Эцэст нь би хэн нэгнийг буруутгахаар шийдлээ. Энэ бол Бурханы буруу. Тэрээр ээжийг минь надаас арай л эрт салгасан. Миний ээж амьдралын минь олон чухал үйл явдалд надтай хамт байгаагүй бөгөөд би энэ нь Бурханаас болсон гэж боддог байв. Би тухайн үед Сүмийн гишүүн байгаагүй ч сүсэг бишрэлтэй Христийн шашинтан байлаа. Би хүч чадал олж авахын тулд Бурханд найдахын оронд Түүнээс нүүр буруулан, амьдралдаа оруулахаа ч больсон юм.

Би ээжийгээ үнэхээр их санаж байв. Намайг өсөж торниж байх үед ээж, аав хоёр минь байсан учраас гэр орон маань аюулгүй газар байсан. Намайг хаа ч юу ч хийж байсан бай, ээжтэйгээ ярих юм уу цагийг хамтдаа өнгөрүүлэх мөч бүрд надад гэртээ байгаа мэт мэдрэмж төрдөг байв. Одоо миний дуртай, “гэртээ байгаа мэт” мэдрэмж үгүй болсон байлаа.

Он жилүүд өнгөрсөөр, би итгэлээ бараг бүрмөсөн алдсан байв. Яагаад ээж минь нас барах ёстой байсныг би ойлгохыг хичээж байсан ч юу ч надад амар амгаланг авчирсангүй. Гэтэл бараг нэг долоо хоногийн турш, энэ бүхнийг ойлгохын тулд тэнгэр өөд харах хэрэгтэй гэсэн бодол надад дахин дахин орж ирэх болов. Би үүнийг Сүмийн гишүүн байсан найздаа ярилаа. Тэр өөрийнхөө шашин шүтлэгийн талаар илүү ихийг мэдмээр байгаа эсэхийг надаас асуусан юм.

Би тухайн үед ойлгоогүй ч Сүнс миний бодгалийг бөх нойрноос минь сэрээсэн байлаа. Би сайн мэдээний талаар илүү ихийг суралцах тусам аюулгүй газрыг дахин олсон мэт мэдрэмжийг улам бүр мэдрэх болсон. “Гэртээ байна” гэсэн мэдрэмж надад эргэж ирэв.

Би 2013 оны 5-р сард баптисм хүртсэн. Итгэл маань эргэн ирсэнд би баярладаг. Би Бурханаас дахин нүүр буруулахаа больж, оронд нь Түүнийг хүлээн авсан юм. Ээж минь зуурдаар нас барсанд би өнөөг хүртэл харуусдаг ч Бурханд итгэх итгэлийнхээ улмаас хэзээ нэгэн өдөр ээжтэйгээ болон гэр бүлийнхэнтэйгээ хамт үүрд мөнхөд “гэртээ байна” гэдгийг мэднэ. ■

Жюди Рашер, АНУ-ын Колорадо

Ракотомалалаг сайн мэдээг сонирхож эхлэх үед хамгийн ойр байрлах сүм Сародроад байх түүний тосгоноос 50 километрийн зайд Антсирабэ хотод байдаг байв. Ракотомалала нэг найзынхаа хамт ням гараг бүр тийшээ явах арга замаа олжээ.

Өнөө үед Сародроад ням гараг бүр 100 гаруй гишүүн цуглардаг жижиг цуглааны байр бий. Тосгоныхон нь сайн мэдээг хүлээн авахыг Ракотомалала харсан. Сародроагаас дөрвөн номлогч номлолд үйлчилсэн бөгөөд Сүм улам өссөөр байна.

КОДИ БЭЛЛ, ГЭРЭЛ ЗУРАГЧИН

Ракотомалала Алфонс

Мадагаскар, Сародроа

Би сүмд явахыг хүсэж байсан ч надад автобусны мөнгө байгаагүй. Би найз Разафиндраваонасолотойгоо энэ талаар ярихад тэр бид миний дугуйг унаж болно шүү дээ гэж хэлэв. Бид ням гараг бүр Сародроагаас Антсирабэ хүртэл нэг талдаа хоёр цаг явдаг байлаа. Намайг дугуй унан ядрах үед найз минь дугуйг унаж, би ард нь суудаг байв. Харин түүнийг ядрахад бид хоёр байраа сольдог байлаа.

Эцэст нь би болон Разафиндраваонасологийн гэр бүлийнхэн Сүмд нэгдсэн юм. Сародроад салбар нээгдэх хүртэл бид Антсирабэд сүмд явдаг байв. Бид тосгондоо сүмд явах боломжтой болсондоо ямар их баяртай байсан гээч!

Ракотомалала, Разафиндраваонасоло нарын өөр олон зургийг **lds.org/go/41845**-оос үзнэ үү.

Tristan
alpas

Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн
Ахлагч Үлиссэс Соарэс

Жинхэнэ аз жаргалд хүргэх зам

Тэнгэрлэг Эцэг юу юунаас илүү бидэнд жинхэнэ бөгөөд үүрдийн аз жаргалыг хүсдэг.

"Бидний аз жаргал бол Түүний бидэнд өгдөг сайн мэдээний сургаал, зарлиг, санваарын ёслол, гэр бүлийн харилцаа, бошиглогчид, ариун сүм, бүтээлийн гоо үзэсгэлэн, тэр ч бүү хэл саад бэрхшээлтэй нүүр тулах боломж зэрэг бүх адислалын зорилго юм. . . . Бидэнд энэ амьдралд аз жаргалтай байж, мөнх оршихуйд баяр баясгалангийн бүрэн байдлыг хүлээн авах боломжийг олгохын тулд Тэр Хайрт Хүүгээ Цагаатгал хийлгэхээр илгээсэн."[1]

Газар сайгүй хүмүүс ямар нэгэн зүйлийг эрж хайж байдаг. Үнэндээ тэдний хувьд хайж буй зүйл нь аз жаргал юм. Гэвч энэ нь үнэнтэй адил "тэд үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас" (С ба Г 123:12) олон хүн аз жаргалгүй байдаг.

Тэд жинхэнэ бөгөөд үүрдийн аз жаргалыг хаанаас олохоо мэдэхгүй тул түр зуурын таашаал өгөх зүйлсээс буюу эд зүйлс худалдан авах, зүй бус зан байдлаар зохисгүй үйлдэл хийн, дэлхийнхнээс нэр төр, сайшаал магтаал эрэлхийлэх эсвэл бие махбодын гоо үзэсгэлэн, дур булаам байдалд анхаарах гэх мэтээс аз жаргалыг эрэлхийлдэг.

Ихэнх тохиолдолд таашаалыг аз жаргалтай андуурдаг. Хүмүүс хэр зэрэг түр зуурын таашаал эрэлхийлнэ, тэр хэрээр илүү аз жаргалгүй болдог мэт санагддаг. Зугаа цэнгэл нь ихэвчлэн богино хугацаанд үргэлжилдэг.

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) "Чи түр зуурын таашаал авч болно, тийм ээ, гэхдээ чи баяр хөөр, аз жаргалыг олж авч чадахгүй. Аз жаргал бол мөнх амьдрал руу хөтөлдөг нарийн хэрнээ шулуун, хүний хөлд дарагдсан замын хажуугаас л олддог юм"[2] гэж хэлсэн.

Харамсалтай нь олон хүний хувьд аз жаргалыг олоход хэцүү байдаг. "Аз жаргал нь сэтгэл санааны энгийн өөдрөг байдлаас илүүтэй утга учиртай, гүнзгий сэтгэл ханамжаар дүүрэн хангалуун амьдралыг хүрээлдэг сайн сайхан аж байдлыг хэлдэг" гэдгийг эрдэмтэд мэддэг.[3]

Аз жаргал бол нэг үйл явдлаас нөгөө рүү үсчихийн үр дүн биш гэдгийг судалгаа харуулдаг. Харин аз жаргалыг олж авахын тулд ихэвчлэн амьдралдаа илүү чухал ямар нэгэн зүйлийн төлөө урт удаан хугацааны туршид хичээл зүтгэл гаргах хэрэгтэй байдаг байна. Аз жаргал нь бидний санаатай үйлдлээрээ шууд харуулдаг дадал хэвшил, биеэ авч явах байдал, бодол санааны хэв загвараар тодорхойлогддог. Үнэндээ аз

Бидний хүн нэг бүр Их Эзэнийг хайрлаж, аз жаргалд хүргэх Түүний замыг дагах болтугай.

КАЛИФОРНИЙН ОАКЛЭНД АРИУН СУМИЙН ӨМНӨ БУЙ ХОС

жаргалын маань ихэнх хэсэг бидний “хувь хүний хяналтан доор байдаг.”[4]

Судруудад байдаг болон орчин цагийн бошиглогч, төлөөлөгчдийн заадаг аз жаргалын замуудын заримынх нь ач холбогдлын талаар бүгдээрээ авч үзье. Тэдгээр зам дээр итгэлтэй, бат алхах нь өмнөө байгаа аяллынхаа туршид аз жаргалтай байх боломжийг бидэнд олгодог.

Ариун журам

Эдгээр замын эхнийх нь ариун журам бөгөөд энэ нь ёс суртахууны өндөр жишигт суурилсан бодол санаа, зан байдлын хэв загвар юм. Энэ нь Их Эзэний ариун сүмд орох боломжийг танд олгодог ариун явдал, ёс суртахууны цэвэр ариун байдалд төвлөрдөг. Ариун журамт хүмүүс цаанаасаа л хүмүүсийн хүндлэлийг хүлээсэн, сэтгэлийн хаттай хүмүүс байдаг. Тэд Ариун Сүнсийг хүлээн авахуйц зохистой бөгөөд Түүгээр удирдуулагддаг тул өөрсдөдөө итгэлтэй байдаг. Ариун журам нь зүрх сэтгэл, оюун санаанд эхэлдэг ба өдөр бүр хийдэг олон мянган жижиг шийдвэр, үйлдлийн нийлбэр юм.

“Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг, тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болно, мөн санваарын сургаал тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно.

Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн чиний очир таяг, зөв шударга ёс хийгээд үнэний хувиршгүй очирт таяг байх болно; мөн эзэгнэл чинь үүрдийн эзэгнэл байх болно; мөн албадлагын арга хэрэгсэлгүйгээр энэ нь чам руу үүрд мөн мөнхөд урсах болно” (С ба Г 121:45–46).

Ерөнхийлөгч Томас С. Монсон: “Таны эрүүл саруул ухаан, ёс суртахууны цэвэр байдлаас илүү үнэ цэнтэй нөхөрлөл гэж үгүй. Өөрийн томилогдсон газраа цэвэр ариун, мөн тэнд байх зохистой гэдэгтээ итгэлтэй байх нь ямар гайхалтай сайхан мэдрэмж байх билээ”[5] хэмээн хэлсэн.

Шударга байдал

Аз жаргалд хүргэх хоёр дахь зам бол шударга байдал юм. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт (1928–2015)

"Үүрдийн аз жаргал нь танд юу байгаагаас биш, харин та ямар хүн бэ гэдгээс ирдэг болохыг ойлго.

Жинхэнэ баяр баясгалан шударга зан чанараас ирдэг бөгөөд энэ нь тогтмол гаргаж байсан зөв шударга шийдвэр дээр үндэслэгдэн бий болсон хэв загварт суурилсан байдаг. . . . Гаргасан зөв шударга шийдвэрүүд тань таны хэн болохыг мөн танд юу чухал болохыг тодорхойлдог. Тэдгээр нь зөв зүйлийг үйлдэхэд улам бүр хялбар болгож өгдөг. Одоо болон амьдралынхаа бүхий л үед аз жаргалтай байхын тулд Их Эзэнд туйштай дуулгавартай бай"[6] гэж хэлжээ.

Бид судраас судалж байхдаа Их Эзэний бидэнд өгсөн амлалтууд зөв шударга амьдрахад биднийг урамшуулан дэмждэг болохыг мэдэж авдаг. Тэдгээр амлалт нь ёс зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ буурч буй энэ дэлхийн амьдралын өдөр тутмын бэрхшээлтэй нүүр тулгарах үедээ ч бууж өгөхгүй байх урам зоригийг бидэнд өгснөөр бодгалийг маань тэтгэж, итгэл найдвар авчирдаг. Тиймээс бодол санаа, хэл яриа, үйлдэл маань Тэнгэрлэг Эцэгт хүргэх зам руу биднийг хөтөлж байгаа эсэхэд бид анхаарах хэрэгтэй.

Итгэлтэй байдал

Аз жаргалд хүргэх гурав дахь зам бол итгэлтэй байдал юм. Бурхан биднийг тэнгэрлэг зорилго, мөнхийн алсын хараа бүхий амьдралын эх үүсвэр болдог итгэлийн маань дагуу адисалдаг гэдгийг ойлгох нь чухал. Итгэл бол хичээнгүй байдлыг өдөөдөг бодит зарчим юм. Энэ нь бидний эерэг хандлага ба Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын биднээс хийхийг хүссэн бүх зүйлийг дуртайяа хийх хүслээс харагддаг. Энэ нь биднийг өвдөг сөхрөн, Их Эзэнээс удирдамж хүсээд мөн босож, Түүний хүсэлтэй нийцэх зүйлсийг гүйцэлдүүлнэ гэдэгт итгэж үйлдэхэд урамшуулдаг.

Таныг аяллаа цааш үргэлжлүүлэх явцад Их Эзэн Бурханы зарлигласан бүх зүйлийг хийх нь үү, үгүй юу гэдгийг чинь сорьж шалгана (Абрахам 3:25). Энэ бол мөнх бус амьдралд олж авах туршлагын нэгэн хэсэг юм. Энэ нь Христэд туйштай итгэн, Сүнсээр удирдуулж, Бурхан бидний хэрэгцээг хангана гэдэгт итгэж найдан, урагш тэмүүлэхийг биднээс шаарддаг.

Үнэхээрийн хэцүү байдалд орсон үедээ ч гэсэн та Христэд гуйвшгүй итгэдэг хэвээр байх ёстой гэдгээ бүү март. Хэрэв та туйштай байж чадах юм бол Их Эзэн амьдралын саад бэрхшээлийг даван туулах чадварыг тань өсгөн нэмэгдүүлнэ. Та сөрөг өдөөлтийг дарах боломжтой болж, бүр давж гарах боломжгүй мэт санагдах саад тотгорыг ч даван туулах чадварыг хөгжүүлнэ.

Ариун байдал

Аз жаргалд хүргэх өөр нэгэн зам бол ариун байдал ба энэ нь сүнслэг болон ёс суртахууны хувьд төгс байхтай холбоотой. Ариун байдал нь сэтгэл зүрх, хүсэл эрмэлзэл цэвэр ариун байгааг харуулдаг. Бид ийм бурханлаг зан чанарыг хөгжүүлэхийн тулд хэрхэн өдөр бүр өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд тэжээхээр хөдөлмөрлөж болох вэ?

Ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973) дараах байдлаар энэ асуултад хариулсан. Тэрээр: "Бид даллага сургуулилтаар өөрсдийн сүнслэг хувилбарыг хөгжүүлдэг. . . . Бид залбирч, өдөр бүр сайн үйлс хийн, бусадтай хуваалцсанаар сүнсний дасгал сургуулилтаа хийх ёстой. Бид өдөр бүр судраас суралцан, [гэр бүлийн үдэш] хийж, цуглаануудаа оролцож, ариун ёслолоос хүртэх замаар сүнсээ тэжээх ёстой. . . .

Зөв шударга хүн өдөр бүр наманчлах хэрэгтэй гэдгээ мэддэг учраас өөрийгөө хөгжүүлэхийг хичээдэг"[7] гэсэн байна.

Ариун байдлын өөр нэгэн чухал хэсэг бол ариун сүмд гэрээнүүд хийж, тэдгээрийг сахихтай холбоотой. Хэрэв бид итгэлтэй байх юм бол эдгээр гэрээ нь биднийг өөрийн хүч чадал, харах өнцгөөс хальж, илүү их өндөрлөгт хүргэх боломжтой. Бид ариун сүмд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн өмнө хийдэг ёслол, гэрээнүүддээ үнэнч байх юм бол Есүс Христийн сайн мэдээний амлагдсан бүх адислал бидниих

ПРОВО ХОТЫН ТӨВ АРИУН СҮМ

болох боломжтой. “Аз жаргалтай хүмүүний ёсоор” амьдрах загварын нэгээхэн хэсэгт шүтэн бишрэх ба Их Эзэнтэй гэрээ хийх боломжтой ариун сүмийг барих нь ордог (2 Нифай 5:16, 27-г үзнэ үү).

Энэ замд онцолбол зохих нэг зүйл бол бид сүнслэг байдлаа хөгжүүлэн, ёс суртахууны хувьд цэвэр ариун байхад анхаарах ёстой явдал юм.

Дуулгавартай байдал

Бурханы бүх зарлигийг сахих нь аз жаргалд хүргэх өөр замуудтай холбоотой. Нифайчууд леменчүүдээс салсныхаа дараа “Их Эзэний тогтоол, дүрэм, зарлигуудыг бүх зүйлд, Мосегийн хуулийн дагуу даган мөрдөж байсан” (2 Нифай 05:10)-ыг үзнэ үү) тул тэд үлэмж ихээр дэгжин хөгжсөн. Энэхүү загвар нь “аз жаргалтай хүмүүний ёсоор” амьдрахын өөр нэгэн чухал хэсэг билээ.

Ерөнхийлөгч Монсоны зааснаар “Бид зарлигуудыг сахивал амьдрал маань илүү аз жаргалтай, утга учиртай, ээдрээ багатай болно. Бид бэрхшээл, асуудлуудаа давж гарахад илүү амар болж, [Бурханы] амласан адислалыг хүлээн авах болно.”[8] Тэр мөн “Бид хайж буй мэдлэг, хүлээж буй хариултуудаа болон энэхүү түвэгтэй, хувирамтгай дэлхийн бэрхшээлүүдийг даван туулахад туслах хүч чадлыг Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагаснаар л олж авч чадна”[9] гэж хэлсэн.

Аврагч бидэнд

“Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. . . .

Миний тушаалуудыг сахидаг хүн Намайг хайрлагч мөн. Намайг хайрладаг хүн Миний Эцэгт хайрлагдана. Би тэр хүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд илчилнэ” (Иохан 14:15, 21) хэмээн заасан.

Амь биеэ үл хайрлах байдал ба хайр

Аз жаргалд хүргэх хамгийн сайн арга зам бол амь бие үл хайрлан зүтгэж, хайрлах—бүх амьд бодгаль бүрд санаа тавин, сонирхож, ямар нэгэн байдлаар энэрэх явдал юм. Хайр бол бидний болон бусдын амьдралыг баяжуулж, адислах аз жаргалд хүргэх шулуун зам юм. Энэ нь Аврагчийн хэлснээр дайснуудаа хүртэл хайраа үзүүлэхийг хэлнэ (Матай 5:44-ийг үзнэ үү).

Ингэснээр та Бурханыг хайрла гэсэн агуу зарлигийг биелүүлнэ. Та бузар булай, уналтад хүргэгч, гашуун тааламжгүй салхины дээгүүр өнгөрөх болно. Жинхэнэ бөгөөд үүрдийн аз жаргал зөвхөн бид “бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ [хайрлах]” (Матай22:37; мөн Дэд хууль 6:5; Марк 12:30; Лук 10:27-г үзнэ үү) үед л ирдэг.

Бидний хүн нэг бүр Их Эзэнийг хайрлаж, “бидний оршихуйн эцсийн зорилго ба загвар”[10] болох аз жаргалд хүргэх Түүний замуудыг дагахыг сонгох болтугай. ■

2017 оны 6-р сарын 8-нд Хавай дахь Бригам Янгийн Их Сургуулийн төгсөлтийн баяр дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. “Happiness,” Gospel Topics, topics.lds.org.
2. David O. McKay, in Conference Report, Oct. 1919, 180.
3. “Happiness,” *Psychology Today,* psychologytoday.com/basics/happiness.
4. “Happiness,” *Psychology Today,*
5. Thomas S. Monson, “Examples of Righteousness,” *Liahona,* May 2008, 65.
6. Richard G. Scott, “Making the Right Decisions,” *Ensign,* May 1991, 34.
7. *Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* (2000), 176178.
8. Томас С.Монсон, “Зарлигуудыг сахь,” *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 69.
9. Томас С.Монсон, “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 104.
10. Joseph Smith, in *History of the Church,* 5:134.

Жинхэнэ аз жаргал гэж юу болохыг **lds.org/go/41849** дээрээс мэдэж авна уу.

Гэрлэлт, мөнгө, итгэл

Сандэй Чибуйкэ Обаси

Би аль хэдийн сүй тавьсан байсан тул Ганагийн Кумасид болсон ганц бие залуучуудын уулзалтад найз бүсгүйтэй болох гэж оролцоогүй ба харин надад илүү их урам зориг хэрэгтэй санагдаж байсан болохоор үүнийг олж авах зөв газар нь тэрхүү уулзалт байсан юм. Үнэндээ ганц бие залуучуудтай ажиллахаар томилогдсон ахмад номлогч Кол эгч ариун сүмийн гэрлэлтийн ач холбогдлын тухай ярьсны дараа миний залбирлын хариулт ирсэн билээ.

Ярилцлагын төгсгөл хавьд түүний царай гэнэт өөрчлөгдөн, "Гэрлэхийн тулд та нарт мөнгө хэрэггүй. Ганцхан итгэл л хэрэгтэй" гэж хэлсэн. Тэр яг надад хандан ярьж буй мэт санагдсан ч бид хуримд бэлдэхийн тулд хэд хэдэн зүйл худалдан авах хэрэгтэй байсан учраас надад хамаагүй гэж би бодсон юм. Би өөрөө өөртөө "Яагаад надад мөнгө биш, зөвхөн итгэл хэрэгтэй вэ?" гэж хэлж билээ.

Тухайн долоо хоногийн турш би энэ тухай дахин дахин бодсон. Тэгэх явцдаа би өөрөөсөө "Бурханы хийж чадах зүйлд хязгаар байдаг болов уу?" гэж асууж билээ. Эхэндээ би байхгүй гэж бодсон ч дараа нь байдаг гэж бодсон. Харин дараа нь "Тэр бүхнээс хүчтэй юм бол яагаад хязгаарлагдмал байдаг билээ?" гэсэн асуулт надад орж ирэв. Сүнс надад "Бурханы адислалууд бидний дуулгавартай байдлаас хамаардаг" хэмээн хариулж, зааж өгсөн юм. Түүний биднийг адислах чадвар хязгааргүй боловч бид Түүний биднээс хийхийг хүссэн зүйлийг хийж, итгэлээ хэрэгжүүлснээр ирдэг адислалуудыг урин авчрах ёстой.

Дараа нь би хуримынхаа төлөвлөгөөний талаар ярилцахаар сүйт бүсгүй Присцилла руугаа утасдав. Бидэнд мөнгө хангалттай байгаагүй бөгөөд хурим хийх өдрөө сонгохоор шийдсэн хэдий ч өдрөө тодорхой сонгож чадахгүй байлаа. Бид бишопоосоо тойрог, гадасны хуанлид сул өдөр байгаа эсэхийг асуух нь зүйтэй гэдэгт санал нэгдэв. Бишопынхоо санал болгосон хоёр өдрөөс бид 2014 оны 9-р сарын 27-ыг сонгосон ба бидэнд хуримын өдөр хүртэл ойролцоогоор долоон долоо хоног үлдсэн байлаа!

Сүйт бүсгүйтэйгээ гэрлэхээс минь өмнө тийм ч их цаг хугацаа байгаагүй ба мөнгө төгрөг бага байсан хэдий ч бидэнд илүү чухал нэгэн зүйл байсан бөгөөд тэр нь итгэл байлаа.

Присциллаг "*Обим* [игбо хэлээр "миний зүрх" гэсэн утгатай үг], чамд мөнгө байгаа юу? Бидэнд хуримдаа бэлтгэх цаг бага байна" гэж асуухад нь

би "Байхгүй ээ, гэхдээ надад итгэл бий" гэж хариулав.

Тэр инээгээд, "За, за. Хоёулаа тэгвэл мацаг барьж, залбиръя даа" гэж билээ. Тэр 1 Нифай 3:7-г өөрийнхөө үгээр "Их Эзэн бидэнд замыг бэлтгэх болно, учир нь Тэр биднийг гэрлэхийг зарлигласан" гэж хэллээ.

Би тэр долоо хоногт хэдэн сарын өмнө хийж дуусгасан ажлынхаа хөлсийг авсан юм. Дараа нь Присцилла илүү их мөнгө олохоор бизнес эхлүүлэхийг хүсэж байгаагаа надад хэлэв. Тэр олсон мөнгөөр маань эмэгтэй хүний хуучин цүнхнүүд худалдан аваад, буцаан зарлаа. Хэрэгтэй зүйлсийнхээ жагсаалтад орсон зарим зүйлийг худалдан авсны дараа түүнд миний өгсөн мөнгөнөөс лав хоёр дахин илүү мөнгө үлдсэн байв.

Тухайн хугацаанд надад ямар ч ажил орж ирээгүй бөгөөд хийхээр тохирсон бүх ажил нурсан юм. Бидэнд хоёр долоо хоног үлдсэн байсан ба авах хэрэгтэй зүйл олон байлаа. Сүйт бүсгүй минь хугацаагаа хойшлуулахыг хүсэхэд би "Гайхамшиг болно" гэхээс өөр зүйл хэлсэнгүй.

Бидний хуримын өдрөөс хоёрхон хоногийн өмнө гайхамшиг тохиолдож, би хоёр долоо хоногийн өмнө хийсэн ажлынхаа хөлсийг авав. Түүнээс гадна, Их Эзэн биднийг итгэлтэй байж, шаргуу хөдөлмөрлөх юм бол зөв шударга зорилгоо биелүүлэхэд маань адисална гэдгийг би ойлгож мэдсэн билээ.

Бид итгэлийнхээ үйлдлийг Бурхан зөвшөөрсний бэлгэдэл гэж үзсэн аадар бороон дундуур чекээ бэлэн мөнгө болгохоор банк руу явж, тэндээсээ шаардлагатай зүйлсээ авахаар шууд зах руу явсан юм.

24 цаг ч хүрэхгүй хугацааны дараа бид хоёр гэрлэв. Биднийг хуримын тангаргаа солилцохыг хүсэх тэр мөчид би амьдралдаа урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүй нэгэн мэдрэмжийг мэдэрсэн. Надад их зүйл хийсэн гэсэн мэдрэмж төрсөн ба би тэр үеэс эхлэн итгэлээр бүх зүйлийг хийж чадна гэдэгт итгэх болсон. Дараа нь бид Ганагийн Аккра ариун сүмд лацдан холбуулж билээ.

Хэдийгээр танд гэрлэлтэд бэлтгэхэд *ямар нэгэн* мөнгө хэрэгтэй ч хамгийн хэрэгтэй чухал зүйл бол итгэл юм. ■

Зохиогч нь Ганагийн Ашанти мужид амьдардаг.



“Хэрэв надад итгэлээ алдаж байна гэсэн мэдрэмж төрвөл итгэлээ эргүүлэн олж авахын тулд би юу хийж болох вэ?”

“Сүмийн зорилгуудын нэг бол зарим үед итгэлийн үрийг бүр эргэлзээ бүхий болон итгэлгүй байдлын элсэрхэг хөрсөнд тарьж, арчилж ургуулах явдал ч байдаг. . . .

. . . итгэлдээ эргэлзэхээсээ өмнө эргэлзээндээ эргэлз.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд”, 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган.

Судруудад ханд

Надад Сүнс мэдрэгдэхгүй хэцүү байх үед судруудад хандаж, хүн бүрийн итгэлийг олж харах нь тусалдаг. Энэ нь надад итгэл төрүүлдэг. Магадгүй залбирал тань хэт богино байсан байж болно. Залбирлаа илүү чин сэтгэлээсээ хийхийг хичээх бол Тэнгэрлэг Эцэг итгэлээ эргүүлэн олж авахад тань тусална.

Крис Б, 14 настай, АНУ, Орегон



Итгэлийн үрийг тордох нь

Би Эцэгт хандан залбирч, ургуулж буй итгэлийн ургамлаа арчлахад туслахыг Түүнээс хүсэж болно гэдгээ мэднэ. Би итгэлээ тордохын тулд судруудаас уншин, сүнслэг туршлагыг эрэлхийлж, адислалаа тоолон, гэр бүлийнхнээсээ тусламж хүсэх зэрэг шаардлагатай зүйлсийг заавал хийх ёстой. Ийм арга замаар миний итгэл дахин өсөж эхэлнэ. Энэ нь нэг шөнийн дотор хийгдэхгүй бөгөөд энэ үйл явцад цаг хугацаа шаардлагатай. Би тэвчээртэй байж, Их Эзэнд найдах хэрэгтэй.

Элиас Б., 18 настай, Аргентин, Мендоза



Хамтдаа хариултыг ол

Надад итгэлээ алдаж байна гэсэн мэдрэмж төрөх үед би ээж аавтайгаа ярилцаж, хамтдаа хариултыг олдог. Заримдаа бид ярилцсаныхаа дараа Сүнсийг мэдрэхийн тулд урам зориг өгөх дуу дуулдаг.

Эммалий К., 15 настай, АНУ, Колорадо

Эцэг эхээсээ асуу

Бид шууд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахын зэрэгцээ хэрхэн Түүн рүү эргэн очиж, итгэлээ эргүүлэн авч болох талаар эцэг эхээсээ асууж болно.

Элиас., 12 настай, Уругвай, Пэйсанду

Залбир, холбоо барь, унш

Би итгэлээрээ уналтад орж байсан хүний хувьд итгэлээ эргүүлэн олж авахын тулд дараах гурван зүйлийг хийсэн. Тухайлбал: Нэгдүгээрт, би залбирсан. Хүч чадал олж аван, юу хийх ёстойгоо олж мэдэхийн тулд залбирсан маань үр дүнтэй байсан. Хоёрдугаарт, би дотны найзууддаа хэлсэн бөгөөд тэд хэрэгтэй үед маань надад маш их тусалсан. Гуравдугаарт, би судруудаа уншсан. Ихэнх судар итгэлтэй холбоотой байдаг бөгөөд бидэнд итгэлээ эргүүлэн олж авахад тусалдаг.

Жак Ж., 14 настай, АНУ, Флорида

Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Яагаад Бурхан дайныг хүлээн зөвшөөрдөг вэ?

Дайн нь энэ дэлхий дээрх хүн төрөлхтний түүхийн эхэн үеэс нэг хэсэг нь байсаар ирсэн. Гэхдээ биднийг нэг нэгэнтэйгээ дайтахыг Их Эзэн, Энхийн Жонон хүсдэггүй. Хүмүүс бие биенээ хайрлахгүй байх сонголтыг хийж, мөн “хайрлах сэтгэл алга, мөн . . . өөрсдийнхөө цусан төрлийнхнийг үзэн яддаг” (Мосе 7:33), дэлхийг хүчирхийллээр завхруулж (Эхлэл 6:11–13) байгаад тэр үйлдаг. Ёс бус явдлынхаа улмаас дэлхийд дайн авчирдаг хүмүүсийг үйлдлийнх нь дагуу шүүх болно.

Их Эзэн Өөрийн хүмүүст “дайнаас татгалзаж, энх тайвныг тунхагла” хэмээн зарлигласан (С ба Г 98:16). Хэдий тийм боловч улс үндэстнүүдийг бие биенийхээ эсрэг дайтах үед зарим үед гэр бүлээ болон улс орон, эрх чөлөөгөө сүйрэл, харгис хэрцгий явдал, дарангуйллаас хамгаалах нь зүйтэй хэмээн Их Эзэн мөн хэлсэн байдаг (Алма 43:47; Алма 46:12–13; С ба Г 134:11-ийг үзнэ үү). Мөн улс орныхоо зэвсэгт хүчинд зүтгэдэг хожмын үеийн гэгээнтнүүд “хаад, ерөнхийлөгчид, удирдагчид, мөн шүүгчдэд захирагдах” (Итгэлийн тунхаг 1:12) зарчмыг баримталдаг.

Энэ талаар илүү ихийг Gordon B. Hinckley, “War and Peace,” Apr. 2003 general conference; “War,” Gospel Topics, topics.lds.org-оос үзнэ үү.

Дараагийн асуулт

“Шийдвэр гаргахад патриархын адислал маань хэрхэн тусалж болох вэ?”

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар (“Өгүүлэл эсвэл санал оруулах” дээр дар) 2018 оны 5-р сарын 15-ны дотор илгээнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах магадлалтай.

ЗАЛБ

Иосеф Смитийн үлгэр жишээ болон Сэргээлтийн загварыг дага.

ИРАЛ

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Робэрт Д.Хэйлс (1932–2017)

ГЭРЧЛЭЛ БА СЭРГЭЭЛТИЙН ТҮЛХҮҮР

Судруудад ханд. Өвдөг сөгдөн залбир. Итгэлтэйгээр асуу. Ариун Сүнсийг сонс.

Сүмийн удирдагчдын хувьд биднээс "Би Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний тухай хэрхэн гэрчлэлтэй болж болох вэ?" гэж үргэлж асуудаг.

Гэрчлэлтэй болж, хөрвөгдөхийн тулд судраас судлах болон залбирах зэргээр эхэлж, дараа нь тэвчээртэйгээр сайн мэдээний дагуу амьдарч, Сүнсэнд итгэж найдаж амьдрах хэрэгтэй. Иосеф Смитийн амьдрал болон Сэргээлтийн загвар энэхүү үйл явцын тод жишээ мөн. [Намайг]…та нартай Сэргээлттэй холбоотой үйл явдлуудыг хуваалцаж байх үед гэрчлэлд хүргэх алхмуудыг олж харахыг хичээгээрэй.…

ВОЛТЕР РЭЙНИЙ *МИНИЙ ЗҮРХНИЙ ХҮСЛЭН II*, БҮТЭЭЛЭЭС © GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Их будлиан

Иосеф Смит 1805 оны 12-р сарын 23-нд АНУ-ын Вермонт мужийн Шарон хотноо залбирч, Библиэс суралцдаг байсан гэр бүлд мэндэлжээ. Тэрээр өсвөр насандаа шашныг сонирхох болж, Христийн сургаалын талаар "санваартан санваартныхаа эсрэг, түүнчлэн хөрвөгч хөрвөгчийнхөө эсрэг" байдаг "их будлиан" болж байгааг олж мэдсэн байна (Иосеф Смит—Түүх 1:6).

Энэ будлиан нь . . . олон зуун жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд Их урвалт хэмээн нэрлэгддэг байв. Төлөөлөгч Паул "Эхлээд итгэлээс салах явдал [гарахаас нааш]" Христийн өдөр "ирэхгүй" гэж хэлсэн (2 Тесалоник 2:3).

Христийн Амилалтаас хойш хэдэн арван жилийн дараа Түүний төлөөлөгчид алуулж, сургаал өөрчлөгдөн, санваар дэлхийгээс авагдав. Гэвч Паул бидний цаг үеийн талаар, "Энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд [Их Эзэн] бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ" хэмээн бошиглосон юм (Ефес 1:10) юм. Тэрээр Христийн үнэн Сүмийг дэлхий дээр дахин сэргээнэ. . . .

Иосеф хариултыг олсон нь

Иосеф . . . , 14 настайдаа, "[шашны] санаа бодлын үймээн самуунтай" үед амьдарч байгаагаа мэдсэн. "Хэрэв [эдгээр сүмээс] аль нэг нь зөв бол, аль нь бол, тэгвэл би үүнийг яаж мэдэх вэ?" хэмээн өөрөөсөө үргэлж асуудаг байлаа. (Иосеф Смит—Түүх 1:10).

Иосеф хариултыг олохоор Библийг судлав. "Хэрэв та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно" (Иаков 1:5) хэмээн тэр Иаковын номоос уншлаа.

Иаковын зөвлөгөөг даган Иосеф Бурханаас асуухаар гэрийнхээ ойролцоох ойн цоорхойд очиж, залбирчээ. Тэрээр Бурханыг дуудахад "гэрлэн багана . . . доош бууж ирэн" үд дундын нарнаас илүү хурц гэрэлтэй байсан ба "хоёр Хүн" гарч ирэв. "Тэдний нэг . . . ярьж, [Иосефыг] нэрээр [нь] дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—*Энэ бол Миний Хайртай Хүү. Түүнийг сонс!" гэж хэлэв.* (Иосеф Смит—Түүх 1:16–17).

Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр Иосеф Смиттэй ярилцжээ. Тэд түүний асуултад хариулан, түүнд Христийн үнэн Сүм дэлхийгээс алдагдсан болохыг заав. Иосеф Бурхан Тэргүүтэний эдгээр гишүүн тус тусдаа, өөр өөр биес болохыг мэдэж авсан. Тэд Иосефыг нэрээр нь мэдэж байсан ба түүний залбиралд хариулахад бэлэн байв. Тэнгэр нээгдэж, урвалтын шөнө дуусаж, сайн мэдээний гэрэл гэрэлтэж эхэллээ.

Иосефын нэгэн адил, бидний дундаас олон хүн үнэний гэрлийг эрэлхийлдэг. . . . Иосефын нэгэн адил бид судраас эрэлхийлэн, залбирч, . . . даруу [байж], итгэлээ хөгжүүлж [сурах] ёстой.

Моронай ба алтан ялтас

Анхны Үзэгдлийн дараах гурван жилийн туршид Иосеф [өөрийн сул тал болон төгс бус байдлынхаа улмаас байнга шантарч байсан гэдгээ хэлсэн байдаг]. Гэхдээ тэр итгэлээ алдаж, залбирлын хүчийг мартаагүй юм.

1823 оны 9-р сарын 21-нд, 17 настайдаа [Иосеф] өвдөг сөхрөн "[өөрийн] бүх нүглүүдээ өршөөнө үү" хэмээн гуйж . . . мөн "[Бурханы] өмнө хэрхэн зогсож байгаагаа" [мэдэхийг] хүссэн аж (Иосеф Смит—Түүх 1:29-ийг үзнэ үү). Түүнийг залбирахад гэрэл . . . гарч ирэн, тодрон тодорсоор, "тэр өрөөг үд дундынхаас илүү гэрэлтэй мэт бол[сон" байна (30-р шүлэг). Тэр гэрэлд "тансаг цав цагаан" орхимжтой нэгэн хүмүүн зогсож байлаа (31-р шүлэг). Тэр Иосефыг нэрээр нь дуудаад, өөрийгөө Моронай хэмээн танилцуулав. Тэрээр "[Иосефт] зориулсан нэгэн ажил Бурханд бий" гэдгийг, мөн "алтан ялтсууд дээр бичигдсэн" эртний цэдгийн тухай хэлсэн бөгөөд тэрхүү цэдэг хожим нь орчуулагдан Мормоны Ном болсон билээ. Уг номд сайн мэдээний бүрэн байдлын цэдэг агуулагдсан байв. (33-34-р шүлгийг үзнэ үү.) . . . Иосефт . . . тэр цэдэг нь . . . ойролцоох Кумора [гүвээнд] . . . булагдсан болохыг үзүүлсэн.

Дараа өдөр нь Иосеф ялтаснуудыг олсон боловч тэдгээрийг авчрах цаг арай болоогүй байлаа. Моронай Иосефт ирэх дөрвөн жилийн турш яг тэр өдөр уг газарт ирж өөртэй нь уулзахыг зааварласан аж (52–53-р шүлгийг үзнэ үү). Иосеф дуулгавартай дагав. Жил бүр тэр гүвээ рүү

Сэргээлтийн гол үйл явдлууд бүгд залбирлаар эхэлсэн.

явж, Моронайгаас Христийн Сүмийн Сэргээлтийн талаар “заавар” (54-р шүлэг) авч байлаа. . . .

Иосеф ялтаснуудыг 1827 оны 9-р сарын 22-нд 21 насандаа хүлээн авав. Тэр мөн ялтаснуудыг орчуулах Урим ба Туммим гэгддэг эртний хэрэгслийг хүлээн авсан байна. Энэ ариун нандин хөрвүүлэгчийг ашиглан Ариун Сүнсний хамтаар Иосеф орчуулгын ажлаа эхэлсэн. . . .

Сэргээлт өрнөж эхлэв

23 насандаа Иосеф ялтаснуудыг орчуулж байхдаа [өөрийн бичээч] Оливер [Каудерийн] хамт нүглүүдийн ангижралын тулд хийгдэх баптисмын талаарх шүлэгтэй таарчээ. . . . Тэд илүү ихийг мэдэхийг хүссэн бөгөөд Иосеф юу хийхээ мэдэж байлаа.

1829 оны 5-р сарын 15-нд [Иосеф, Оливер хоёр] Их Эзэнээс асуухаар ой руу очив. Тэднийг залбирч байхад Иохан Баптист “гэрэлт үүлэн дотор” үзэгджээ (Иосеф Смит—Түүх 1:68). Тэр . . . амьд байхдаа Авраг-чид баптисм хүртээсэн [бөгөөд] Бурханы эрх мэдлээр тэрхүү ёслолыг хийж гүйцэтгэх санваарын түлхүүрүүдийг атгадаг байв.

. . . Иохан . . . [Иосефын толгой дээр, дараа нь Оливерынх дээр] гараа тавьж, тэдэнд [хоёуланд нь] Аароны санваар хүртээсэн байна (С ба Г 13; Иосеф Смит—Түүх 1:68–69-ийг үзнэ үү). . . . 1829 оны 5-р сарын сүүлээр эсвэл 6-р сарын эхээр төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар Иосеф, Оливер хоёрт дээд санваар буюу Мелкизедек санваарыг хүртээв.

Мормоны Номын орчуулга тэр 6-р сард дууссан бөгөөд уг ном 1830 оны 3-р сарын 26-нд хэвлэгдэн гарав. . . . Хэдэн өдрийн дараа 4-р сарын 6-нд Сүм албан ёсоор зохион байгуулагджээ. . . . Паулын бошиглосноор Христийн эртний Сүм дэлхий дээр дахин байгуулагдсан байв.

Гэвч Сэргээлтийн ажил дуусаагүй байлаа. . . . [Энэ эрин үед баригдсан хамгийн анхны ариун сүм болох Көртландын ариун сүм] . . . 1836 оны 3-р сарын 27-нд онцгойлон адислагдав. Долоо хоногийн дараа буюу 4-р сарын 3-нд тэнд нэгэн уулзалт болсон аж. Хүндэтгэлийн, чимээгүй залбиралд, . . . Их Эзэн Есүс Христ [Иосеф, Оливер хоёрт үзэгдэв.] . . . Мосе, Елиас, Елиа нар мөн [Көртландын ариун сүмд] үзэгдэн, Иосефт [санваарын түлхүүрүүдийг өгсөн] (С ба Г 110).

Бидний дагах загвар

Ах, эгч нар аа, бид загварыг олж харж байна уу? Анхны үзэгдэл, Моронайн айлчлал, Мормоны Номын ирэлт, санваарын сэргээлт, Есүс Христ Өөрийн ариун сүмд үзэгдсэн гэх мэт Сэргээлттэй холбоотой чухал үйл явдал бүр залбирлаар эхэлсэн. . . .

[Олон удаа] би сэргээгдсэн сайн мэдээ үнэн гэсэн Бурханы Сүнсний үгүйсгэхийн аргагүй гэрчийг цээжин дотроо шатаж буй гал мэт мэдэрсэн. . . . [Хэрэв та нар эдгээр зүйлийг өөрсдөө мэдэхгүй байгаа бол,] Мормоны Номон дахь Моронайн: “Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно. Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” гэсэн урилгыг хүлээн авахыг би та нарт зөвлөж байна (Моронай 10:4–5). . . .

. . . Иосеф Смитийн үлгэр жишээ болон Сэргээлтийн загварыг дага. Судруудад ханд. Өвдөг сөгдөн залбир. Итгэлтэйгээр асуу. Ариун Сүнсийг сонс. . . . Мөн “Хэрэв та нар . . . [Их Эзэний] зарлигуудыг дагахад хичээнгүйлэн, мөн та нар хүлээн авна гэдэгтээ найдсаар, мөн [Тэнгэрлэг Эцэгээс] итгэлтэйгээр асуух аваас, эдгээр зүйлүүд та нарт лавтайяа мэдүүлэгдэх болно” гэдгийг би Есүс Христийн нэрээр амлаж байна (1 Нифай 15:11). ■

2003 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

ВОЛТЕР РЭЙНИЙ ЕСҮС ХРИСТ БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТ БОЛОН ОЛИВЕР КАУДЕРИД ҮЗЭГДСЭН НЬ БҮТЭЭЛЭЭС; *МЕЛКИЗЕДЕК САНВААРЫГ СЭРГЭЭСЭН НЬ*, ВОЛТЭР РЭЙН

ЮУ, ЯАГААД, ХЭРХЭН:

СЭРГЭЭЛТИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХҮЙ

Фэйт Садерлин Блакхөрст
Сүмийн сэтгүүл

Та далайн эрэг рүү найзынхаа гэр бүлийнхэнтэй хамт долоо хоногийн аялалд явлаа гэж бод. Үнэхээр хөгжилтэй байсан ч та гэр бүлээ санаж эхэлсэн. Тэр үед аав тань танаас ямархуу байгааг асууж мессеж бичихэд танд яг иймэрхүү зүйл буюу хайрладаг, санадаг гэдгийг нь мэдрэх хэрэгтэй байсан.

Дэлхийн амьдрал үүнтэй зарим талаараа төстэй. Бурхан бидэнд мессеж явуулдаггүй ч бид тэнгэрлэг гэрээсээ хол байгаа тул Тэнгэрлэг Эцэг бошиглогчдыг илгээн, Өөрийн хайрыг харуулдаг.

ЭРИН ҮЕ

Бошиглогчид *эрин үе* хэмээгддэг цаг үеийг, (1) Бурхан дэлхий дээр дор хаяж нэг итгэмжлэгдсэн удирдагчтай байдаг, (2) энэ удирдагч буюу бошиглогч нь авралын төлөвлөгөөний талаар Бурханаас шууд суралцдаг хэсэг цаг үеийг удирддаг. Бошиглогч дараа нь сайн мэдээг хүмүүст зааж, *түгээдэг.*

Судруудын ачаар бид олон эрин үеийн тухай мэднэ. Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе, Есүс Христ болон Иосеф Смитийн үед зарим чухал эрин үе байсан. Их Эзэн эдгээр бошиглогч тус бүрээр дамжуулан эрин үеийг эхлүүлсэн.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭН СИМОНСЭН

Сайн мэдээг заахын тулд танд урвалт, эрин үе, Сэргээлт гэж юу болохыг тайлбарлах хэрэг гарна. Харин энэ хүснэгт танд тусална.

УРВАЛТ

Урвалт=ёс бус явдал. Хувь хүн эсвэл бүлэг хүн Есүс Христийн сайн мэдээний үнэнээс нүүр буруулж, бошиглогчдыг үл тоомсорлон, нүгэл үйлдэж эхэлбэл урвалтад орсон гэсэн үг.

СЭРГЭЭЛТ

Сэргээлт гэж ямар нэгэн зүйлийг анхны байдалд нь эргүүлэн, буцааж авчрах үйлдлийг хэлнэ. Энэ нь ямар нэгэн шинэ зүйлийг бий болгохын тулд өмнө байсан зүйлийг өөрчилдөг шинэчлэлт биш юм. Жишээлбэл, та хуучин байшинг сэргээн засварлахыг хүсвэл өмнөх зураг төслийнх нь дагуу барина. Харин шинэ задгай зуух нэмэхийг хүсвэл байшинг сэргээх биш, харин өөрчилж байгаа хэрэг.

Есүс Христийн сайн мэдээ Их урвалтын үед алдагдсан байсан тул үүнийг сэргээх шаардлагатай байв. Хүмүүс олон зууны туршид үнэн Сүмгүйгээр амьдарсан. Тиймээс Их Эзэн Өөрийн Сүм болон сайн мэдээг эртний бошиглогчдын бошиглосноор Иосеф Смитээр дамжуулан *сэргээсэн* (Исаиа 2:1–3; 29:13–14; Үйлс 3:19–21; Илчлэлт 14:6–7; 2 Нифай 3:3–15-ыг үзнэ үү).

Есүс Христийн үнэн сайн мэдээ үргэлж энд байх тул та сайн мэдээтэй хамт байх уу? Хэдийгээр дэлхий ертөнц улам бүр ёс бус болсоор байгаа ч Есүс Христийн Сүм эцсийг хүртэл орших болно.

Танд цагийн эхлэлээс мөнх бус хүмүүний хийсээр ирсэн тэр сонголтыг хийх хэрэг гарна. Тухайлбал: Та бошиглогчийг дагах уу? Хэрэв та дагавал адислагдан, Ариун Сүнсээр удирдуулах болно.

ЭРИН ҮЕҮДИЙН УДИРДАГЧИД

Эдгээр бошиглогчийг “тэдний үлэмжийн итгэл хийгээд сайн үйлүүдээс үндэслэн” Бурхан дууддаг (Алма 13:3 мөн Абрахам 3:22–23-ыг үзнэ үү). Бошиглогч Иосеф Смит тэдний атгадаг байсан санваарын түлхүүрүүдийг сэргээсэн. Эдгээр бошиглогчийн талаар хэдэн сонирхолтой зүйл хуваалцъя. Судраас судалж байхдаа тэдний талаар өөр юуг олж мэдэх боломжтой болохыг олж харна уу.

АДАМ

Адам бол жинхэнэ анхдагч байсан. Тэр энэ дэлхийн анхны хүн мөн анхны бошиглогч байсан. Тэрээр сайн мэдээг гэр бүлдээ заасан боловч бүр эхнээс нь олон хүн “мөн харанхуйд тэд өөрсдийн зөвлөгөөг эрэлхийлсэн” бөгөөд үнэнээс нүүр буруулсан юм (Мосе 6:28).

ЕНОХ

Та нар бүхэл бүтэн хот тэнгэрт дээш аваачигдсан гэдгийг өмнө нь сонсож байсан уу? Енохын байгуулсан Сион хотынхон зөв шударга байсан учраас Бурхантай хамт амьдардаг байжээ (Мосе 7:23-ыг үзнэ үү).

НОА

Та Ноагийн хөвөгч авдрын талаар мэднэ. Зөвхөн Ноагийн гэр бүлийн 8 хүн Ноагийн анхааруулгыг сонссон учраас үерээс амьд үлдсэн (Эхлэл 7; Мосе 8-ыг үзнэ үү). Гэхдээ тэр 10 настай байхдаа санваар хүлээн авсныг (С ба Г 107:52-ыг үзнэ үү) мөн “аварга хүмүүс... Ноаг амь насыг нь бүрэлгэхээр [эрэлхийлснийг]” (Мосе 8:18) мэдэх үү?

АБРАХАМ

Ёс бус санваартнууд Абрахамыг золиослох гэж байхад тэнгэр элч түүнийг аварсан (Абрахам 1-ийг үзнэ үү). Тэр гайхамшигтай илчлэлтүүдийг хүлээн авч, тэр дундаа мөнх бус байдлын өмнөх амьдралыг үзэгдэлд харсан. Сүмийн гишүүд түүний үр удам бөгөөд Абрахамын гэрээг түүний нэрээр нэрлэжээ. (Абрахам 2–5-ыг үзнэ үү.)

МОСЕ

Тэрээр израильчуудыг Египетээс удирдан гаргаж, эрх чөлөөтэй болоход тусалсан. Тэр “тэд Бурханы нүүрийг болгоож болохын тулд өөрийн хүмүүсийг ариусгахын тулд хичээнгүйлэн эрэлхийлдэг байлаа; гэвч тэд зүрх сэтгэлээ хатууруулж мөн түүний оршихуйг тэвчиж чаддаггүй байв” (С ба Г 84:23–24). Үнэн хэрэгтээ тэд урвалтаасаа болж цөлд 40 жил тэнүүчилсэн билээ!

ЕСҮС ХРИСТ

Есүс Христ сайн мэдээг зааж, гайхамшгуудыг үзүүлэхийн зэрэгцээ дэлхий дээр Өөрийн сүмийг байгуулсан. Тэр бидний гэм нүглийг цагаатгаж, цовдлуулж мөн амилсан нь бидэнд сүнслэг болон бие махбодын үхлийг ялан дийлэх боломжийг олгосон юм. Өнөөдөр Тэрээр Сүмийнхээ тэргүүн нь бөгөөд Тэнгэрлэг Эцэгтэй хамт хоёулаа санваарын эрх мэдлийн эх сурвалж мөн.

ИХ УРВАЛТ

Аврагчийг амилсны дараа Түүний төлөөлөгчид болон Сүмийн бусад удирдагч сайн мэдээг түгээхийг хичээсэн боловч хүмүүс тэдний сургаалаас татгалзаж, тэр ч бүү хэл маш олон төлөөлөгчийг алжээ. Хүмүүсийн энэ ёс бус байдлаас болж сайн мэдээний бүрэн байдал дэлхийгээс авагдсан юм. Дэлхий сүнслэг харанхуйд автав (Исаиа 60:2-ыг үзнэ үү).

- 1000 гаруй жилийн турш хүмүүс авралын ёслол, ариун сүмийн адислал, бошиглогчдын удирдамжийг хүлээн авах боломжгүй болсон.
- Эрхэм үнэт үнэнүүд Библиэс алдагдсан.
- Бурханы жинхэнэ мөн чанарын тухай худал хуурмаг үзэл санаануудыг зааж байв.
- Авралын зарим ёслолыг өөрчилж эсвэл буруу зааж байжээ (Исаиа 24:5-ыг үзнэ үү).
- Энэ урвалт нь яваандаа олон сүм үүсэхэд хүргэсэн юм.

ШИНЭЧЛЭЛТ

Их урвалтын үеэр Европт байсан шашны зарим номлогч Есүс Христийн сайн мэдээг буруу зааж байгааг ойлгосон юм. Энэ шинэчлэгчид бошиглогчид байгаагүй ч үнэнийг өөрсдийн ойлголтоор заахыг чадлаараа хичээсэн. Тэд Библийг олон хүнд хүртээлтэй болгосон бөгөөд тэдний дундаас олон хүн шашны эрх чөлөөний төлөө тэмцэж, сайн мэдээний Сэргээлтэд замыг нь нээж өгсөн.

ИОСЕФ СМИТ

Тэгэхээр сайн мэдээний бүрэн байдал үүрд алдагдсан байсан уу? Үгүй ээ! Бурхан Иосеф Смитэд чухал үнэнүүдийг дахин илчилсэн. Тэнгэрлэг элчүүд санваарын бүх шаардлагатай түлхүүрийг түүнд сэргээн өгч (С ба Г 27:8–13; 110; 128:18–21-ийг үзнэ үү), энэ үеийг "цаг хугацааны бүрэн байдлын эрин үе" (С ба Г 138:48) болгосон. Энэ нь Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн өмнөх сүүлчийн эрин үе тул үүнийг бас хожмын өдрүүд хэмээн нэрлэдэг.

СЭРГЭЭЛТ

Юу болсныг таа даа? ТАНД Сэргээлтийн адислалууд байгаа. Тийм ээ, танд бий!

- Есүс Христийн Сүм бошиглогч, төлөөлөгчдөөр удирдуулагдахаар сэргээгдсэн юм.
- Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд болон бусад орчин цагийн илчлэлтэд алдагдсан байсан эрхэм үнэт үнэнийг сэргээсэн (2 Нифай 27-г үзнэ үү).
- Иосеф Смит Иохан Баптистаас Аароны санваарыг (С ба Г 13-ыг үзнэ үү) Петр, Иаков, Иохан нараас Мелкиседек санваарыг (С ба Г128:20-ийг үзнэ үү) тус тус хүлээн авсан.
- Итгэмжлэгдсэн санваартнууд авралын ёслолуудыг зохих ёсоор хийж гүйцэтгэдэг.
- Үнэнийг дахин хэзээ ч урвалтаар алдахгүй гэдгийг бид мэднэ (Даниел 2:44-ийг үзнэ үү). ■

Та Есүс Христийн талаар ойлгож мэдсэнээр Түүний амар амгалан болон оршихуйг амьдралдаа урин авчирдаг.

Сара Хэнсон

Аврагчийн талаарх *бүх зүйлийг* Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд гэх судруудаас уншиж байна гэж төсөөлөн бод доо. Ямар их цаг хугацаа, хөдөлмөр шаардагдах бол! Гэхдээ 2017 оны 1-р сард Рассэлл М.Нэлсон бидэнд яг үүнийг хийх буюу жишиг бүтээлүүд дэх Есүсийн хэлсэн, хийсэн бүх зүйлийг судлахыг уриалсан. Энэ төслийг хийж дуусгасан нь түүнийг “өөр хүн” болгосон гэж ерөнхийлөгч Нэлсон хэлсэн билээ. Тэрээр Есүс Христийн тухай илүү ихийг ойлгож мэдээд зогсохгүй Түүнд итгэх сүсэг бишрэлээ шинэчилсэн гэдгээ мэдэрчээ.[1]

Та ч мөн адил Христийн талаар ойлгож мэдсэнээр Түүнтэй илүү ойртох боломжтой. Та Христийн амьдрал, зорилгыг судалснаар амар амгаланг амьдралдаа урин авчрах ба энэ нь Түүнийг болон Тэнгэрлэг Эцэгийг танин мэдэхэд тусална. Эдгээр өсвөр үеийнхэн дараах хоёр асуултад хэрхэн хариулсныг үзнэ үү. (1) Танд Аврагчийн тухай ямар дуртай судрын түүх байдаг вэ мөн яагаад? (2) Түүнчлэн сайн мэдээнээс судлах нь хэрхэн танд амар амгаланг авчирсан бэ?

ЛИЗ ЛЕМОН СВИНДЛИЙН БУСАД ЕС НЬ ХААНА БАЙНА ЗУРГИЙН ХЭСГЭЭС

АВРАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НЬ

Би уяман өвчтэй арван хүний түүхэнд дуртай. Учир нь Христ Өөрт нь талархсан уяман өвчтэй нэгэн хүнийг асар их хайрласан. Тэрээр "Итгэл чинь чамайг эдгээлээ" (Лук 17:19; шүлэг 11–19-ийг үзнэ үү) хэмээсэн байдаг. Түүний хүн бүрд үнэхээр нинжин сэтгэлээр хандлаг байсанд би дуртай.

Сургуульд маань саяхан тохиолдсон зарим эмгэнэлт үйл явдлын улмаас хүн бүрд туйлын их амар амгалан, тайтгарал хэрэгтэй байгаа. Би семинарт суралцсанаар хүч чадал, амар амгаланг олж авсан. Семинарын багш нар судрууд болон сайн мэдээг хүн бүрийн онцлогт тааруулан заадаг. Семинарын анги, жирийн анги хоёрыг харьцуулахад эрс ялгаатай байгааг олж харах үнэхээр сайхан. Тэнд амар амгаланг авчирдаг тэс өөр мэдрэмж төрдөг.

Габриел С., 16 настай, АНУ, Колорадо

Итгэл болон Бурханы үгийн тухай Алмагийн түүх (Алма 32:18–43-ыг үзнэ үү) бид хайрыг таривал хайрыг хүлээн авдаг гэдгийг надад заасан. Алмагийн зорамчуудад тайлбарласнаар итгэл нь үртэй адил юм. Энэ нь ямар нэгэн зүйлийг өөрийн биеэр хараагүй ч үнэн гэдэгт итгэхийг хэлдэг. Хүн Бурханы үгэнд итгэж, сонсох хүсэлтэй байх үед итгэл нь өсдөг. Энэ бүхэн намайг тайван байж, зүрх сэтгэлээ хүчирхэгжүүлэн, Тэнгэрлэг Эцэг намайг хайрладаг мөн надад нигүүлсэнгүй ханддаг гэсэн гэрчлэлийг олж авахад тусалсан.

Би өдөр бүр судраас судалснаар бидний хүн нэг бүрийн төлөөх Аврагчийнхаа хайрыг илүү сайн ойлгодог. Энэ мэдлэг нь асуудалтай тулгарах үедээ тэд ганцаараа биш, яагаад гэвэл биднийг хайрладаг Бурхан бий гэдгийг сургуулийнхаа найзуудад тайлбарлахад надад тусалдаг.

Мариа Д., 17 настай, Испани, Гуадалахара

Би Аврагч Америк тивд айлчлан ирж, хүүхдүүдийг Өөр рүү нь ирэхэд урьдаг 3 Нифай 17 дахь хэсэгт дуртай. Тэр тэдэнтэй хамт сууж, хүн нэг бүртэй цагийг хамт өнгөрүүлдэг. Энэхүү гайхалтай түүх надад Есүс Христ гэж хэн болох, Тэрээр бидний хүн нэг бүрийг ямар их хайрладаг болохыг харуулдаг.

ДЭЛ ПАРСОНЫ *ХРИСТ БА МОРМОНЫ НОМЫН ХҮҮХДҮҮД* ЗУРГИЙН ХЭСГЭЭС

ХЭЙНРИХ ХОФФМАНЫ *"ХРИСТ БА БАЯН ЗАЛУУ ЭР"*

Түүний тусламж хэрэгтэй үед ч гэсэнТэрээр бидний хүн нэг бүрийн хажууд сууж байдаг гэдэгт би итгэдэг.

Энэ жил би судраас өдөр бүр нэг хуудас уншина гэж өөртөө амласан. Харин би ийнхүү хийснээр өдөр бүр уншихыг хүсэн хүлээдэг болсон юм. Би цаг зав гарган судруудын үгс болон түүхийг ойлгохыг хичээснээр илүү ихийг сурч мэдсэн бөгөөд Тэнгэрлэг Эцэг болон Аврагчийнхаа талаар сурч мэдсэнээр Тэдэнтэй илүү ойр байх болсон билээ. Энэ нь миний амьдралыг үнэхээр амар амгалан болгосон.

Анна К., 17 настай, АНУ, Монтана

Христ Америк тивд ирээд, тэдний дунд өвчтэй, зовж зүдэрсэн хүмүүс байгаа эсэхийг асууж, тэднийг эдгээдэг. Дараа нь тэр бяцхан хүүхдүүдийг адисалсан. (3 Нифай 17-г үзнэ үү.) Үүнийг би үнэхээр сэтгэл уярам, хүчирхэг түүх гэж боддог. Би бяцхан хүүхдүүдэд хайртай. Хүүхдүүд цэвэр ариун тул хүмүүс тэднийг илүү ихээр хайрлаж байгаад би дуртай. Энэ түүх Аврагчийн бидний төлөөх хайр ямар гүн гүнзгий болохыг надад харуулдаг. Тухайн үед Тэрээр хийе гэсэн зүйлээ бүгдийг нь хийхүйц хангалттай их хайраар хүмүүсийг хайрлаж чадсан учраас өнөөдөр ч гэсэн биднийг хайрлаж чадна.

Исаиа 53:3-т Аврагч бол "уй гашуугийн хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн" хэмээсэн байдаг. Би Христийн Цагаатгалыг болон бидний төлөө туулсан бүхнийг мөн нүглээ наманчилбал хэрхэн өршөөгдөж болох талаар бодох үед үнэхээр амар амгаланг мэдэрдэг. Мормоны Номд гардаг Мозаягийн хөвгүүд, Аммон, Залуу Алма гээд олон хүн өмнө нь алдаа гаргаж байсан ч өршөөгдсөн. Тэд Христэд хандан, наманчилж, өнөөдөр бидний суралцаж болох гайхалтай үлгэр жишээ болж чадсан. Би ч гэсэн өршөөгдөх боломжтой гэдгийг мэдэх нь надад амар амгаланг авчирдаг.

Алина Т., 18 настай, АНУ, Орегон

Есүс нэгэн хуримын үеэр ээжийнхээ хүссэнээр усыг дарс болгон хувиргадаг тухай түүх миний хамгийн дуртай судрын түүх юм. Есүс эмэгтэйчүүдийг, тэр тусмаа ээжийгээ хүндэлдэг гэдгээ харуулсан учраас би энэ түүхэнд дуртай (Иохан 2:1–11-ийг үзнэ үү). Энэ түүх хүүхдүүдийг эцэг эхээсээ айснаасаа биш, харин хэмжээлшгүй их хайрладаг болохоор тэдэнд дуулгавартай байхыг урамшуулдаг. Есүс Христийн үлгэр жишээг хүн бүр дагахыг эрэлхийлэх ёстой. Эхийгээ гэх Түүний хайр хэзээ ч дундраагүй бөгөөд эцэг эхээ хайрлах бидний хайр ч бас дундрах ёсгүй. Энэ ч бас миний дуртай судрын хэсэг юм. Түүний үйлдсэн гайхамшиг үйлчлэл байсан бөгөөд бид ч бас бусдад туслан гайхамшгийг бүтээж чадна.

Судруудад байдаг энэ болон бусад түүх надад амар амгаланг авчирсан. Хэрэв би Христээс суралцаж, Түүний сургаалуудыг дагахыг үргэлж хичээх юм бол нэгэн өдөр



ТҮҮНД АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛ

“Бидний анхаарал Аврагчид болон Түүний сайн мэдээнд бат бэхлэгдсэн байх ёстой. Санаа бодол *бүрдээ* Түүн рүү харахын тулд оюун санаагаараа нэлээн хичээл зүтгэл гаргах ёстой байдаг. Гэхдээ ийнхүү үйлдсэн үед эргэлзээ, айдас маань арилдаг юм.”

Рассэлл М.Нэлсон, “Христийн хүчийг амьдралдаа татан авах нь,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

хайртай Тэнгэрлэг Эцэг рүүгээ эргэн очиж чадна гэдгээ мэдэх үнэхээр сайхан.

Энн Р., 17 настай, Австрали, Виктория

Би Христ болон баян залуу эрийн түүхэнд (Марк 10:17–22-ыг үзнэ үү) дуртай. Энэ нь Бурханыг бүхний түрүүнд тавих талаар ихээхэн ойлголт, төсөөллийг надад өгдөг. Дэлхийн өмч хөрөнгөө нэг бүрчлэн бүгдийг зарахыг хүсэх нь бараг хүн бүрд биелүүлэхэд хүндхэн хүсэлт байх болов уу. Гэхдээ Бурханыг өмч хөрөнгөнөөсөө дээгүүр тавина гэдэг нь бидний хүн нэг бүрийн энэ амьдралдаа суралцах ёстой зүйлсийн нэг гэж би боддог. Есүс Христийн биднийг гэсэн хязгааргүй хайр үнэхээр гайхамшигтай. Энэ нь амьдралдаа олж авч болох ямар ч мөнгө хөрөнгө, эд зүйлсээс илүү гэдэг нь тодорхой.

Судраас унших нь надад амар амгаланг өгч, тайтгаруулахаас гадна илүү их мэргэн ухаан, ойлголтыг авчирдаг. Хэдийгээр би судраас судлахын хүчийг үргэлж мэдрэх боломжгүй байж болох ч судар унших нь миний амьдралд эергээр нөлөөлж, Сүнсийг мэдэрч, Түүний өдөөлтийг танин мэдэхэд тусалдаг гэдгийг мэднэ.

Ючень Ч., 19 настай, Тайвань, Тайжун

Христ үхлүүт байсан жаахан охин дээр очихоор явж байтал цус алддаг өвчтэй нэгэн эмэгтэй Түүний хувцсанд дөнгөж хүрээд, эдгэрдэг. Христ тэр эмэгтэйг Өөрт нь хүрснийг мэдрээд, эргэн харж, түүнтэй ярьдаг (Лук 8:43–48-ыг үзнэ үү). Өөр хүнд туслахаар явж байсан хэдий ч Христ тэр эмэгтэйд цаг гаргасан. Христ бидний хүн нэг бүрд ч бас цаг гаргадаг.

Би сургуульд явж, балетын хичээл авч эсвэл өөр ажил төрөл гээд тун завгүй байдаг. Энэ бүгдийг хийх гэсээр байгаад надад ганцаар байх эсвэл амар амгаланг мэдрэх цаг зав гардаггүй. Би судраа унших юмуу залбирах үедээ л амар амгаланг мэдэрдэг. Үүнийг мэдрэх нь бас завгүй амьдралаасаа завсарлага авах нь сайхан байдаг. Би амар амгаланг мэдрэх мөчүүддээ Аврагчид илүү ойртон, сайн мэдээнд өсөж хөгждөг.

Зои Б., 17 настай, АНУ, Юта

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Рассэлл М.Нэлсон, “Бошиглогчид ба удирдлага мөн тэнгэрлэг хууль” (Залуучуудад зориулсан дэлхий дахины онцгой цугларалт, 2017 оны 1-р сарын 8), broadcasts.lds.org; “Есүс Христийн хүчийг амьдралдаа татан авах нь,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган; “Аврагчийн үгээс суралц,” *Лиахона,* 2018 оны 1-р сар, 56–59-ийг тус тус үзнэ үү.

ХАЙДИ ДЭЙНИС ДАРЛИГИЙН ХРИСТИЙН ХУВЦАСНЫ ХОРМОЙД НЭГЭН ЭМЭГТЭЙ ХҮРСЭН НЬ ЗУРГИЙН ХЭСЭГЭЭС

Сэргээлт миний хувьд ямар утга учиртай вэ?

Сүмийн сэргээлт 1820 онд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр ирснээр эхэлсэн. Үүний дараа Есүс Христийн Сүмийг дэлхий дээр буцаан авчрах бусад чухал зүйл болж өнгөрсөн. Эдгээр картыг уншиж, хайчлан, цаасан дээр наагаад, ижилсүүлэх тоглоом болгон тоглоорой.



Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ Иосеф Смитэд үзэгдсэн . . .

. . . учир би Тэднийг надтай адил бие махбодтой гэдгийг мэднэ.

Иосеф Смит алтан ялтаснуудыг орчуулсан . . .

. . . учир Би Мормоны Номыг уншиж чадна.

Иохан Баптист Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Аароны санваар хүртээсэн . . .

. . . учир би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэх боломжтой болсон.

Петр, Иаков, Иохан нар Мелкиседек санваарыг сэргээсэн . . .

. . . учир би Ариун Сүнсний бэлэг авч чадна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ КОФОРД

Сүм 1830 оны 4-р сарын 6-нд байгуулагдсан . . .

. . . учир би сүмд явж чадна.

Эмма Смит Сүмийн анхны дууллын номын дуунуудыг цуглуулсан . . .

. . . учир би дууллуудыг дуулах боломжтой.



Көртландын ариун сүмд Елиа Иосеф Смитэд гэр бүлүүдийг лацдан холбох түлхүүрийг өгсөн . . .



. . . учир би гэр бүлийн түүхээ хийж, ариун сүм рүү очиж чадна.

Их Эзэн анхны гэгээнтнүүдэд аравны нэгийн өргөлийг орлогынхоо 10 хувиар төлөхийг зарлигласан . . .

. . . учир би аравны нэг, мацгийн өргөлөө өгөх боломжтой.

Авреліа Рожерс хөршүүдийнхээ хүүхдүүдэд заахын тулд Хүүхдийн хэсгийн холбоог эхлүүлсэн . . .

. . . учир би Хүүхдийн хэсэгт явж чадна.

"Есүс бол Христ, бидний Гэтэлгэгч бөгөөд Аврагч мөн болохыг Түүний үйлчлэгчдийн нэгний хувьд би гэрчилж байна. Тэр амьд бөгөөд бид Түүний эрхэм их нигүүлслээс бүгд хүртэх боломжтой гэдгийг би мэднэ."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга
Ахлагч Дэвид А.Бэднар

"The Tender Mercies of the Lord," Liahona, *2005 оны 5-р сар, х. 99-өөс авав.*

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТАЙЯ МОРЛИЙ

Гайхамшигтай сургамж

Далын ахлагч
Ахлагч Валэри В.Кордон

"Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах [болно]" (Малахи 3:10).

Намайг Гватемалд өсөж торниж байхад гэр бүл маань спортын багийн өмсгөл хийдэг үйлдвэртэй байлаа.

Аав минь хүүхдүүдээ шаргуу хөдөлмөрлөж сураасай гэж хүсдэг байсан бөгөөд бид үйлдвэрийн ажилд нь түүнд тусалдаг байсан юм. Би бага байхдаа асуудалд их орооцолддог, байнга л юм эвдэлж хэмхэлдэг хүүхэд байв. Гэвч намайг арай том болоход аав минь нэхмэлийн машинуудаа надад хариуцуулсан юм.

Аав бидэнд хийсэн ажлын маань хөлсийг өгдөг байсан. Тэгээд түүнийг "Энэ мөнгөөрөө чи юу хийх гэж байна даа?" гэж асуухад "Аравны нэгээ төлөөд, номлолдоо мөнгө хадгална" гэж хариулах нь зөв хариулт болохыг би мэддэг байв.

Намайг 13 орчим настай байхад манай бизнес ихээхэн алдагдалд орсон юм. Бид олон оёдлын машинаасаа салж, хоёр зуун ажилтны оронд таваас бага ажилтантай болов. Тэд манай гэрийн гараашид ажилладаг байлаа.

Би аравны нэгээ үргэлж төлдөг байсан ч энэ нь ямар чухал болохыг бүрэн дүүрэн ойлгодоггүй байсан юм. Тэгтэл би нэгэн гайхалтай сургамж олж авч билээ. Нэгэн бямба гаргийн өглөө би аав, ээж хоёрыгоо аярхан ярьж байгааг сонсов. Аав минь ээжид нэг бол аравны нэгээ төлөх эсвэл хоол хүнс авахад хүрэлцэх л мөнгө байгаа бөгөөд хоёуланд нь хүрэхгүй болохыг хэллээ. Миний санаа зовнив. Аав минь алийг нь сонгох бол?

Ням гарагт би аавыгаа салбарын ерөнхийлөгчид дугтуй өгч байхыг олж харав. Тэр аравны нэгээ төлөхийг сонгосон байлаа! Би баяртай байсан ч санаа зовнисон хэвээр байв. Бид юу идэх билээ?

Маргааш нь өглөөгүүр хэдэн хүн манай хаалгыг тогшлоо. Тэд дүрэмт хувцас тэр даруй, яаралтай хэрэгтэй байгаа гэдгээ аавд хэлэв. Хүмүүс ихэнхдээ захиалга бэлэн болсны дараа л бидэнд төлбөрөө хийдэг байсан юм. Гэвч тэр хүмүүс манай аавд яг тэр өдрөө, дүрэмт хувцас хийж өгөхөөс бүр өмнө нь төлбөрөө хийв.

Ийнхүү би нэгэн амралтын өдөр амьдралынхаа туршид дурсагдах сайхан сургамжийг олж авч билээ. Аравны нэгийн хууль биднийг итгэлээ хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэгтээ баярлаж талархаж байгаагаа үзүүлэхэд тусалдаг. Аравны нэгийг төлөх нь адислал мөн. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАНДОН ДОРМАН

Абуелогийн гутал засварын газар

Рэй Голдрап
Бодит түүхээс сэдэвлэв

"Намайг уучлаарай гэж хэлэх үргэлж амар байдаггүй" (Children's Songbook, *98*).

Мигель Абуелогийнхоо (өвөөгийнхөө) гутал засварын газрын хаалгыг онгойлгов. Түүнд Абуелогийн боловсруулж байсан арьсны үнэр үнэртлээ. Энэ нь түүний дуртай үнэрүүдийн нэг байв.

"Сайн уу, Абуело?"

Абуело өвдөглөж суугаад, үйлчлүүлэгчийн хөлийн хэвийг цаасан дээр буулгаж байлаа. Тэр өндийж харсан ч үгүй. Абуелогийн сонсгол тийм ч сайн биш л дээ.

Мигель ажлын ширээний дэргэд суулаа. Тэр давхарлан тавьсан зүссэн арьсыг хараад, Абуелог алх, бахь зэргээ ашиглан, арьс бүрээр юу хийхийг төсөөлөн бодов.

Багажнууд өөр нэгэн дуртай зүйлийг нь Мигельд санууллаа. Мигелийг цэвэрлэгээнд туслах бүрд Абуело түүнд чихэр өгдөг байв.

Харин Мигель яг одоо өлсөж байлаа. Тэр асуулгүйгээр амттанг авч болохгүй гэдгийг мэдэж байсан ч Абуело нэг хэсэгтээ л завгүй байх шинжтэй харагдсан тул "Би хүлээх хэрэггүй байхаа" гэж бодлоо.

Мигель лангуун доор байсан чихрийн савыг авлаа. Чихрийн саванд түүний дуртай чихэрлэг, улаан чинжүүний нунтаар амталсан дүүрэн чихэр байв. Тагийг нь онгойлгоход Мигельд бага зэргийн эвгүй мэдрэмж төржээ. Гэвч чихэр тун амттай харагдсан болохоор тэр яаран нэгийг авч, амандаа хийлээ.

Тун удалгүй үйлчлүүлэгч явав. Абуело арьсны өөдсийг авч, усанд хийв. Ингэх нь арьсыг зөөлрүүлж, боловсруулахад амар болгодог байлаа.

Мигель дутуу идсэн чихрээ хурдхан гэгч идчихээд, Абуело руу дөхөж очлоо.

"Бид яг л энэ гутал шиг байх хэрэгтэй" гэж өвөө хэлэв.

"Сайн уу?" гэж Абуело инээмсэглээд, "Надтай уулзах гэж ирсэнд чинь би баяртай байна" гэлээ.

Мигель Абуелог тэврэв. Абуело түүнийг чихэр идсэнийг анзаарахгүй байгаасай гэж тэр дотроо найдаж байлаа. Мигель юу ч болоогүй мэт дүр үзүүлээд,

давхарлан тавьсан арьс шир руу заан, "Та өнөөдөр завгүй юм шиг байна. Танд тусламж хэрэгтэй юу?" гэж асуув.

Тэр "Тийм ээ! Надад тэр утсыг дөхүүлээд өгөөч?" гэв.

Мигель урт утсыг аваад, хоёр гараараа хоёр тийшээ угз татав. Утас харагдаж байгаагаасаа илүү бат бөх байлаа.

"Пөөх, ямар бөх юм бэ" гэхэд

Абуело инээд алдаж, "Тэгэлгүй яахав. Элэгдэл, нугалаас даахуйц бат бөх байх ёстой юм чинь" гэлээ. Абуело арьсан дундуур утсыг татан оруулав. Тэгтэл түүний царайд Мамагийн хааяа хэлдэгчлэн "цэцэн мэргэн Абуело"-гийн чухал төрх тодорч,

"Бид яг энэ гутал шиг байх хэрэгтэй" гэж толгой дохин хэллээ.

Мигель арьсыг ойртон харав. "Мм. Тийм гэж үү?" гэхэд

"Тийм ээ. Бид бат бөх, хүчтэй хэвээр байх хэрэгтэй. Тэгвэл Сатаны уруу таталт биднийг унагаахгүй" гэлээ.

Мигелийн толгойд улаан чихэр гэнэт орж ирэх нь тэр. Тэр энэ тухайгаа Абуелод хэлэх хэрэгтэй гэж мэдэж байв.

Абуело тавиураас хуучин гутлыг аваад, "Энэ том нүхийг харж байна уу?" гэв.

Тэр нүхээр Мигель гараа бараг бүхлээр нь оруулж болохоор байлаа. Тэр "Тийм ээ" гэв.

"Энэ нь нэгэн үед амархан засаж болох жижигхэн нүх байсан. Харин тэд засахгүй байзнасан тул одоо үүнийг засахад хэцүү болгосон байна. Муу зуршил, муу сонголтууд яг л энэ нүхтэй адил байдаг. Тэдгээрийг аль болох эрт засах нь зүйтэй" гэв.

Тэгснээ Абуело толгойгоо дахин дохиж, цэцэн мэргэн Абуело царай нь өөрчлөгдөн, инээмсэглэсэн юм. Абуелог ажиллаж байх зуур тэд хоорондоо ярьсаар л байв. Ийнхүү ярилцаж байх үед Мигель улаан чихрийн тухай бодсоор байлаа.

Абуелог ажлаа хийж дуусахад Мигель түүнд цэвэрлэгээ хийхэд нь туслав. Харин үүний дараа Абуело чихрийн саваа авлаа.

Сүүлдээ Мигель тэсэхээ байгаад, "Би таны чихрээс нэгийг авчихсан!" гэж хэлж орхив.

Абуело чихрийн саваа доош тавиад, "Чи юу гэсэн бэ?" гэлээ.

Мигель зөвшөөрөлгүйгээр чихэр авснаа түүнд хэлэв. "Абуело, намайг уучлаарай. Би дахиж тэгэхгүй, амлаж байна!" гэлээ.

Абуело Мигелийг чанга тэврэв. Мигельд *хамаагүй* дээр болох шиг санагдлаа.

"Шударга байсанд чинь баярлалаа. Энэ нь миний хувьд өөр бусад ямар ч зүйлээс илүү чухал зүйл юм" гэж хэлэв.

Гэр рүүгээ явж байхад нь Мигельд Абуелогийн шинэ гуталтай адил мэдрэмж төрсөн юм. Түүнд бат бөх бөгөөд амьдралд бэлэн байгаа мэт санагджээ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

САЙХАН МЭДРЭМЖ

Нэг өдөр би ээжтэйгээ хамт усны төлбөр төлөхөөр явав. Бидний өмнө байсан эрэгтэй санамсаргүй нэлээн их мөнгө унагаачихаад, үүнийгээ анзаарсангүй. Би яаран очиж, түүнд унагасан мөнгийг нь аваачиж өглөө. Тэр надад "Маш их баярлалаа" гэж хэлээд, өөр хүүхдүүд ингэхгүй байх гэж бодож байгаагаа хэлэв. Надад үүний дараа ямар сайхан санагдсан гээч! Би тэр сайхан мэдрэмжийг үргэлж санах болно.

Брианна К., 9 настай, АНУ, Айдахо

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД ВУ

Нинжин сэтгэлтэй бай!

Би бусдад нинжин сэтгэлээр хандсанаар гэрлээ гэрэлтүүлдэг.

Сайн уу?
Намайг Клаудиа гэдэг. Би Австралид амьдардаг.

Клаудиагийн ах Тайлэр

Би бусдыг хамгаалдаг

Манай ангийн нэг хөвгүүнд сургуульд сурахад их хэцүү байдаг. Хүмүүс түүнийг шоолох үед би өмөөрч, хэрэг гарвал хичээл хийхэд нь тусалдаг. Багш маань түүнийг ангийнхаа нэг хэсэг гэдгийг энэ жил л мэдэрч байна гэж хэлсэн.

Миний бяцхан тоглоомон бамбарууш

Багш маань нагац ахыгаа нас барахад маш их гунигтай байсан. Тэр Сүмийн тухай мэддэггүй байсан тул би түүнд Тэнгэрлэг Эцэг өөрт нь хайртай гэдгийг хэлсэн юм. Би түүнд ил захидал бичиж, түүнийг нагац ахтайгаа дахин уулзах болно гэж хэлэв. Түүнийг гашуудаж буй цаг үеэ даван туулахад нь туслахын тулд би онцгой бяцхан тоглоомон бамбаруушаа түүнд өгсөн.

Дуу ба Ариун Сүнс

Би *Хүүхдийн хэсгийн* дуунуудыг дуулах дуртай. Манай гэрийнхэн дуулах нь Ариун Сүнсийг мэдрэхэд тусалдаг гэж хэлсэн. Ариун Сүнс миний дотор халуун дулаан мэдрэмж төрүүлдэг.

Азтай найзууд

Манай хөрш айлын Оливиа явах, ярих, сонсохдоо тааруу бөгөөд ээж нь түүнд над шиг найзтай байгаа нь аз завшаантай хэрэг гэж хэлсэн. Би ч гэсэн азтай!

ЧИ ХЭРХЭН ГЭРЭЛТЭЖ БОЛОХ ВЭ?

Олон найзгүй хэн нэгэнтэй найзалдаг БАЙ.

Хөршдөө тусалж БАЙ.

Найзыгаа сүмд урьдаг БАЙ.

Дуулдаг БАЙ.

БИДЭНД ОД ИЛГЭЭНЭ ҮҮ!

Та Есүсийн биднээс хүссэнчлэн, гэрлээ хэрхэн гэрэлтүүлж чадах вэ? Түүх болон гэрэл зураг бүхий одныхоо зургийг эцэг эхийнхээ зөвшөөрлийн хамт э-мэйлээр liahona@ldschurch.org хаяг руу илгээгээрэй.

GETTY IMAGES-ИЙН УУТАТ БААВГАЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Кэл С., 8 настай, АНУ-ын Виржини

Би Тэнгэрлэг Эцэг залбиралд хариулдаг гэдгийг мэднэ. Манай гэр бүл Германд амьдарч байхдаа тосгоныхоо *Фолксмарш* хэмээх үйл ажиллагаанд оролцож билээ. *Фолксмарш* бол найз нөхөд, хөршүүд хамтдаа байгальд алхаж, цагаа өнгөрүүлдэг үйл ажиллагаа юм. Аав, ээж хоёр маань намайг найзуудынхаа хэн нэгэнтэй бүлгээсээ түрүүлээд алхаж болно гэсэн бөгөөд бид ч урт жим даган алхаж эхэллээ.

Хэдэн минутын дараа би гэрийнхнийхээ хэнийг нь ч олж харахгүй байв. Би найздаа жим дээрээ үлдэж, гэрийнхнээ хүлээнэ гэдгээ хэллээ. Удалгүй найз маань ч бас гэрийнхэнтэйгээ харагдахаа больж, аав ээж маань ч ирэхгүй байсаар байв. Би ойд орь ганцаараа үлдсэн тул айж, хэн нэгэн нь намайг олоосой гэж залбирахаар шийдэв.

Ойн нөгөө захад байсан аав минь Ариун Сүнсний "Явж хүүгээ ол" гэж хэлэхийг мэдэрчээ. Тэр надад ямар их хэрэгтэй байгаагаа мэдэрсэн тул шууд л эргэж явахаар шийдэн, ээжид намайг хайх гэж байгаагаа хэлсэн байна. Хэдэн минутын дараа аав минь миний хүлээж байсан жимээр гүйн ирж, намайг олсон юм. Би аавыгаа хараад, ямар их баярласан гээч! Надад тусламж хэрэгтэй байсныг хүчтэй мэдэрсэн гэдгээ ярихад нь Тэнгэрлэг Эцэг залбирлыг минь хариулсныг би ойлгосон.

Би хаана ч байсан Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьж болно гэдгийг олж мэдсэндээ үнэхээр их баярладаг. Тэр надад замаа олоход тусална. ■

Төөрөөд, олдсон нь

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ШЭЙДА АБВАБИ

БИДНИЙ ХУУДАС

Би баптисм хүртэхдээ айж сандарч байсан ч ус руу орохдоо баяр хөөр, аз жаргалыг ихээр мэдэрсэн.

Томас Б., 8 настай, Уругвай

Бага охин дүү Лаурагаа гэр бүлтэйгээ лацдан холбуулахын тулд бид Камбожоос Хятадын Хонконг ариун сүм рүү аялсан юм. Би тэр онцгой газарт Сүнсийг мэдэрсэн.

Роза П., 9 настай, Камбож

Нэгэн өдөр хичээл дээр бүх хүүхэд ширээний тоглоом тоглож байхад би чимээгүй уншиж байв. Хонх дуугарахад тэд тоглоомоо тавиур дээр чихэж, замбараагүй болгов. Намайг тэдгээрийг эмхэлж цэгцэлж эхлэхэд удалгүй бусад хүүхэд тусалж эхэлсэн. Би сайн үлгэр жишээ үзүүлснээр гэрлээ гэрэлтүүлсэн.

Винний В., 10 настай, Канад

Намайг найман нас хүрэхэд өвөө, эмээ, олон найз нөхөд маань миний баптисмд ирсэн. Аав надад баптисм хүртээж, намайг гишүүнээр баталсан. Дараа нь би өөрийнхөө 30 см үсийг хорт хавдартай хүүхдэд бэлэглэсэн. Төрсөн өдрөөрөө би маш их баярласан.

Лавона Р., 8 настай, Индонез

Иосеф Египет рүү худалдагдсан нь

Ким Вэбб Рэйд

Иосеф 11 ах дүүтэй байв. Аав нь түүнд өнгө алагласан гоёмсог хүрэм өгөв. Бурхан Иосефт ах нараа удирдах болно гэж хэлсэн байна.

Иосефын ах нар үүнд нь уурлаж байлаа. Тэд Иосефыг удирдагчаа болгохыг хүсэхгүй байв. Тэд түүнийг Египет рүү явж байсан хүмүүст зарж, боол болгожээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭПРИЛ СТОТТ

Иосеф шаргуу хөдөлмөрлөсөн. Хүмүүс түүний талаар худал ярьж, шоронд хийх үед ч тэр сайн сонголтуудыг хийж байв.



Хүнд хэцүү үед ч Иосеф Бурханд итгэж байсан ба Бурхан түүнтэй хамт байсан. Иосеф Египетийн удирдагч болсон шүү дээ! Тэр нас өндөр болоод, Бурханы хэлснээр гэр бүлээ удирдахад тусалсан.

Би Бурханд Иосефын нэгэн адил итгэж мөн зөвийг сонгож чадна. Юу ч болсон бай, Бурхан надтай хамт байх болно. ■

Эхлэл 37–41-ээс авав.

Есүс Христ "Ирээд, Намайг дага" гэж хэлсэн.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

АМИЛАЛТЫН БОДИТ БАЙДАЛ

Есүс Христ бол чухамдаа бүх хүн төрөлхтнийг авралд хүргэж болох цорын ганц нэр бөгөөд зам мөн.

Назарын Есүсийн бүхий л үнэн төрх байдал, философийн том маргааны талаар болон амьдралын асуултуудад хариулсан амилалтын ач холбогдлын талаар түр тунгаан бодоод үзээрэй. Хэрэв Есүс үнэхээр амилсан л юм бол энэ нь Түүнийг бурханлаг биетэй гэдгийг зайлшгүй нотолно. Ямар ч мөнх бус бие үхсэний дараа өөрийгөө амилуулах хүчгүй. Есүс амилсан учраас ердийн нэг мужаан, багш, рабби эсвэл бошиглогч биш болж таарлаа. Тэр амилсан болохоор л Бурханы, бүр Эцэгийн Төрсөн Ганц Хүү байх учиртай.

Тиймээс Түүний заасан зүйлс үнэн бөгөөд Бурхан худлаа ярьдаггүй.

Тиймээс Түүний Өөрийнх нь хэлснээр Тэр бол дэлхийн Бүтээгч.

Тиймээс Түүний заасанчлан диваажин болон там нь үнэн бодитой юм.

Тиймээс сүнснүүдийн ертөнц гэж байдаг. Тэр нас барсныхаа дараа тэнд зочилсон.

Тиймээс тэнгэр элчүүдийн хэлснээр Тэр дахин ирж, "дэлхий дээр өөрийн биеэр хаанчлах болно" [Итгэлийн тунхаг 1:10].

Тиймээс бүх хүний хувьд амилуулалт болоод эцсийн шүүлт байх болно.

Христийн амилалт үнэн бодитой учраас дэлхийн гэтэлгэлийн төлөө Өөрийн Төрсөн Ганц Хүүг өгсөн Бурхан Эцэгийн хүч, мэдлэг, хайр энэрлийн талаарх аливаа эргэлзээ үндэсгүй юм. Амьдралын утга учир, зорилгын талаарх эргэлзээ ч утга учиргүй. Есүс Христ бол чухамдаа бүх хүн төрөлхтнийг авралд хүргэж болох цорын ганц нэр бөгөөд зам мөн. Нүглээ наманчлагч нүгэлтэнг өршөөж, цэвэршүүлдэг Христийн ач ивээл үнэн бодитой билээ. Үнэн итгэл бол ямар нэгэн төсөөллөөс эсвэл санаанаасаа зохиосон ямар нэг зүйлээс илүү чухал. Туйлын үнэн гэж байдаг. Түүний заасан бодит, хэзээ ч өөрчлөгдөшгүй ёс суртахууны жишиг гэж бас байдаг.

Христийн Амилалт үнэн бодитой учраас Түүний хууль, зарлигийг зөрчсөн л бол заавал наманчлах ёстой бөгөөд наманчлах боломжтой. Аврагчийн гайхамшгууд үнэн бөгөөд шавь нартаа та нар Миний адил зүйлийг хийх болно мөн бүр илүү агуу хийх болно гэж хэлсэн Түүний амлалт бодитой билээ. Түүний санваар нь үнэн бодитой хүч бөгөөд "сайн мэдээг удирдаж мөн хаант улсын нууцуудын түлхүүрийг, бүр Бурханы мэдлэгийн түлхүүрийг атгадаг болой. Тиймийн тул, үүний ёслолуудад бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг" (С ба Г 84:19). Христийн амилалт бодит учраас үхэл бидний төгсгөл биш бөгөөд "ялзрал нь [бидний бие махбодыг] устгаж болох ч [бид] махан [биеэрээ] Бурханыг харах болно" [Иов 19:26]. ■

2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЯХАЙРА РАМОС

МИНЕРВА ТЕЙЧЕРТ,
ХРИСТ НИФАЙЧУУД ДЭЭР АЙЛЧИЛСАН НЬ

*"Та нарын дунд өвчтөнүүд байна уу? . . . Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно. . . .
Мөнхүү улиран тохиох дор түүнийг тийн ярихад, бүх цугласан олон . . . өвчтэй мөн зовж зүдэрсэн, мөн доголон, мөн хараагүй, мөн хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг . . . эдгээв"* (3 Нифай 17:7, 9).

ӨСВӨР ҮЕИЙН БАГШ НАР

ЮУ, ЯАГААД, ХЭРХЭН: СЭРГЭЭЛТИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХҮЙ

Энэ ням гарагт урвалт, сэргээлтийн тухай ойлгоход амар хялбар болгоорой.

58

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ЖИНХЭНЭ АЗ ЖАРГАЛД ХҮРГЭХ 6 ЗАМ

46

ЭЦЭГ ЭХЧҮҮД БОЛОН ХҮҮХДИЙН ХЭСГИЙН УДИРДАГЧИД

ГЭР БҮЛИЙН ҮДЭШТ ЭСВЭЛ ХУВААЛЦАХ ЦАГТ ЗОРИУЛСАН СЭРГЭЭЛТИЙН ТУХАЙ ИЖИЛСҮҮЛЭХ ТОГЛООМ

66

MONGOLIAN
4 02147 50363 3

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ